



Унгар Улсын Элчин
сайдын Яам



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ



УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ХООРОНДЫН **ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Шинжлэх ухааны ажилтны өдөрт зориулан бүтээв.

Улаанбаатар хот

2025 он



УНГАР, МОНГОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

.....
Шинжлэх ухааны ажилтны өдөрт зориулан эмхэтгэсэн товхимол

АГУУЛГА

Элчин сайд Др.Обрущанский Борбала Аннагийн мэндчилгээ	3
ШУА-ийн Ерөнхийлөгч Содномсамбуугийн Дэмбэрэлийн мэндчилгээ	5
Фалуш Оршуё, Обрущанский Борбала “Монголын нууц товчоо” бол эрх зүйн түүхийн эх сурвалж	7
Дашзэвэг Амараа Бөөгийн оргой малгайн хэв загвар ба хүний хөрөг дүрийн урлахуйн онцлог	36
Омбоосүрэн Эрдэнэчимэг Монгол-Унгарын ШУА-ууд хооронд хэрэгжүүлж буй мобилити судалгааны төслийн тухай	49
Др.Хидан Чобо Ласло Морьтон нүүдэлчдийн ойрын зайн тулаан	53
Жофия Банфалви, Хонгорзул Одгэрэл, Эдина Чаквари, Жени Жосе, Михайл Кондрак Төмсний булцуу үүсэлт болон навчны хөгжлийн харилцан хамаарал	57
Кишш Роберт Рихард Төрийн хууль тогтоомж, төрийн байгууллагуудын талаарх унгарчуудын сэтгэгдэл	62
Телеки Кристина Монгол улс, хангайн нурууны шашны тархац	66
М.Лежак Габриэлла Төв Азиас Карпатын сав газар хүртэл Кунсаллаш-Фүлөпякобийн аварын үеийн язгууртны булш	68
Доржпүрэв Хатанбаатар, Жигжиджав Мөнхдэлгэр, Сахьяа Болормаа, Оюунчимэг Болормаа Ямаан усны хүннүгийн язгууртны булшны судалгаа	85
Гэндэнжамц Хишигбадам Халхын Хар Очир зайрангийн түүхэн дүр: бөөгийн зан үйл ба хууль эрх зүйн уялдаа	90
Шрамко Габор Монгол улс дахь Сибирийн тул (hucho taimen) загасны төрөл зүйлийн хамгааллын геномын судалгаа	97
Түмэндэмбэрэл Өлзийсайхан, Бямбадаш Сод-Эрдэнэ, Шрамко Габор, Батсүх Цэрэндулам Монгол орны ойн шийхнүүхэйн (anthus trivialis, linnaeus, 1758) филогенетикийн судалгаа	107

Эрхлэн гаргасан:

Улаанбаатар дахь Унгар Улсын Элчин сайдын яам

Эмхэтгэсэн: Элчин сайдын Нарийн бичгийн дарга Гэндэнжамцын Хишигбадам

Унгар хэлнээс монгол хэл рүү орчуулсан:

Др.Обрущанский Борбала Анна, Гүрдагвын Энхтөр

Хянан тохиолдуулсан: Гэндэнжамцын Хишигбадам, Бестерсей-Бецки Анна

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Туулсүрэнгийн Бат

“Хүслийн өнгө” ХХК-д хэвлэв.

Унгар Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд
Бүрэн эрхт Элчин сайд **ДР.ОБРУЩАНСКИЙ**
БОРБАЛА АННА



МЭНДЧИЛГЭЭ

Манай хоёр орны Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа нэлээн эрт үеэс буюу дорнын гарал үүсэлтэй Унгарын ард түмэн гарал угсаагаараа холбоотой байж болох садан төрөл, тэдний хэл соёлыг сонирхох болсон тэр цагаас эхлэлтэй юм.

Тэртээ XIII зуунд Унгарын Загалмайн шашны Доминикан лам Юлианус унгарчуудын өвөг дээдэс, удам угсааг хайхаар Европоос зүүн тийшээ явж, монголчуудын тухай хамгийн анхны мэдээллийг Ромын хамба ламд хүргэсэн юм.

1873 онд Унгарын судлаач, хэл шинжээч Балинт Габор монгол нутагт ирж хээрийн судалгаа хийжээ. Тэрбээр монголчуудын аман түүх, үлгэр домог, ёс заншил, ахуй амьдралтай холбогдох мэдээ баримтыг цулгуулаад буцсан байна.

XX зуунд Лигети Лаёш монгол хэлний судалгаа хийж, хэл сургах үйл ажиллагаа явуулснаар Унгарын монгол судлалд чухал алхам болж, энэ салбарт эрдэм шинжилгээний экспедициуд

унгаруудын үүсэл гарвалын тухай судалгаа, байгалийн шинжлэх ухааны судалгааг ч үр дүнтэй хийсэн юм.

Унгар, Монгол хоёр улс 1950 оны 4 дүгээр сарын 28-нд Дипломат харилцаа тогтож, 1957 онд Улаанбаатар болон Будапешт хотуудад харилцан Элчин сайдын яамаа нээснээр манай хоёр орны хооронд албан ёсны харилцаа тогтож, харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарыг хамран хөгжих үүд хаалга нээгдсэн юм.

1957 онд Унгар-Монголын соёл, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны анхны хэлэлцээр байгуулагдснаар хоёр улсын холбогдох талууд хамтарсан экспидецүүдийг зохион байгуулах боломжтой болсон. Ингэснээр угсаатны зүй, археологи, хэл шинжлэл, биологи, ус, геологийн гэх мэт экспидецүүд 1960 оноос эхлэн зохион байгуулагдах болов. Энэ хүрээнд 1957 онд Унгарын талаас монгол судлаач Хар Дорж (Кара Дьёрдь), Каталин Кохальми, Андраш Рона-Таш нар Монголд судалгааны

аялал хийсэн байна. 1961 онд бөө судлаач Вилмош Диосеги мөн Монголд ирж, бөөгийн шүтлэгийн түүх, уламжлалын талаар судалгаа хийсэн. Археологич Иштван Эрдели 1961-1989 онд Төв Азийн бүс нутаг дахь Хүннү, Түрэгийн булшинд археологийн малтлага хийв. 1969 онд Лайош Лигети Унгарын Шинжлэх Ухааны Академийн дэргэд Алтай судлалын судалгааны бүлгийг байгуулсан бөгөөд тус бүлэг нь 2006 он хүртэл ажилласан гэх мэтчлэн хамтын ажиллагааны түүх маш урт үргэлжилнэ.

Өдгөө манай Элчин сайдын яамнаас хоёр улсын Шинжлэх ухааны салбар хоорондын энэхүү уламжлалт харилцаа, хамтын ажиллагааг улам илүү өргөжүүлэн хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ хүрээнд археологи, археогенетик, түүх, биологи, философи угсаатны зүйн болон бусад чиглэлээр хамтарсан судалгааны хөтөлбөрүүд маш амжилттай хэрэгжиж байна.

Бид цаашдаа олон олон судалгаа, шинжилгээний ажлуудыг хамтдаа хийж, хоёр орны Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааг өргөжүүлнэ гэж итгэж байна.

Монгол Улсын Шинжлэх Ухааны
Академийн Ерөнхийлөгч, Академич
С.ДЭМБЭРЭЛ



МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт Элчин сайд, доктор
Обрущанский Борбала Анна!

Элчин сайдын яамны хамт олон!

Эрдэм шинжилгээний хуралд морилон
саатсан эрдэмтэн судлаачид аа!

Хатагтай Ноёд оо!

Та бүхний энэ өдрийн амар амгаланг
айлтгахын ялдамд Монгол Улсын
ШУА-ийн эрдэмтэн судлаачдынхаа
нэрийн өмнөөс болон хувиасаа чин
сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье!

Дэлхийн шинжлэх ухааны ажилтны
өдөрт зориулан Унгар Улсаас Монгол
Улсад суугаа Элчин сайдын яамнаас
санаачлан, Монгол Улсын ШУА-тай
хамтран “Монгол-Унгарын эрдэм
шинжилгээний хурал”-ыг жил бүр
зохион байгуулж байдагт талархал
илэрхийлье!

Монгол Улс болон Унгарын
хооронд 1950 онд дипломат харилцаа
тогтоосноос хойш Монгол Улсын
Шинжлэх Ухааны Академи нь Унгарын
Шинжлэх Ухааны Академитай хамтран
өнөөг хүртэл хамтран харилцан ашигтай
ажиллаж ирлээ.

Хоёр улсын Шинжлэх ухааны
Академи хооронд хамтран ажиллах
тухай хэлэлцээрийг 1995, 2018,
2021, 2024 онуудад тус тус шинэчлэн
байгуулж хамтарсан мобилити төсөл
хэрэгжүүлж ирсэн уламжлалтай.
2024 онд байгуулсан протоколын
дагуу ШУА-ийн харьяа Биологийн
хүрээлэн, Философийн хүрээлэнгүүд
дээр хоёр шинэ төслийг 2024-2026
онд хэрэгжүүлэхээр баталгаажуулан
ажиллаж байна.

Эдгээр мобилити төслүүд нь
Шинжлэх ухааны тодорхой чиглэлээр
хоёр улсад эрдэмтэн судлаачдын багийг
бүрдүүлж хамтарсан судалгаа явуулах,
харилцан мэдлэг мэдээлэл хуваалцах,
эрдэмтэн солилцох замаар хүний
нөөцийг чадавхжуулах ажлыг хоёр
талаас тохирсон байгууллагууд дээр
гүйцэтгэдэг билээ.

Энэхүү эрдэм шинжилгээний
хурлыг бид хоёр орны шинжлэх
ухааны байгууллага болон эрдэмтэн,
судлаачдын хооронд хэрэгжүүлж
байгаа судалгаа хөгжүүлэлтийн ажлын
явц, үр дүнг олон нийтэд сурталчлах,
түгээн дэлгэрүүлэх, судлаачдын хамтын

ажиллагааг өргөжүүлэх зорилгоор зохион байгуулж байна.

Манай хоёр академи нь 1968 оноос түүх археологи, 1970 оноос усны хайгуул, ус цэвэршүүлэх технологи, 1973 оноос нарны зайн үйлдвэрлэл, хураагуур, нарны эрчим хүч ашиглалт, 1979 оноос генетикийн болон шинжлэх ухааны бусад салбарт хамтран ажиллаж ирснийг дурдахад таатай байна.

Цаашид бид хамтарсан судалгаа хөгжүүлэлтийн мэдээллийн сан, дэд бүтэц, хамтын ажиллагааны туршлага, хүний нөөцийн чадавхиа ашиглан дээрх салбаруудад үр дүнтэй ажиллах боломжтой гэж үзэж байна. Мөн бусад салбарууд дээр шинэ боломжийг бий болгох, улмаар тодорхой үр дүнд хүргэх, цаашлан Монгол-Унгарын хамтын

ажиллагааг шинэ түвшинд гаргах талаар санаачилга гарган ажиллах нь чухал байна.

Бидний энэ хамтын ажиллагаа нь Унгар Улсын ШУА-ийг ирээдүйн Европ дахь Монгол судлал, эрдэм судлалын хамтын ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэх түнш гэдгийг илэрхийлж байна. Бид цаашид олон чиглэлээр хамтран судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэнэ гэдэгт итгэл төгс байна.

Та бүхэнд манай хоёр орны шинжлэх ухаан, технологи, инновацын салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулж, улам бүр ойртон дотносож, хамтран ажиллахыг уриалж, эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагаанд өндөр амжилт хүсэн ерөөе!

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО” БОЛ ЭРХ ЗҮЙН ТҮҮХИЙН ЭХ СУРВАЛЖ

Фалуш Оршүе¹-Обрущанский Борбала²

Танилцуулга

Монголын хууль эрх зүйн хөгжил нь хүчирхэг эзэнт гүрний задрал болон тусгаар тогтносон орчин үеийн улс байгуулагдах хүртэлх түүхийн өсөлт, бууралттай салшгүй холбоотой үйл явц юм.

Монголын хууль эрх зүйн хөгжлийг түүхийн гурван үед авч үзэх боломжтой.³

1-р үе: Монгол үндэстний хууль цаазын үүсэл хөгжлийн үе: Чингис хаан Их Монгол Улсыг байгуулан Их Засаг хуулийг баталсан. Хууль зүйн эх сурвалжид тэмдэглэснээр татаар аймгаас гаралтай, бичиг эрдэмд гаргууд Шихихутугийг Хаант төрийн Их заргачаар өргөмжилсөн. Шихихутуг уламжлагдан ирсэн хууль дүрэм дээр үндэслэн Их Засаг хуулийг боловсруулсан.

Их Засаг хуулийн эх бичвэр нь хадгалагдан үлдээгүй боловч холбогдох түүхэн сурвалжууд болон уламжлалуудыг судлах замаар агуулгыг нь дүгнэж болно.

2-р үе: Монгол овог аймгуудын дунд батлагдсан хоёр дахь хууль цааз буюу



Зураг1. Шихихутуг Их сургуулийн өмнө байрлах Шихихутугийн хөшөө (Фалуш Оршүе, 2024 оны 5-р сар)

1640 оны Халх-Ойрадын цааз. Энэхүү цаазын бичигт монгол овог аймгуудын хэрэглэж байсан хууль дүрмүүдийг нэгтгэж өгсөн. 1709 онд “Халх журам” батлагдсан. Энэхүү хуулиар Манжийн харьяанд байсан халхын нийгэм⁴, улс

¹ Dr. Obrusánszky Borbála PhD; Károli Gáspár Református Egyetem, Bölcsészeti-és Társadalomtudományi Kar; borbala.obrusanszky@gmail.com; <https://orcid.org/0000-0001-8654-1796>

² Dr. Habil, PhD, egyetemi docens, Dunaiújvárosi Egyetem, Társadalomtudományi Intézet, Szervezetfejlesztési és Kommunikációtudományi Tanszék; faluso@uniduna.hu; címzetes egyetemi tanár, PTE ÁJK Jogtörténeti Tanszék; <https://orcid.org/0000-0002-8217-3065>

³ Odgerel Tseveen - *Ganbold Battsetseg: The Mongolian Legal System and Laws: a Brief Overview*. NYU Law, 2006, *GlobalLex*. <https://www.nyulawglobal.org/globalex/Mongolia.html> (2024. 10. 27.)

⁴ A khalkhák a hagyomány szerint Dzsingisz kán egyenes ági leszármazottai. Mongólia lakosságának 80%-át teszik ki. Az ő dialektusuk Mongólia hivatalos nyelve. Forrás: Britannica,

төрийн дотоод асуудлыг зохицуулсан.

3-р үе: Холбогдох бичмэл хууль тогтоомж болон орчин үеийн тогтолцоо бүрэлдсэн үе.⁵ Монголчуудын хууль эрх зүй болон Олон улсын харилцааны түвшинд удаан хугацаанд ашиглаж байсан тухайн үеийн цорын ганц бүтээл нь 1937 онд хэвлэгдсэн Риасановскигийн “Монголын эрх зүйн үндсэн зарчмууд”⁶ хэмээх монографи бөгөөд дундад зууны болон шинэ цагийн эхэн үеийн хууль эрх зүйн сурвалжуудыг эмхэтгэн англи хэл рүү хөрвүүлсэн байдаг. Ном хэвлэгдэн гарсны дараа 1948 онд “Вашингтоны хуулийн тойм”⁷ сэтгүүлд зохиолч нарийвчилсан судалгаагаар хураангуйлан нийтлүүлжээ. Энэхүү судалгаанд хууль зүйн түүхчдийн судалсан эрх зүйн анхдагч сурвалжуудыг нарийвчлан

судлаагүй, харин өнөөг хүртэл түүхэн зохиол хэмээн тайлбарласаар ирсэн XIII зууны сурвалжийг онцолж судалсан байна. “Монголын нууц товчоо”-нд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр “Их Монгол Улсын төрийн байгуулал”⁸-ын талаар нэлээд олон бүтээл хэвлэгдсэн байдаг. Чингис хааны удирдан манлайлах гоц авьяас чадварын тухай⁹ энэхүү бүтээлд тусгагдсанаас гадна “Их Засаг хууль”, “Хөх дэвтэр”-ээс тухайн үеийн зан заншлын эрх зүйн талаар өөр хаанаас ч унших боломжгүй арвин их мэдээлэлийг авах боломжтой. Судалгааны таамаглалаас үзэхэд “Монголын нууц товчоо” нь хууль зүйн түүхчдийн хувьд үнэ цэнэтэй эх сурвалж¹⁰ мөн хэмээн үзэж болно.

T. Editors of Encyclopaedia (2016, February 22). Khalkha. Encyclopedia Britannica. <https://www.britannica.com/topic/Khalkha-people>. Bóvebben: Uradyn E. Bulag: Ethnicity, National Unity and Law in Mongolia. Ulaanbaatar, 2020. National University of Mongolia Press; Myagmarjav, Batsaikhan: On Avga Taiji Nobles in Khalkha. Chinggis Khaan Heritage & Culture, 2023. 2. évf. 2. sz. p. 23-36.

⁵ *Odgerel - Ganbold 2006.*

⁶ *Riasanovszky, Valentin A.: Fundamental Principles of Mongol Law. Tientsin, 1937. Telberg's International Bookstores*

⁷ *Riasanovsky, Valentin A.: Far Eastern Section, Mongol Law—A Concise Historical Survey. Washington Law Review, 1948. 23. évf. 2. sz. p. 166-177.*

⁸ *Bedeski, Robert: Human Sources of the Mongol State: Chinggis Khan's Survival, Will-to-Live and Will-to-Power as told in the Secret History. Chinggis Khaan Heritage & Culture, 2022. 1. évf. 1. sz. p. 25-51.; Allsen, Thomas T.: Technologies of Governance in the Mongolian Empire: A Geographic Overview. In Sneath, David (szerk.): Imperial Statecraft. Bellingham, 2006. Western Washington University, 2006. p. 110-140.; Fitzhugh, William, W. – Rossabi, Morris – Honeychurch, William: Genghis Khan and the Mongol Empire. Washington DC, 2013. Arctic Studies Center*

⁹ *Bayarshaikan Dashdondog: Some thoughts on why did the Mongol Empire succeed and fell. Chinggis Khaan Heritage & Culture, 2022. 1. évf. 1. sz. p. 6-24.; Earle, Timothy: How Chiefs come to Power: The Political Economy in Prehistory. Stanford, 1997. Stanford University Press; Juvainy, Ata-Malik: The History of the World-Conqueror. Manchester, 1997. Manchester University Press; Saunders, J. J.: The Nomad as Empire Builder: A Comparison of Arab and Mongol Conquests. Diogenes, 1965. 13. évf. 52. sz. p. 79-103.*

¹⁰ *Itt szükséges megemlíteni, hogy egyes – nem jogász, hanem történész - mongol kutatók korábban már foglalkoztak a művel, és fel is hívták a figyelmet különböző szokásokra ezzel kapcsolatban, azonban nem végeztek ezzel kapcsolatban jogi – jogtörténeti szempontú elemzést. Perlee, Kh.: Nuuts товчоонд улсын хуулилтаазни зарим зүйл. Ulaanbaatar,*

Энэхүү бүтээлд Монголын нэгэн жижиг аймгийн удирдагчийн хүү Тэмүжин дэлхийг байлдан дагуулах аянд хэрхэн мордсон тухай өгүүлдэг. Тэмүжин хэрхэн Чингис хаан болж, хүчирхэг Монголын Эзэнт гүрнийг байгуулсан тухай болон дундад зууны үеийн тал нутгийн морьтон нүүдэлчин ард түмний ахуй амьдралын хэв маяг, сэтгэлгээний талаарх ойлголтыг өгдөг. Мөн нүүдэлчин, малчин ард түмэн төр улсаа ямар зарчмаар зохион байгуулж, өргөн уудам тал нутгийн Эзэнт гүрнийг хэрхэн удирдаж байсан талаар дүгнэлт хийж болно. Энэхүү бүтээл нь Хубилай хааны Бээжин дэх (Ханбалик) ордонд хадгалагдаж байсан бөгөөд олон зуун жилийг гайхамшигтай байдлаар туулан үлджээ. Уг бүтээлийн эх нь Хятадын ордны сургуулиудад монгол хэл заахад орчуулгын дадлага сургуулилт болгон ашиглаж байсан тул өнөөг хүртэл үлдэж чадсан юм. Ингэхдээ монгол эх бичвэрийг хятад үсгээр дуу авианы хувьд хөрвүүлсэн тул хадгалагдан үлдсэн юм. Энэ нь өнөө үед чухалд тооцогдох XIII зууны үеийн түүхийн болон уран зохиолын бичгийн дурсгал юм.

Анх 1866 онд орос хэл дээр, 1915-1917 оны хооронд монгол судлаач Баавудай Цэнд гүн монгол хэлээр хэвлүүлсэн.¹¹ 1940-өөд оноос эхлэн барууны хэл рүү хөрвүүлэгдсэн ба 1962 онд Лигети Лаёш унгар хэлнээ

хөрвүүлсэн.¹² Энэхүү судалгааны арга нь эх сурвалжийн шинжилгээ бөгөөд “Монголын нууц товчоо”-г бид хууль зүйн түүхийн эх сурвалжийн үүднээс нь судалсан.

Бүтээлийн түүхэн сурвалж: Их Монгол улс байгуулагдсан нь.

Монгол түүхчдийн үзэж байгаагаар тал нутгийн төрийн үзэл санаа нь эв нэгдлийн сургаалд тулгуурласан байдаг. Үүний мөн чанар нь нум сумаар харвадаг нүүдэлчин ард түмэн нэгдэж чадвал хүчтэй байдгийг илтгэж байна.¹³ “Монголын нууц товчоо” бүтээлд Чингис хааны элэнц эмээ Алунгуа хатан хөвгүүддээ эвтэй байхыг сургамжилдаг: “Хаврын нэгэн өдөр тэрээр өвөл төрсөн хурга чанаад өөрийн хөвгүүд болох Бэлгүнүдэй, Бүгүнүдэй, Буха хатаги, Бухати салжи, Бодончар мунхаг нарыг зэрэгцүүлэн суулгаад хүн тус бүрд нь сум өгөөд хугал гэдэг. Хөвгүүд нь сумнуудаа амархан хугалдаг. Дараа нь тэдэнд таван сумыг багцлан өгөөд хугал гэдэг. Багцалсан сумыг хөвгүүн тус бүр хугалахыг оролдсон боловч хугалж чададгүй.” Тэр үед эх нь хөвгүүддээ ийн сургадаг: “Та таван хөвүүн миний нэгэн хэвлээс төрсөн бус уу. Та нар ганц ганцаар салбал ганц сум мэт хүнд хялбархан дийлэгдэнэ. Та нар эв эеэ нэгтгэвэл багласан таван сум мэт бэх болж, хэнд ч хялбар дийлдэхгүй болно”.¹⁴

1962. *Mongolin 4. 3. boti, 15-r devter.; Dashtsedem, D.: Nuuts tovchooni khuuli tsaazni zarim zuil. Dornodakhin sudlal, 1990. 2. ёvf. 23. sz. p. 41-50.*

¹¹ *Obrusánszky Borbála: Törvények és tanítások. A sztyeppei lovas birodalmak szellemi öröksége. Budapest, 2024. Két Hollós Kiadó*

¹² *Föglér Klára (szerk.): A mongolok titkos története. Budapest, 1962. Gondolat Kiadó. Fordította és jegyzetekkel ellátta: Ligeti Lajos. A verseket Képes Géza fordította (a továbbiakban: MTT)*

¹³ *Obrusánszky 2024. p. 35.*

¹⁴ *Монголын нууц товчоо 19-22.*

Монголын тал нутагт олон жижиг овог аймгууд байсан бөгөөд XII зууны хоёр дугаар хагаст хоорондоо хамгийн сайн бэлчээр нутгийг булаалдалдан дайтдаг байв.¹⁵ Зарим хүчирхэг хангууд эдгээр жижиг овог аймгуудыг өөрийн эрхшээлдээ оруулахыг оролддог байв.

Монголын судлаач Отгоны Пүрэвийн үзсэнээр¹⁶, өвөг дээдсийнхээ хүндэтгэлд суурилсан итгэл үнэмшлийн тогтолцооны үзэл баримтлалд тулгуурлан эртний Скиф, Хүннүгээс гарал үүсэлтэй, тэнгэрийн хүчинтэй холбогдсон онцгой нэгэн хаан нум сумтан, нүүдэлчин эсгий туургатан¹⁷ ард түмнийг нэгтгэн захирах ёстой.



Зураг 2. Монголын тал нутагт гэр барьж байгаа нь
(Фалуш Оришүе, 2024 оны 5-р сар)

XII зууны сүүлчээр Хамаг Монголын хаанаар өргөмжлөгдөх ёстой байсан хүн нь Тэмүжин байсан бөгөөд тэрээр өмнөө тулгарсан саад бэрхшээлийг үл харгалзан жижиг, том овог аймгуудыг

нэгтгэж чадсан хүн юм. Тэрээр 1189 онд Хамаг Монголын хаанаар өргөмжлөгдөн Чингис хаан нэртэй болсон. 1206 оны Онон мөрний эхэнд болсон хуралдайгаар¹⁸ Их Монгол Улсыг байгуулжээ.



Зураг 3. Онон гол. Энэ нутгаас Тэмүүжин гаралтай бөгөөд түүнийг энд Чингис хаанаар өргөмжилсөн. (Фалуш Оришүе, 2024 оны 5-р сар)

Хуралдайгаар Тэмүүжинг Чингис хаанаар өргөмжилсний дараа хууль цаазыг боловсруулсан. Мөн төрийн захиргаа болон шүүх эрх мэдэлтэй түшмэд сонгогдсон. Эртний нүүдэлчдийн уламжлалын дагуу Эзэнт гүрнийг гурван хэсэгт хуваасан: Их хааны үнэнч анд Мухулай болон Боорчи

¹⁵ *A legerősebb fejedelemségek: Kereit kánság, Najman kánság, Öngüt Kánság.*

¹⁶ Пүрэв, О.: Монголын бөөгийн шаашин. (Pürev, O.: *Mongol böögijn sasin*) Ulánbátor, 2002. Адмон (Admon)

¹⁷ Obrusánszky 2024. p. 40.

¹⁸ *A szó a kuri (=összegyűlni) szóból ered. A szó a magyar kör rokona. A mongoloknál korábban az eje volt a törzsi, káni gyűlések összefoglaló neve. Utóbbi szó jelentése egy, amely arra utal, hogy a fórumon a vezetőknek egységre kellett jutniuk.* Obrusánszky 2024. p. 81.

нар баруун зүүн хэсгийг нь захирсан. Хуралдайгаар Шихихутугийг төрийн Их заргачаар томилсон бөгөөд тэрээр уламжлагдан ирсэн хууль дүрмэнд тулгуурлан шийдвэрлэсэн хэрэг заргаа “Хөх дэвтэр”-т тэмдэглэдэг болсон. (Жич: Монгол хэлний төр хэмээх үг нь унгар хэлний төрвинь (хууль) гэсэн үгтэй ижил төстэй үг юм¹⁹). Уламжлалт хуулинд 1210, 1218 оны хуралдайгаар хүлээн зөвшөөрсөн үйл ажиллагааны хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хуралдайгаар гарсан шийдвэрүүд нь гадаад, дотоод бодлого болон тэдний эрхшээлд байсан ард түмнүүдээс хураах татвартай холбоотой байв.

Чингис болон түүний залгамжлагч Өгөдэй хаан эртний Монголын ард түмний бий болгосон өртөөг²⁰ төгөлдөршүүлж, тухайн үеийн дэлхийн хамгийн дэвшилтэт харилцаа холбоо, шуудангийн сүлжээг²¹ зохион байгуулсан нь Эзэнт гүрний доторх мэдээллийн хурдацтай урсгалыг бий болгожээ.

Нүүдэлчдийн төрийн байгуулал нь суурин соёл иргэншлийн нэгэн адил хууль тогтоох, төрийн удирдлага, шүүх эрх мэдэл гэсэн гурван чухал салбартай байв. Монголын Эзэнт гүрэн байгуулагдахаас өмнө гурвуулаа хааны захиргаанд байсан. Монголын эзэнт гүрэн байгуулагдсаны дараа эрх мэдлийн хуваарилалтууд өөрчлөгдсөн. Төрийн дээд албыг Их хааны томилсон түшмэд бүрдүүлдэг байв.

1206 оны хуралдайгаар засаг захиргаа, шүүхийн шинэчлэлийн хүрээнд Чингис хаан бичиг үсгийг төгс эзэмшсэн татаар гаралтай Шихихутугийг төрийн Их заргачаар томилсон: “Тэрээр улсын их заргач байсны хувьд хаантай зөвлөлдөн шүүн таслах ажиллагаа явуулж, заргаа “Хөх дэвтэр”-т²² цагаан цаасан дээр бичиж дэвтэрлэх үүрэгтэй болсон. Чингис хаан “Хөх дэвтэр”-ийн цагаан хуудсанд бичигдсэн хууль цаазыг үеийн үед сахиж хэн ч өөрчлөх ёсгүй! Үүнийг өөрчилсөн хүмүүсийг шийтгэх ёстой”²³ хэмээн зарлигдсан.



Зураг 4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн байран дахь “Цэнхэр дэвтэр”-ийн хуулбар. Улаанбаатар хот, Монгол улс (Зураг: Фалуш Оришүе, 2024 оны 5-р сар)

¹⁹ Obrusánszky 2024. p. 80.

²⁰ Монголын нууц товчоо 279

²¹ Obrusánszky 2024. p. 85.

²² A jogi szakirodalomban elterjedt Kék Könyv megnevezés valójában pontatlan fordítás eredménye. A mongol eredeti neve Kőke Debter; magyarul Kék Füzet. MTT 203; Obrusánszky 2024. p. 81.

²³ Монголын нууц товчоо 203

Мөн хуралдайгаар аян дайн хийх шийдвэрийг гаргаж оролцох цэргийн тоог тогтоодог байсан. “Монголын нууц товчоо”-ны ихэнх хэсэгт энэ талаар тэмдэглэгдсэн байдаг.

Унгарчуудтай холбоотой хамгийн эмгэнэлтэй шийдвэр бол 1235 оны хуралдайгаар гаргасан 1241-1242 онуудын монголчуудын аян дайны талаарх шийдвэр юм. Энэхүү хуралдайгаар өрнө зүгт хийх аян дайны талаарх шийдвэр гарсан: “Өмнө нь Сүбээдэй баатар аян дайнд мордож кангли, кипчак, баджигин, орос, асуд, сесүт, мажар, кешимир, черкес, булгар, керел аймгуудыг довтолсон (...). Харин энэ удаа Сүбээдэй жанжин зөвлөхөөр томилогдон Бат, Бүри, Гүюг, Мөнх болон бас хан хөвгүүд аян дайнд мордсон. Аян дайныг Батаар удирдуулахаар шийдвэрлэсэн.”²⁴

1219 онд болсон хуралдайгаар Чингис хааны бага хатан Есүй хатны санаачлагаар их хааны гэрээслэлийг баталгаажуулж, хан хөвгүүдэд оноогдох нутаг дэвсгэрийг хуваарилсан. Хоёр дахь хүү Цагаадайн санаачлагаар

Өгөөдэй хаан ширээг залгамжлахаар шийдвэрлэсэн. Хамгийн том хүү Зүчийн гарал²⁵ нь тодорхой бус байсан тул түүнд хамгийн баруун хэсгийн нутгийг өгчээ. Хоёр дахь хүү Цагаадайд²⁶ тухайн үед Чингис хааны эзэлсэн Дундад Азийн мусулман улсуудын нутаг оногдов. Хамгийн отгон хүү Тулуйд өвөг дээдсийн уугуул Монгол нутгийг оноов²⁷. Хуралдай нь зөвхөн Чингис хааны үед ч бус түүний залгамжлагчдын үед ч гэсэн онц чухал хууль тогтоох байгууллагын үүргийг гүйцэтгэдэг байсан. Чингис хааныг нас барсны дараа²⁸ 1229 онд Хэрлэнгийн Хөдөө аралд болсон хуралдайгаар Өгөөдэйг их хаанаар сонгосон.²⁹

Эх сурвалжийн шинжилгээ: “Монголын нууц товчоо”-н дахь уламжлалт хууль дүрмийн элементүүд ба хууль тогтоомж

“Монголын нууц товчоон”-д өгүүлснээр, улсын анхны Их заргач Шихихутуг төрийн хэрэг зарга шүүсэн тухайгаа “Хөх дэвтэр”-т тэмдэглэх байв.³⁰ Тал нутгийн бусад нүүдэлчин

²⁴ Монголын нууц товчоо 270. *A Magyar Királyság területére a madzsar szó vonatkozik.*

²⁵ Монголын нууц товчоо 100 – 106, 255. *Első feleségét, Börtét, a merkitek elrabolták. így álltak bosszút azért, hogy annak idején Temüdzsin apja is a merkitektől rabolta el Höelüint, Temüdzsin anyját. Börte kiszabadítására Temüdzsin Tooril kánnal és Dzsamukával szövetkezett, s együttes erővel győzték le a merkiteket. Temüdzsin hazavihette feleségét, aki ekkor már első gyermekét várta. A nagykán hiába fogadta el fiának a gyermeket, annak a neve, Dzsocsi (=vendég) arra utal, hogy akár más is lehet az apja. Bővebben: Obrusánszky 2024. p. 64.*

²⁶ „A nyúl-évben (1219) megindult hát a szartaul nép ellen, s átkelt az Alajon.” Монголын нууц товчоо 257

²⁷ Монголын нууц товчоо 254 – 255. *Lásd még: 3.1.3.*

²⁸ „A disznó-évben (1227) Dzsingisz kán az égbe szállt.” MTT 268

²⁹ Монголын нууц товчоо 270; Obrusánszky 2024. p. 86.

³⁰ *Ha figyelembe vesszük, hogy a szokásjog összegyűjtése és írásbeli rögzítése a Nagy Mongol Birodalomban már a 13. században megtörtént a főbíró, Shihihutug, munkája nyomán, Magyarországon pedig ez - a szintén főbíró: királyi ítélmester- Werbőczy Istvánnak köszönhetően 1514-ben készült el (Tripartitum Opus Iuris Consuetudinarii Incltyi Regni Hungariae), tehát háromszáz évvel később – nem állítható, hogy a mongol jogrend primitív, fejletlen lett volna Dzsingisz nagykán uralkodása idején, a 13. században.*

ард түмний адилаар монголчууд уламжлалаа хүндэтгэдэг байсны дотор уламжлалт хууль тогтоомжийг ч мөн хүндэлдэг байсан. Чингис хаанаар овоглох Их Монголын Эзэнт гүрний шинэчлэлийн тэргүүлэх зүйл нь эдгээр уламжлалт заншил дээр суурилсан хуулиудыг бичиж тэмдэглэх байсан. Шихихутугийн “Хөх дэвтэр”-т тэмдэглэсэн заншлын хууль тухайн цаг үед, нийгмийн өөрчлөлтөөс үүдэн бий болсон хэлбэрээр нэмж өөрчлөгдөн, зөвхөн хүчин төгөлдөр эх сурвалж болохын тулд энэ нь тэдний хожмын кодчилох үйл ажиллагааны үндэс нь болсон. Зөвхөн хуралдайгаар хэлэлцэж зөвшөөрөгдсөн хуулиуд хүчин төгөлдөр болдог байсан.

Энэхүү бүтээлд орсон хууль эрх зүйн (заншлын хууль) элементүүдийг хууль бүрээр тайлбарласан болно.

3.1. Хувийн эрх зүй

3.1.1. Хүний эрх зүйн байдал

3.1.1.1. Дархан

Монголын нийгэмд боолоос бусад насанд хүрсэн бүх хүн их хааны харьяат байсан тул эрх чөлөөтэй байсан. Хэдийгээр эцгийн эрхт нийгэмд эрэгтэйчүүд чухал асуудлыг шийддэг байсан ч гэрлэлтийн зан заншил хууль тогтоомжид тусгаснаар эмэгтэйчүүд өөрсдөө эрэгтэйчүүдтэй адил эрх мэдэлтэй байх ёстой байсан тул тал нутгийн овог аймгуудын дунд эмэгтэйчүүдийн эрх мэдэл өндөр

байв.³¹ Тэгш эрхтэй хүмүүсийн дундаас дархлагдсан хүмүүс л илүү эрхтэй байсан бөгөөд тэд хичээл зүтгэл, эр зориг, үнэнч байдлынхаа төлөө олон давуу эрх хүртсэн байдаг (жишээлбэл, тэд дайнаас олсон бүх олзоо өөртөө үлдээж, хаанд чөлөөтэй бараалхах эрхтэй байсан).³² Дархлагдах зам хүн бүрийн өмнө эрх тэгш нээлтэй байсан. Тэдний давуу эрхэнд эрүүгийн хуулийн тусгай заалтууд багтсан байсан: “урьдчилсан байдлаар тэднийг дархалсан”³³ байдаг бөгөөд үүний үндсэн дээр тэднийг есөн удаагийн гэмт хэргээс урьдчилан өршөөсөн байдаг. Тэдний эрхийг үр удам нь ч өвлөж авах боломжтой.

Боолын эзэн нь боолуудаа хөдлөх хөрөнгө мэт өөрийн хүссэнээр захиран зарцуулж болно: “Босгонд мөргөж / боол болох/ Босгыг чинь давсан боол бослого гаргавал / Гар хөлийг нь хугал!/ Харагтун, тэд чиний харьяат боол юм. / Тэд таны тушаалыг хүлээж байна. /Тэд таны хаалгыг савж одвоос, /Элгийг нь тасдаж хая!”³⁴

3.1.1.2. Бэк -ийн эрх зүй

Бэк гэдэг үгээр Монголын Эзэнт гүрний өмнөх үеийн нэгэн чухал хэргэм зэрэгт тооцогдож байсан бөгөөд хэд хэдэн жижиг ханлигууд (мэргэд, ойрд гэх мэт)-ын удирдагчдыг нэрлэж байжээ. Энэхүү хэргэм зэргийг эрчүүд болон эмэгтэйчүүдийн³⁵ аль аль нь хэрэглэж болдог байсан. Харамсалтай нь эх сурвалж цөөхөн байдаг тул бид энэ

³¹ Broadbridge, Anne F.: *Women and the Making of the Mongol Empire*. Cambridge, 2018. Cambridge University Press. p. 18.

³² *A darhan méltóság eredete egészen a közép-ázsiai hephtalita (hun) birodalomig nyúlik vissza, de a tarkhan címet ismerték és használták a türkök és ujugurok is. A szó rokonságot mutat a tarján szóval.*

³³ *Bóvebben: 3.2.5. pontban*

³⁴ *Монголын нууц товчоо 137*

³⁵ *Монголын нууц товчоо 165, 168, 186, 198, 239*

талаар бага зэргийн ойлголттой байдаг. “Монголын нууц товчоо”-нд тулгуурлан хэлэхэд Чингис хаан ард түмэндээ энэхүү хэргэм зэргийг үлдээсэн нь гарцаагүй юм: “Монголчуудын хуулиар бол хүн болгонд бэкийн хэргэм зэрэгт хүрэх боломж бий”. (...) Түүнд бэкийн хэргэм зэрэг олгон, цагаан хувцас өмсүүлж, цагаан морь өгч, дээгүүр залж, олон жил сараар хүндэтгэл үзүүлэхээр болсон.”³⁶

3.1.1.3. Хөдөлмөрийн чадваргүй хүний эрх зүйн байдал

3.1.1.3.1. Хөдөлмөрийн чадваргүй хүний өв залгамжлал

Чингис хааны гарал үүслийн тухай уг бүтээлийн эхэн хэсэгт дурддаг. Чингис хааны элэнц эх Алангуаг нас барсны дараа 5 хүү нь эд хөрөнгөө хуваахаар болдог: “Бэлгүнүтэй, Бүгүнүтэй, Буха-Хатиг болон Бухату-Салжи нарын дөрвөн хөвгүүн нь өөр өөрсдийн хувийг авдаг. Бодончарыг мунхаг хэмээн хэлж гэр бүлийн гишүүнд тооцолгүй түүнд хувь хүртээдэггүй.”³⁷ Энэхүү хэсэгт сэтгэцийн эмгэгийн улмаас хөдөлмөрийн чадваргүй гэж тооцогдсон насанд хүрсэн хүн гэр бүлээс хасагдсан, улмаар өв залгамжлалаас хасагдсан тухай өгүүлнэ. Түүнийг хөдөлмөрийн чадваргүй гэж үзсэн нь гэр бүлийнх нь шийдвэр байсан тул хүчингүй болгож болно. Энэ нь Бодончарт тохиолдсон байж магадгүй бөгөөд түүнийг ах дүү нар нь хожим олж, гэр бүлдээ буцаан хүлээж авдаг. Хожим нь түүний зөвлөснөөр удирдагчгүй нэгэн ард түмэн рүү дайрч, их хэмжээний олз

авсан байдаг тул түүний хөдөлмөрийн чадваргүй байдалд нь өөрчлөлт орсон байж магадгүй юм.³⁸

3.1.1.3.2. Хөдөлмөрийн чадваргүй хүний гэрлэлт

Өв залгамжлалаас хасагдсан Бодончар мунхаг нэгэн эмэгтэйг довтолгооны үеэр олзолдог: “Бодончарын толгойн харуулынхан тэдэн рүү довтлон нэгэн хөл хүнд бүсгүйг олзолдог”³⁹. Бодончар цаашид ахин эхнэр авснаар түүний үр удам олон болдог⁴⁰.

Бүтээлд дараах зүйлсийг тодорхой зааж өгсөн байдаг: Сэтгэцийн эмгэгийн улмаас хөдөлмөрийн чадваргүй болсон насанд хүрсэн хүн өв залгамжлалаас хасагдсан ч түүний гэрлэлт хүчинтэй хэвээр байв. Энэ нь удам угсаагаа хадгалахад тусалсан бөгөөд Бодончар Монголын анхны удирдагчдын өвөг болсон байдаг.

3.1.2. Гэр бүлийн хууль

3.1.2.1. Гэрлэлт

а) Олон эхнэр: Бодончарын түүхээс харахад эртний нийгэмд олон эхнэртэй байх нь хууль ёсны заншил байсан. Чингис хаан өөрөө мөн олон эхнэртэй байсан байна: “Монголын нууц товчоо”-нд маш олон татвар эмс болон долоон хатны нэрс дурдагддаг: Үүнд: Бөртэ хатан болон Есүгэн, Есүй хатад нь эгч дүүс байсан байна. Мөн Ибага бэхи, Хулан хатан, Гекчжу хатан, Чаха хатан нарын нэрс дурдагдсан байдаг. Чингис хааныг хүүхэд байхад нь Бөртэ

³⁶ Монголын нууц товчоо 216

³⁷ Монголын нууц товчоо 23

³⁸ Монголын нууц товчоо 32-35

³⁹ Монголын нууц товчоо 38

⁴⁰ Монголын нууц товчоо 44 - 43

хатныг⁴¹ түүний эцэг Есүхэй баатар гуйсан байдаг. Ибага бэхи⁴² нь Чингис хаанд ялагдсан Ван ханы дүүгийн охин нь байсан бол мэргэд аймгийг буулгаж авсны дараа Хулан⁴³ хатныг түүний эцэг нь Тэмүүжинд хүргэж өгсөн байдаг. Гекчжу⁴⁴ хатан нь Чингис хаанд ялагдсан Алтан хааны охин байсан бол Чаха⁴⁵ нь түүнд дагаар орсон хашин хааны охин байсан. Есүгэн, Есүй⁴⁶ хатдыг их хаан олзолж авсан байдаг⁴⁷.

Хатдын эрэмбийг түүний нөхөр нь тогтоодог байсан. “Монголын нууц товчоо”-нд Есүгэн, Есүй хатдын эрэмбэ эгч дүүсийн хооронд хэрхэн өөрчлөгдсөн талаар тэмдэглэсэн байдаг: “Татаарын Ихчирэнгийн охин Есүгэнийг Чингис хаан өөртөө хатан болгон авдаг. Хуримын шөнө Есүгэн хатан ийн өгүүлдэг: “Хаан соёрхвол намайг хүнд бодож асрах биз, миний эгч Есүй надаас илүү хаан хүнд зохих гоо үзэсгэлэнтэй билээ, тэрээр саяхан нөхөрт гарсан ч үймээний үеэр хаана очсоныг нь мэдэхгүй хэмээхэд, Чингис хаан ийн өгүүлрүүн: Эгч чинь үнэхээр чамаас гоо үзэсгэлэнтэй болвоос түүнийг ирүүлье, эгчийгээ ирвээс чи зайлж, сууриа өгөх үү хэмээн асуухад Есүгэн хатан: Хаан соёрхож, эгчийг минь авчирч уулзуулбал би эгчдээ даруй зай тавьж өгье” гэв. Эгчийг нь олж ирмэгц Есүгэн эгчийгээ хатан суудалд залж, өөрөө доошоо суув. Есүгэн хатны хэлснээр Есүй хатан үнэхээр

үзэсгэлэнтэй⁴⁸ байсан тул Чингис хаан түүнийг таалж хатнаа болгодог.”

Олон эхнэр авах нь ихэвчлэн хааны эрх мэдлийг бэхжүүлэх хэрэгсэл байсан бөгөөд энэ нь Эзэнт гүрний угсаа залгамжлах мөн чанарыг баталгаажуулж өгдөг байв. Хэрвээ их хатнаас нуган үр төрөхгүй бол бусад хатдаас гарсан хөвгүүдээс угсаа залгамжлагчийг тодруулдаг байв. Эхнэр хүүхэн бэлэглэх нь хааны тааллыг хүртэх нэгэн боломж байв.

“Монголын нууц товчоо”-нд дурдсанаар, Хорчи ноён их хаанд зүтгэснийхээ төлөө 30 гуа охид эмсийг эхнэр болгох эрхийг их хаанаас хүсэв:

“Хол урьдын цагт Хорчи чи мэргэлээд
Зөгнөж хэлсэн үгээ
Зөв болгон тохирч
Тэнгэрийн өршөөл хүчээр
Тэр ёсоор бүтвэл
Гучин эхнэр авья гэж

Гуйсан билээ, чи-хэмээн Чингис хаан өгүүлээд “Чиний хэлсэн үг биелэсэн тул чи одоо эзэлж оруулсан улсын дотроос сайн эхнэр, сайхан хүүхнүүдийг сонгож ав” хэмээн зарлигдав.”⁴⁹

б) Бэр булаах, хулгайлах: Гэрлэлтийн нэгэн хэлбэр нь бэр хулгайлах ёсон байсан. Есүй болон Есүгэн эгч дүүсийг Чингис хаан өөрийн өстөн дайсан татаар аймгаас олзлон авч хатдаа болгосон. “Монголын нууц товчоо”-нд

⁴¹ Монголын нууц товчоо 66 (*első említése*), 94 (*házasságkötés*)

⁴² Монголын нууц товчоо 186

⁴³ Монголын нууц товчоо 197

⁴⁴ Монголын нууц товчоо 248

⁴⁵ Монголын нууц товчоо 249

⁴⁶ Монголын нууц товчоо 155 (*házasságkötés*)

⁴⁷ Монголын нууц товчоо 155 (*házasságkötés*)

⁴⁸ Монголын нууц товчоо 155

⁴⁹ Монголын нууц товчоо 207

тэдний хуримласан он цагийг нохой жилийн (1202) намар хэмээн тодорхой тэмдэглэсэн байдаг.”⁵⁰ “Монголын нууц товчоо”-нд Бодончар болон Чингис хааны гэрлэлтээс гадна өөр олон гэрлэлтийн тухай тэмдэглэсэн байдаг. Чингис хаан ч өөрөө тийм гэрлэлтээс гаралтай. Эцэг Есүхэй баатар түүний ээж Өүлэн хатныг мөн булааж авсан байдаг.⁵¹ Үүнд нь өс санасан мэргэдүүд хожим нь Чингис хааны анхны хатан Бөртэг булаадаг.⁵² Чингис хаан Бөртэ хатныг буцаан авах үед Бөртэ хөл хүнд болсон байдаг.⁵³ Тэмүүжиний ээж Өүлэнг булааж авах үед тэрээр нөхөрт гарсан байсан. Нөхөр болох мэргэд аймгийн Чилэдү өөрөөс нь хүний тоогоор илүү хүмүүс довтлон ирэхийг хараад түүнийг зугтаалгадаг.⁵⁴ Салалтыг эрт цагт мөрдөгдөж байсан уламжлалт хууль дүрэм зохицуулдаггүй байсан.

Гэрлэлт нь булаах замаар явагддаг байсан тул эмэгтэй нь булааж авсан талын нөхөртэй хууль ёсны эхнэр, нөхөр болдог байжээ. Зарим тохиолдолд эмэгтэй хүн нөхрийнхөө зөвшөөрсний дагуу бусдын эзэмшилд очдог. Энэ тухай бодит жишээ наймдугаар номны бэлэглэлийн дараалал дээр гардаг: Жүрчидэй жанжинд Чингис хаан Ибага бэхи хатнаа өгдөг: “Чингис хаан Ибага бэхийг Жүрчидэй жанжинд өгөхдөө ийнхүү өгүүлэв:

“Авир занг чинь голсон биш
Ариун үзэсгэлэнг чинь чамласан биш,

⁵⁰ Монголын нууц товчоо 153

⁵¹ Монголын нууц товчоо 54-56

⁵² Монголын нууц товчоо 102-103

⁵³ Монголын нууц товчоо 110

⁵⁴ Монголын нууц товчоо 56

⁵⁵ Монголын нууц товчоо 202

⁵⁶ Монголын нууц товчоо 202

⁵⁷ Монголын нууц товчоо 43

⁵⁸ Монголын нууц товчоо 66

Өврөө дулаацуулж
Хөлөө хучуулсан
Өөрийн хатан чамайг
Их төрийн үйлст
Илт зүтгэсэн Жүрчидэйд
Ийнхүү соёрхох болов.”⁵⁵

Чингис хаан Ибага-бэхийг язгууртан угсаатай гүнж байсан бөгөөд Их хааны хатан байсныг харгалзан үзээд түүнд зохих ёсоор хүндэтгэлтэй хандахыг захиж, инжнээс нь хувь хүртэх нөхцөлийг бүрдүүлээд тогооч болон нэг зуун зарц шивэгчнийг түүнд өгсөн.⁵⁶

с) Хурим: Монголчууд эмэгтэйчүүдийг зөвхөн булаах замаар эхнэр болгодоггүй байсан. “Монголын нууц товчоо”-нд Бодончар мунхагийн талаар өгүүлэхдээ, түүний авааль эмээс төрсөн хүүг Барим ширату Хабич хэмээн нэрлэдэг байсан байна.”⁵⁷

Чингис хааныг хүүхэд байхад нь Бөртэтэй сүй тавиулдаг: Хонгирад аймгийн Дэй цэцэн Есүхэй баатарт: “Чамд охиноо өгье, харин хүүгээ энд хүргэнээр үлдээгээд яв.” гэв. Тэр хоёр ярьж тохирсоны дараа Есүхэй баатар ийнхүү хэлдэг: “Хүүгээ танайд сүйт хар хүү болгон үлдээ” гээд хөтөлгөө морио үлдээж хүү Тэмүүжинээ сүйт хар хүү болгон үлдээгээд явдаг.⁵⁸ Эцгүүд хоорондоо тохиролцсоны дагуу 10 настай Тэмүүжин хүү Бэртэгийн гэр бүлд үлддэг. Энэ ёс заншлын хуулиар бол сүй тавьж бүсгүйг сонгосны хариу

юм. Энэ заншил нь сүй тавьсан залуус бие биенээ таньж холбоо тогтоох боломжийг олгох зорилготой байв.

d) Эхнэрийн эрх: Эцгийн эрхт нийгэмд эмэгтэйчүүдийн эрх хязгаарлагдмал байсан.

Эрчүүд ихэвчлэн хэдэн сар, жилээр урт хугацаагаар аян дайнд явдаг байсан тул ар гэр, аж ахуйн ажлыг энэ үед эмэгтэйчүүд хариуцаж, шаардлагатай тохиолдолд өөрсдийгөө болон эд хөрөнгөө хамгаалахын тулд зэвсгийн эрдэмд суралцдаг байв. Тиймээс эмэгтэйчүүд нь эрчүүдтэй ижил хэмжээний мэдлэг чадвартай байжээ. Эрэгтэйчүүд ихэвчлэн ээж, эхнэрийнхээ зөвлөгөөг авдаг. Үүний нэгэн жишээ бол “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэсэнээр, Жамухаас салж нүүх хэрэгтэйг Өүлэн эх болон Бөртэ хатан нар Тэмүүжинд зөвлөдөг.⁵⁹ Мөн “Монголын нууц товчоо”-ны 11-р бүлэгт гардаг нэгэн чухал үйл явдал бол Есүгэн хатан Чингис хаанд хан хөвгүүдийн дундаас залгамжлагчаа томилохыг зөвлөдөг. Есүгэн хатны энэхүү зөвлөгөөнд хаан талархал илэрхийлдэг.⁶⁰

Нөхрийгөө нас барсны дараа эхнэр нь түүнийг орлож үйл хэргийг цааш үргэлжлүүлэх тохиолдол мөн байдаг: “Борохул ноёныг Хорь түмэдийг

номхотгохоор илгээв. Ноён Дайдухул сохорыг нас барснаас хойш түүний хатан *Тарган Ботохай Хорь Түмэдийг* захирч байлаа.”⁶¹

Эмэгтэйчүүдийн хүлээн зөвшөөрөгдөх нэмэлт өргөмжлөл нь өмнө дурдсанчлан *бхи* хэмээх цол хэргэм юм.⁶²

e) Татвар эмс (хууль ёсны бус “хамтран амьдрагчид”) Эхнэрүүдийн хажуугаар татвар эмс мөн нөлөөтэй байсан. Тэдгээрээс төрсөн эрэгтэй хүүхдүүдийн зарим нь гэрлэлтээс төрсөн хүүхдийн адил эрх мэдэлтэй байсан: “Хабич баатарын эхийнх нь инжэнд дагалдан ирсэн зарц хүүхнийг Бодончар татвар эмээ болгон авсан бөгөөд түүнээс хүү төрсөн. Түүнийг Жаурьдай хэмээн нэрлэсэн. Жаурьдай эхэндээ зүхэл тайлгад оролцох эрхтэй байв.”⁶³

3.1.2.2. Эцэг эхээ асрах: Өүлэн эх бэлэвсэрсэнийхээ дараа үр хүүхдүүдээ өөрөө өсгөдөг. Хүүхдүүд нь өсөж том болоод ээжийгээ асардаг: “Тэр цагаас хойш талархсан сэтгэлээр ээжийгээ асарсан”⁶⁴

3.1.2.3. Цусан тангараг өргөж анд бололцох болон худ-ураг бололцох ёсон: Ураг төрлөөс гадуур цусан тангараг өргөн баталгаажуулж, анд бололцох нь Монголын тал нутагт түгээмэл ёс заншил байсан.⁶⁵ Энэхүү холбоо нь

⁵⁹ *Монголын нууц товчоо* 118

⁶⁰ *Монголын нууц товчоо. Lásd még: 3.1.3.*

⁶¹ *Монголын нууц товчоо. 240*

⁶² *Lásd: 3.1.1.2.*

⁶³ *Монголын нууц товчоо. Amikor azonban a családfő meghalt, a felesleges örökösstől úgy szabadultak meg, hogy azt állították róla, hogy „a házban állandóan ott tartózkodott egy Adangka-Urjangkaj-nemzetségbeli ember, s ő bizonyosan attól való. Erre megalakította a Dzseüirejt-nemzetséget, s ő lett a dzseüiretek őse.” MTT 44 (kvázi apasági vélelem megdöntése)*

⁶⁴ *Монголын нууц товчоо. 75*

⁶⁵ *Ivson, José, Marques Ferreira de Lima: 'Born by the Destiny of Heaven': gender Relations*

тэдний үр удамд өвлөгдөн дамжиж хүчин төгөлдөр үйлчилдэг байв.

“Монголын нууц товчоо”-ны 3-р бүлэгт Хэрэйд аймгийн Ван хан Тоорил нэгэн цагт Есүхэй баатартай анд бололцсоноо санан Тэмүүжинд эхнэр Бөртэг нь мэргэдүүдээс буцаан авахад тусалдаг.⁶⁶ Эцэг нь нэгэн цагт Ван хантай анд бололцсон нь хожим Тэмүүжинд мөн хүчин төгөлдөр үйлчилсэн нь тэр юм. Өнчин ядуус болон тусламж шаардлагатай хүмүүсийг халамжлах нь чухал зан үйл байсан учраас Ван хан хангамжаа нэмэгдүүлэхийн тулд өөрийн овог аймагт тусгай татвар ноогдуулсан: “Өлсөж эцсэн түүнд зориулж Ван хаан тусгай алба (татвар) ногдуулж, дугуй отогт хүлээн авч, бүх зүйлээр хангав.⁶⁷ Хожим нь тэрээр энэ холбоогоо тангараг өргөн баталгаажуулдаг: “Урьд Тэмүжиний сайн эцэг Есүхэй баатар миний бутарсан улсыг аварч цуглуулж өгсөн билээ. Одоо хөвүүн Тэмүжин бас дөрвөн хүлэг баатраа явуулж, миний алдагдсан улсыг аварч олж өгөв. Ач хариулахыг тэнгэр мэдэг.”⁶⁸

Хуурай ах дүүс, анд бололцох хамгийн алдартай цусан тангараг бол Тэмүжин, Жамуха хоёрын хооронд болсон нь тангараг юм.⁶⁹ Багын анд Жамуха нь Тэмүжиний хатан Бөртэг мэргэдүүдээс буцаан авахад нь хүчээ өгдөг. Хоёр найз андын тангаргаа хэд хэдэн удаа шинэчилсэн: “Өвөг дээдсийнхээ уламжлал ёсоор тангараг өргөсөн ахан дүүс, андууд бие биендээ хэзээ ч маш их хүндэтгэл үзүүлж,

амьдралынхаа туршид бие биенээ хамгаалдаг дүрэм юм. Тэд ах дүүгийн харилцаагаа сэргээж, бие биенээ хүндэтгэхээр тохиролцсон.”⁷⁰



Зураг 5: Тэмүүжин болон Жамуха хоёрын андын тангаргаа сэргээж бүсээ солилцож буйг дүрсэлсэн хөшөө. Монгол Улс (Зураг авсан: Фалуш Оршүёо, 2024 оны 5-р сар)

Тал нутгийн морьтон нийгэмд тангараг өргөсөн талууд цусан тангараг өргөхийн хажуугаар ураг барилдан баталгаажуулах нь давхар баталгаа болдог байв. Гадаад болон дотоодын эх сурвалжуудад тэмдэглэгдсэнээр, цусан тангараг болон ураг барилдах хоёр нь хосолсныг монгол нэр томъёонд *анд-худын* барилдлага хэмээн нэрлэдэг байсан. Энэ тухай хамгийн эртний сурвалжууд нь XII зууны сүүл төр улсыг нэгтгэх үеийн

between the Mongols on the Secret History of the Mongols (c. XIII)”. Chinggis Khaan Heritage & Culture, 2023. 2. évf. 3. sz. p. 37-49.

⁶⁶ Монголын нууц товчоо.104

⁶⁷ Монголын нууц товчоо.151

⁶⁸ Монголын нууц товчоо.163

⁶⁹ Монголын нууц товчоо.116-117

⁷⁰ Монголын нууц товчоо. 117

дотоод тэмцлийн үеэс гаралтай. Мөн монголчуудын байгуулсан Юань гүрэн (1271-1368)-ий үеийн сурвалжуудад ч энэ тухай тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэсэнээр, ийм холбоо байгуулсан жишээ бол Есүхэй баатар Дэй Цэцэн хоёрын жишээ юм. Есүхэй баатар ураг барилдах гэж буй хүнээ худ хэмээн нэрлэсэн нь Боржигин болон Хонгирад аймгийн дунд өмнө нь энэ төрлийн холбоо байсныг харуулж байна. Чингис хаан Хонгирад аймгийн удирдагч Тэргэ Эмэлтэй байгуулсан цусан тангаргаа ураг барилдан баталгаажуулдаг.⁷¹ Рашид Ад-Дины тэмдэглэсэнээр⁷², Чингис хаан Баруун Монголын Ойрад аймгийн удирдагч Хутуга бэхитэй мөн адил худ ургийн холбоо байгуулдаг. Хэрэйд аймгийн удирдагч Тоорил хантай эцгийнх нь үед байгуулсан цусан тангаргийг ураг барилдан баталгаажуулахыг хүсэн Чингис хаан ахмад хөвүүн Зүчидээ Ван хан Тоорилын охин Чаур бэхийг гуйж улмаар Сэнгүмийн хөвүүн Тусахад өөрийн охин Хожин бэхийг өгөхөөр санал болгодог.⁷³ Хэрэйд аймгийнхан энэхүү саналыг хүлээж аваагүй тул тэдний хоорондох харилцаа мууддаг.

XIII зууны эхээр Чингис хаан төр улс байгуулахын төлөөх тэмцлийнхээ үед Онгуд аймгийн удирдагч Алакуш Тегинтэй холбоо байгуулж, түүнийг Их хааны алтан ургаас эхнэр авах

боломжийг олгосон. Ийнхүү Их хаан болон Онгуд аймгийн удирдагч нарын хооронд анд-худын барилдлага үүсдэг.⁷⁴ Юань гүрний үеийн сурвалж бичгүүдэд тэмдэглэсэнээр маш олон төрийн өндөр албан тушаалтнууд болон түүний үр удмынхан алтан ургийнхантай анд бололцож, худ ураг барилдах эрхтэй болсон тухай өгүүлдэг.

3.1.2.4. Үрчилж авах

3.1.2.4.1. Бага насны хүүхдийг үрчилж авах

Өнчин хүүхдүүдийг гэр бүлийн гишүүн болгон авч өсгөдөг нь тухайн үеийн монголчуудын нийгмийн хариуцлагын талаарх ойлголтыг баталгаажуулж байв. Үүний тод жишээ бол, хожмын төрийн Их заргач болох татаар гаралтай бяцхан хүүг Чингис хааны эх Өүлэн өсгөж хүн болгодог.⁷⁵ Өүлэн хатан Шихихутугаас гадна өөр гурван хүүхдийг өөрийн хүүхдийн адил өсгөдөг: Өэлүн хатан Мэргидийн нутгаас олсон Хүчү нэрт хөвүүн, Тайчуудын Бэсүдийн нутгаас олсон Хөхөчү, Татаарын нутгаас олсон Шихихутуг, Жүрхиний нутгаас олж авсан Борохул энэ дөрвөн хөвүүнийг өсгөсөн.”⁷⁶

3.1.2.4.2. Томчуудын дунд эцэг хүү бололцох

Ван ханы хөвгүүдийн дундаас хан болж, төр удирдах чадвартай хүн байгаагүй учир Есүхэй баатартай өмнө

⁷¹ Altan Tobcsi (*Arany Foglalat*). *Höhhöt*, 1983. *Népi Kiadó*, 81.1. *magyarázat*

⁷² *Ad-Din, Rasid-ad-din: Jami – at tawarikh*. Ford. Tekin Sinasi -Tekin Gönül Alpay. Cambridge, Massachusetts, 1988. Harvard University Press, II. könyv, II. fejezet, II rész, p. 55.

⁷³ Монголын нууц товчоо.165.

⁷⁴ Egami, Naomio: *Chapters of The Mongol Empire and Christendom*. Tokyo, 2000. Sanpauro, p. 13.

⁷⁵ Монголын нууц товчоо 135

⁷⁶ Монголын нууц товчоо 138

нь өргөсөн цусан тангараг дээрээ үндэслэн түүний хүү Тэмүүжинг хүүгээ болгодог: “Ван хан, Чингис хаан хоёр Туулын хар шугуйд уулзан эцэг хүү бололцдог. Эцэг хүү бололцсон нь дараах түүхтэй холбоотой. Өмнө нь Чингис хааны эцэг Есүхэй баатар Ван хантай ахан дүүс бололцсон учир Чингис хаан Ван ханыг эцгээ хэмээн дууддаг. Энэ нь эцэг хүү бололцохын үндэс нь байсан.”⁷⁷ Нүүдэлчин ард түмний дунд иймэрхүү холбоог худ-ураг барилдан цусан төрлийн холбоогоор баталгаажуулдаг байсан: “Чингис хаан эцэг хүүгийн холбоогоо ураг барилдан улам баталгаажуулахыг хүсэж, ахмад хөвүүн Зүчидээ Ван хан Тоорилын охин Чаур бэхийг гуйж улмаар Сэнгүмийн хөвүүн Тусахад өөрийн охин Хожин бэхийг өгөхөөр санал болгодог.”⁷⁸ Хэдэн жилийн дараа Чингис хаанд дагаар орж тав дахь хөвүүн нь болсон Уйгарын хаан Идүүд Чингис хаан Алалтун бэхи охиноо өгдөг.⁷⁹

3.1.3. Өв залгамжлалын хууль

Кодчилагдсан хууль байхгүй үед заншлын эрх зүйн онцгой чухал элемент нь үхлийн өмнөх гэрээслэл байсан бөгөөд тэр нь зөвхөн цусан талын үр удамд хамаардаггүй байсан: “Монгол овог аймгуудын тодорхой хэсгийн хан нь Хабул хаан байсан. Хэдийгээр түүнд долоон хөвүүн байсан ч Хабул хааны гэрээслэлээр хүү Сэнгүм-билгийн хүү Амбагай Хамаг Монголын хаан болсон.”⁸⁰ Хэрвээ гэрээслэл ёсоор хаан

болох хүн нас барвал түүний цусан төрлийн үр удам нь хаан ширээнд суух ёстой.⁸¹

Есүхэй баатар Тэмүүжинг түүний ирээдүйн хатан болох хүний гэр бүлд үлдээгээд буцах замдаа хуримлаж буй татааруудтай тааралдан тэдэнд хорлогддог: “Есүхэй баатар: “Миний дотор муу байна. Дэргэд минь хэн байна?” гэж асуувал, Хонхотаны Чирха өвгөний хөвүүн Мэнлиг байна гэхэд тэрээр түүнийг дуудан: “Хүү минь, Мэнлиг чи сонс. Хөвүүн минь балчир байна. Тэмүжин хөвүүнийг урагт орхиод ирэх замын зуур татаарт хорлогдов. Дотор минь муу байна. Өнчин хоцорсон дүү нараа, бэлбэсэн бэргэнээ асрахыг чи мэд. Тэмүжин хөвүүнийг даруй явж авчир! Хайрт Мэнлиг минь!” хэмээгээд нас барав.”⁸² Гэрээслэл бичих боломж хомс байсан тул нас барсан тохиолдолд хувийн аман гэрээслэлд захирагдан дагаж мөрддөг байв. Хэрэв өв залгамжлагч насанд хүрээгүй бол асран хамгаалагчийг томилох нь зайлшгүй чухал байв. Монгол заншлаар хамгийн отгон хүү нь эцэг эхээ асарч гал голомтыг нь залгамжилдаг.⁸³ Чингис хааны дүү нараас хамгийн багыг нь Отчигин гэдэг байв. Энэхүү нэр нь *Галын голомтыг сахих* (угсаа залгамжлах) гэсэн утгатай бөгөөд ах нараа тусдаа гарсны дараа тухайн гэрийн голомтыг сахиж үлддэг хүү юм. Чингис хааны багынх нь анд Жамуха: “Өэлүн эхийн отгон хүү өнөөх Отчигин тэр мөн. Эрхэмсэг танхил тэр

⁷⁷ Монголын нууц товчоо 164

⁷⁸ Монголын нууц товчоо 165 *A házasságokat azonban csak tervezték, azonban azok a kereitek ellenállása miatt nem valósultak meg.*

⁷⁹ Монголын нууц товчоо 235

⁸⁰ Монголын нууц товчоо 52

⁸¹ Монголын нууц товчоо 53

⁸² Монголын нууц товчоо 68

⁸³ Монголын нууц товчоо 242

эрт унтдаг боловч эрэлхэг зоригтой отгон хөвүүн учраас орой босдог.”⁸⁴ Их хааны дөрвөн хөвүүний дотроос Тулуй эцгийнхээ гал голомтыг сахиж өнөөгийн Монголын нутгийг авсан.⁸⁵

1219 оны туулай жил Чингис хаан Сартаулын эсрэг өшөө авах аян дайнд мордсон⁸⁶. Энэ үеэр түүний хатдын нэг Есүй хатан хаанд мөнх бус гэдгийг нь сануулж хааныг нас нөгчвөл түүний орыг хэн залгамжлах талаар сануулдаг: “Өндөр давааг давж, Өргөн мөрнийг гэтэлж, Урт аянд мордохдоо улс иргэнээ захирахыг урьдал болгож сэтгэнэ. Төрсөн бие түлбэрэх түмэн амьтны хуулийг төгс ухаандаа санаасай. Уулс мэт бие чинь нурж одвол улс олон Монголыг чинь хэн захирах юм бэ? Тулгуур мэт бие чинь туйвж одвол туг их сүлдийг чинь хэн өргөх юм бэ? Төрсөн дөрвөн хүүгээс чинь төр барих нь хэн бэ?”⁸⁷ Бөртэ хатныг мэргэдээс буцаан авах үед тэрээр жирэмсэн, хамгийн том хүү Зүчи нь гэдсэнд ирсэн, түүний гарал тодорхойгүй байсан ч Чингис хаан түүнийг өөрийн хүүгээ хэмээн өмөөрч бусад хөвгүүдийн адил эрх ямбыг эдлүүлдэг байсан: Чингис хаан: “Зүчийг тэгж хэлж яаж болно? Хөвүүдийн минь ахмад нь Зүчи бишүү? Хожим тэгж бүү хэлтүгэй” хэмээн зарлиг болов.”⁸⁸

Дээрх дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн нэг талаас хүлээн зөвшөөрөгдсөн хүүхэд нь угсаа

залгамжлалтай ижил эрх зүйн статустай байсан хэмээн хэлж болох боловч бодит байдал дээр энэ нь тийм биш байжээ. Учир нь тухайн үеийн гол зүйл нь цусан удмыг цэвэр байлгах явдал байсан. Нөгөө талаас өмнөх жишээнүүдээс харахад хамгийн ахмад нь биш, харин хамгийн чадварлаг хөвүүнийг хаанаар сонгодог байсан байна. Энэхүү шийдвэр нь тухайн ард түмний оршин тогтнох үндэс болдог байсан. Үүн дээр үндэслэн угсаа залгамжлагчид шийдвэр гаргахдаа өөрсдийн дундаас хамгийн тохиромжтой хэмээн Өгөдэйг Их хааны залгамжлагчаар сонгодог.

XVII зуунд бичигдсэн “*Алтан товч*” бүтээлд дурдсанаар Чингис хаан Өгөдэйг залгамжлагчаараа сонгосон шалтгаан нь хаан төрийг удирдахад тэрээр хамгийн тохиромжтой нь байсан байна.⁸⁹ Чингис хаан ийнхүү зарлигдсан байдаг: “Хавсрах нь юу вэ? Эх дэлхий аугаа бөгөөд ус мөрөн олон бий. Харь улсыг эзлүүлэн тус тус салгая. Өөр өөрийн нутгийг өргөтгөж яваарай. Харин Зүчи, Цагаадай та хоёр хэлсэн үгэндээ хүрч, ардын инээдэм, амьтны тоглоом болохгүй, эв найртай яваарай!”⁹⁰ Хамгийн отгон хүү Тулуй “Би хаан эцгийн нэрлэсэн ахын дэргэд байж, мартсаныг сануулж, унтсаныг сэрээж, уриалах дуунд нь уухай болж, унах моринд нь ташуур болж, холын аянд явалцаж, ойрын дайнд оролцож тусалъя” хэмээн андгайлан Чингис

⁸⁴ Монголын нууц товчоо 195. *Otcsigin az, aki a nagykán parancsára birkózás során eltöri a lázadó sámán, Teb-tenggeri, gerincét.* Монголын нууц товчоо 246

⁸⁵ Монголын нууц товчоо 242

⁸⁶ *Dzsingisz kán 100 követét ölték meg a szartaulok előzőleg.* Монголын нууц товчоо 254

⁸⁷ Монголын нууц товчоо 254

⁸⁸ Монголын нууц товчоо 255

⁸⁹ *Altan Tobcsi* 230.

⁹⁰ Монголын нууц товчоо 256

хааны захиасыг хүлээн зөвшөөрдөг.⁹¹

Хатдын нэр хүндтэй байр суурийг нотлох баримт бол тэд өв залгамжлах эрхтэй. Есүй хатан Чингис хааны сүүлчийн аян дайнд хамт явсан бөгөөд 1227 оны гахай жил Чингис хааныг нас барахад түүнд аян дайны олзноос хамгийн их хэсэг нь оногдсон: “Их хаан тэнгэрт халихынхаа өмнө олон тангуд иргэнийг Есүй хатанд өгсөн.”⁹²

Хэдийгээр Чингис хаан өөрийн залгамжлагчаа нэрлэсэн ч уламжлалт хуулийн дагуу 1228 оны хулгана жилийн их хуралдайгаар Их хааныг сонгожээ. Хуралдайн дараа залгамжлагчаар тодруулсан хаанд ширээг шилжүүлсэн.⁹³

Өгөдэй хуралдайн шийдвэрээр хаан ширээнд сууснаар эрх мэдлээ хэрэгжүүлэх эрхтэй болж улмаар шинэ хууль цааз баталж, 1206 онд эцгийнхээ тогтоосон хууль цаазад өөрчлөлтүүд оруулсан.⁹⁴

3.1.4. Хүүхдэд нэр өгөх ёсон: Чингис хаан 1162 онд эхээс төрөхдөө гартаа шагайн чинээ нөж атгаж төрсөн гэсэн домог байдаг. Түүний эргэн тойронд байсан хүмүүс үүнийг тэнгэрийн тэмдэг гэж үзэн шинэ төрсөн хүүд гэрэлтэй ирээдүй байна хэмээцгээв. “Цус нөж” гэсэн ухагдахуунд “төмөр” гэсэн ойлголт мөн холбогддог. Түүний эцэг Монголын хиад боржигон овог аймгаас гаралтай Есүхэй баатар хүүгээ төрөх үед татаар аймгийг дайлаад толгойлогч *Тэмүүжин Үгээг* олзлон ирдэг. Хүүхэд төрөх үед болсон ямар

нэгэн баатарлаг үйл явдлыг бэлэгшээн хүүхдэдээ нэр өгөх нь монголчуудын дунд түгээмэл байсан. Ийнхүү Есүхэй хүүдээ олзлогдсон татаар боолын нэр “*төмөр*” гэсэн утгатай Тэмүүжин нэрийг өгчээ: Энэ нь унгар хэлэнд “дархан” гэсэн утгатай юм. “Тэр цагт Есүхэй баатар Тэмүжин Үгэ, Хори-буха зэрэг татаар хүмүүсийг барьж ирэхэд жирэмсэн байсан Ээлүн үжин, Ононы Дэлүүн болдог гэдэг газар Чингис хааныг төрүүлжээ. Чингис төрөхдөө баруун гартаа шагайн чинээ нөж атган төржээ. Татаарын Тэмүжин Үгэг барьж ирэх цагт тохиолдож төрөв гэж Тэмүжин нэрийг өгчээ.”⁹⁵ Хүүд Тэмүүжин нэрийг өгсөн шалтгаан нь олзны татаар баатар нь маш зоригтой дайчин хүн байсан.



6-р зураг: Дадал сум: Тэмүүжингийн төрсөн нутаг, Монголын зүүн хойд нутаг (Фото зургийг авсан: Фолуш Оршүёо, 2024 оны 5-р сар)

3.1.5. Бэлэг өгөх: Эртний Монголын хуулийн тогтолцооны хамгийн чухал үүргүүдийн нэг бол бэлэг өгөх ёсон байв.⁹⁶ Улс төрийн шалтгаанаар бэлэг

⁹¹ *Монголын нууц товчоо* 255

⁹² *Монголын нууц товчоо* 268

⁹³ *Монголын нууц товчоо* 269. *Lásd még: 3.3.1.*

⁹⁴ *Монголын нууц товчоо* 270

⁹⁵ *Монголын нууц товчоо* 59

⁹⁶ *Rácz Attila: A mongol társadalom és állam alapjai a XIII. században. Dunakavics, 2013. 8. évf. 3. sz. p. 11-30.*

өгөх зан үйл нь овог аймгуудын хооронд анх үүссэн. Энэ тэнцүү хүчнүүдийн дунд харилцан бэлэг өгөх нь эвсэж найрамдах хууль эрх зүйн үйл явц байв. Хүчний харилцаа ялгаатай тохиолдолд нэг талын ашиг сонирхолд нийцүүлэн нөгөөгөөсөө хүч гуйхын тулд нэгэн төрлийн “дайснаас хамгаалах” хүч болсон харилцааг бэлгэддэг байжээ.⁹⁷ “Монголын нууц товчоо”-нд эд хөрөнгө бэлэглэхээс⁹⁸ эхлээд өнчин хүүхдийг бэлэглэх⁹⁹, хаанаас олгосон зэрэг дэв, эрх ямба¹⁰⁰, тэр дундаа бэлчээр ашиглах эрх¹⁰¹ зэрэг тоо томшгүй олон тохиолдлыг тэмдэглэсэн байдаг.

3.1.6. Гэрээ байгуулах, баталгаажуулах, баталгаа өгөх: Бичиг үсэг дутмаг байсан учраас гэрээ хэлэлцээрийг ирээдүй хойч үедээ өвлөгдөн үлдэхүйц тангараг, тахил өргөх хэлбэрээр баталгаажуулан үлдээдэг байв. Тухайлбал, цусан тангараг,¹⁰² адуугаар тахил өргөх,¹⁰³ адислаж уух,¹⁰⁴

найр хийж тангараг өргөх.¹⁰⁵ Цусан тангаргийг алс хол зайтай байгаа талуудын хооронд байгуулсан бол цусаа хусан тагшинд хийж, нөгөө талдаа элчээр илгээдэг байсан. Ийм тохиолдол Ван ханд тохиолддог ба тэрээр тангаргаа зөрчсөндөө харамсаж, өмнөх тангаргаа цусан тангаргаар баталгаажуулдаг: “Ай халаг. Сайн хөвүүнээсээ салж, Сайхан төрөө гутаав, би. Эрхэм хөвүүнээс хагацаж, Эвдрэх үйлийг хийв, би” хэмээн Ван хан өгүүлээд “Одоо хөвүүн (Тэмүжин)-ээ үзэж, муу сэтгэвэл энэ мэт цусаа урсгая” хэмээн андгайлж, чигчий хурууныхаа өндгийг хутгаар хатгаж, цусыг цувируулан хусан саванд хийж “Хөвүүнд минь өг” гэж илгээв.”¹⁰⁶ Гэвч тангаргаа зөрчсөн Ван ханы оролдлогыг Чингис хаан хүлээж аваагүй. Ван хан мөн Итүргэн нэрт элчээ илгээдэг боловч түүнийг урвагч нарт оноодог шийтгэлээр оноожээ: “Чингис хаан Итүргэн элчтэй юм ярилгүй Хасар дээр аваад оч гэдэг. Хасар түүнийг үгийн

⁹⁷ *Mauss, Marcel: Ajándékok és viszonzásuk. In Bohannan, Paul – Glazer, Mark (szerk.): Mérföldkövek a kulturális antropológiában. Budapest-Maidenhead, 1997. Mark Panem–McGraw-Hill, p. 373.*

⁹⁸ *Монголын нууц товчоо 114, 211, 214, 234, 235*

⁹⁹ *Монголын нууц товчоо 135, 137*

¹⁰⁰ *Монголын нууц товчоо 134, 204, 205, 206, 207, 213, 2016, 218, 219, 220, 221, 222, 223, 224, 230, 231, 233, 234, 235*

¹⁰¹ *Монголын нууц товчоо 219. A birodalom valamennyi legelőjének tulajdonosa a nagykan volt. /Ezt a hagyományt a mai napig követi Mongólia, ahol a legelők tulajdonosa az állam.- szerzők/*

¹⁰² *Монголын нууц товчоо 178*

¹⁰³ *Монголын нууц товчоо 141. Ez az áldozati forma a magyarság körében is élt, még a kereszténység felvételét követően is. Dömötör Tekla: „áldozat” In Ortutay Gyula (szerk): Magyar Néprajzi Lexikon. Budapest, 1977. Akadémiai Kiadó*

¹⁰⁴ *Монголын нууц товчоо 141, 189, 219. A mongolok titkos történetéből is tudjuk, hogy a kurultáj befejezését követően a résztvevők közösen áldomást ittak, így szentesítették a határozatokat. MTT 154. Az áldomás szó a mongol forrásban ötök, amelyet a nyelvészek ismeretlen eredetűnek tartanak. Ucsiraltu szerint az etü/ötü gyök az ősi pusztai Földanya kultusszal áll kapcsolatban. Ucsiraltu: A hun nyelv szavai. Ford: Obrusánszky Borbála. Budapest, 2008, Napkút Kiadó, p. 89.*

¹⁰⁵ *Монголын нууц товчоо 163*

¹⁰⁶ *Монголын нууц товчоо 178*

зөрүүгүй шууд цавчин орхиод цогцсыг нь оршуулалгүй хээр хаяв.”¹⁰⁷ Адислаж уух нь андгай тангараг өргөснийг баталгаажуулах ёслолын нэг хэлбэр байсан.

Чингис хаан 1206 оны Их хуралдайгаар Сорхан-шар болон түүний хөвгүүдэд байгуулсан гавьяаг нь үнэлэн төрийн (эрх мэдлийн) “гэрч”-ийн зэрэгтэй албан ёсны адислалыг уугч цол олгохыг зарлигдав. Чингис хаан зарлигтаа “*Нутаг дархалж, мэргэдийн газар Сэлэнгээр ургийн урагт хүртэл нутаг орноо эзэмшиж, нум сумаа агсаж, хурим найр хийж, хундага сөнгөө түшилцэж явтугай. Есөн удаа осолдоход зэмлэхгүй болгоё!*” хэмээн зарлигдав.”¹⁰⁸

3.2. Эрүүгийн хууль

3.2.1. Гэмт хэрэг

3.2.1.1. Өөрийгөө шийтгэх, өшөө авах, цусан өшөө авах

Хүчээр булаан авсан эд хөрөнгө, эмс охид болон бусад эд хөрөнгөө сайн дураараа эргүүлэн авах, өөрийгөө зөвтгөх, цус урсгах зэрэг нь тухайн үеийн Монгол төрийн хууль эрх зүйн тогтолцоонд хүлээн зөвшөөрөгдсөн үйлдэлд тооцогддог байв.¹⁰⁹ Эдгээр

үйлийг хийж чадахгүй бол хулчгар, жигшмээр хүнд тооцогддог байв.

Өшөө авалт нь уй гашуутай адилхан хэмжээтэй байгаагүй бөгөөд гол зорилго нь урьдчилан сэргийлэх явдал байв. Түүхэнд тоо томшгүй олон тохиолдлыг дурдсан байдаг бөгөөд Жөчи-Дармала агтыг нь хулгайлсан Жамухын дүүгийн нурууг хуга харван алаад адуугаа буцааж аваад ирдэг.”¹¹⁰ Харгисаар өшөө авах тохиолдол голдуу хүнлэг бус цуст дайсагналтай тулгардаг байв. Тухайлбал, Жамуха дүү Тайчарынхаа өшөөг авахын тулд чинос овгийн залуусыг далан тогоонд буцалгаж, Нэгүдэй цагаан гуагийн толгойг огтолж морины сүүлэнд чирч оджээ.”¹¹¹ Чингис хаан эртний өстөн дайсан болох татаар аймгийг олон удаа довтлон талан дээрэмдэж, боол болгон авчирдаг: “Өшөө авахдаа тэрэгний дугуйнаас өндөр хүмүүсийг нь хөнөөн устгав.”¹¹² Амьд үлдэгсдийг боол болгон овог аймгуудын дунд тараадаг.”¹¹³

Их хаанд дагаар орчихоод дараа нь амлалтаасаа няцсан улс үндэстнүүд бас байдаг. Үүний тод жишээ бол, Тангуд улс бөгөөд тэд дайн тулааны үед баруун гар нь болж мордоно гэсэн амлалтаасаа няцсанаар Чингис хааныг хилэгнүүлжээ. Тиймээс Чингис хаан

¹⁰⁷ Монголын нууц товчоо 184

¹⁰⁸ Монголын нууц товчоо 219

¹⁰⁹ Монголын нууц товчоо 136

¹¹⁰ Монголын нууц товчоо 128

¹¹¹ Монголын нууц товчоо 129

¹¹² A „tengelyszöghöz mérés” azt jelentette, hogy azokat a fiúgyermekket, akik a székér kerékszőgénéл magasabbak voltak, lekaszabolták, mivel potenciális ellenségnek számítottak már, míg az annál kisebb gyermekeket hazavitték és a sajátjukként nevelték fel. A lányokat általában szétosztották a győztesek között, hol feleségnek, hol ágyasnak, hol szolgálónak. Dzsingisz kánnak két tatár felesége is volt.

¹¹³ Монголын нууц товчоо 154. A bosszú alapja az volt, hogy Dzsingisz kán apját a tatárok megmérgezték, az egyik ösét pedig elfogták és faszamárra szögezve megölték. Hasonló esetek: MTT 240, 251, 256, 265-266

1226 оны нохой жилийн намар ял асуухаар цэрэглэн хөдөлдөг. Тэднийг ялан дийлээд ард түмнийг нь боол болгосон.¹¹⁴ Андгай тангаргаасаа буцсан Тангудын хаан Бурканг бараалхахаар ирэхэд нь Чингис хаан: “Буркан хааныг хаалттай хаалганы цаанаас Чингис хаан сонсдог, түүнийг сонсоод Чингис хааны дотор муухайрдаг. Гурав дахь өдөр нь Чингис хаан зарлиг буулгаж, Илуку Бурканд бууж өгсөн хэмээгээд Сидурку хэмээх нэр өгч, Илуку-Буркан Сидурку хэмээн нэрлэдэг. Энэ үеэр Илукуг өөрийн гараар устга хэмээн Толун-Чэрбид”¹¹⁵ үүрэг өгдөг.

3.2.1.2. Олзлох, дээрэмдэх: Эмэгтэйчүүдийг булаахаас¹¹⁶ гадна довтолсон улсаа тонож дээрэмдэх нь ердийн зан үйл байсан: “Чингис хаан Ван хан нар татаарыг довтолон дайны олзоо хуваагаад буцан хүрээндээ ирсэн.”¹¹⁷

3.2.2. Ял шийтгэл

3.2.1. Ял үүрэх”

Өндөр хэргэм зэрэгтэй эсвэл зочин хүн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ял шийтгэлийг өгөхдөө түүний оронд харьяат албат эсвэл хамааралтай хүнд нь ял үүрүүлэх тохиолдол гардаг байсан. Тогооч Шихүр занчигдсаныхаа

дараа ийн өчиж уйлдаг: “Есүхэй баатар, Нэгүн тайж хоёр үгүйн тул ингэж занчигдав.”¹¹⁸

Хоёр овог, аймгийн ахлагч нар нийлж хуримлах найрлах үед зочдын нэг нь гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд зочныг хүндэтгэж, эрхийг хангах нь гол асуудал байсан. Хурим найрыг зохион байгуулагч овог аймгийн төлөөлөгчид буруутай хүнд шийтгэл оногдуулахын оронд өөр хооронд нь барилдуулж, асуудлыг шийдвэрлэнэ.¹¹⁹ Өрнө зүг хийсэн аян дайны үеэр буюу Унгар руу довтолохоос өмнө Бат хаан болон Их хаан Гүег хоёр муудсан шалтгаан нь ялалтаа тэмдэглэж найрлах явцад Бат хаан цэргийн гол жанжны хувьд түрүүлэн сархад барьснаас болсон байдаг. Гүег бол ирээдүйн хаан ширээ залгамжлагч байсан учраас үүнд гомдон найрыг орхин явдаг.¹²⁰ Энэхүү маргаан нь маш ноцтой байсан тул аян дайныг амжилттай явуулахын тулд Өгөдэй хаан хүүгээ цэргийнх нь хамт буцаад дуудсанаар тэд 1240 оны хулгана жил Монгол нутагтаа буцан ирсэн.¹²¹

3.2.2. Цаазын ял оноох: Шийтгэх зорилгоор тал нутгийн ард түмний голчлон ашигладаг яллах хэлбэр нь цаазаар авах ял байв. Энэ нь цусан

¹¹⁴ Монголын нууц товчоо 265-266

¹¹⁵ Монголын нууц товчоо 267

¹¹⁶ *Lásd:* 3.2.1.1.

¹¹⁷ Монголын нууц товчоо 134 *Továbbá: MTT 153, 154, 277, 274. A Yassában is külön rendelkezés szolt a rablás, fosztogatás szabályozásáról: „Minden katonának a harcra kell összpontosítani, tilos fosztogatni a javakat. Háború idején, ha a sereg arra kényszerül, hogy meghátráljon, a katonáknak küzdeniük kell. Azokat, akik nem ezt teszik, ítéljék halálra. Amikor az ellenséget legyőzték, az eldobott javakat nem szabad elvinni, hanem azokat a harc végén szabad csak szétosztani egységes módszer alapján”.*

¹¹⁸ Монголын нууц товчоо 130

¹¹⁹ Монголын нууц товчоо 131

¹²⁰ Монголын нууц товчоо 275

¹²¹ *Ad-din*, 1988. II. 328.

өшөө авалтын¹²² нэг хэлбэр болохоос гадна андгай тангаргаасаа няцах, үнэнч бус байх, урвах, тушаалаас татгалзах, дуулгаваргүй байх зэрэг цэргийн гэмт хэрэгт ашиглагддаг байв. Оргодол орогнуулж нуугдуулах зэрэг нь урвасанд тооцогддог байв.¹²³ Цаазаар авах ялыг илүү өршөөнгүй (“давуу эрх”) гүйцэтгэх тохиолдолд гэмтний цусыг урсгахгүйгээр хөнөөдөг байсан. Мөн гэмт хэргийн хэр хүнд эсэхээс нь шалтгаалж, шаардлагатай бол цусыг нь урсган хороож, цогцсыг нь булахгүйгээр үлдээх, зарим тохиолдолд шууд хээр хаядаг байжээ.¹²⁴ Сача Тайчу хэлсэн үгэндээ хүрээгүй тул тийм шийтгэл авдаг: Чингис хаан: “Урьд бид юу гэж хэлэлцсэн билээ?” гэвэл, Сача Тайчу хоёр өгүүллрүүн: “Бид хэлсэн үгэндээ хүрээгүй бол үгэндээ хүргэ” гэхэд тэдний урьд хэлэлцсэн үгийг сануулж, тэднийг бүтээж алаад оршуулалгүйгээр цогцсыг нь орхидог.”¹²⁵

Чингис хааны багын анд Жамуха мөн адил хэлсэндээ хүрээгүй урвасан хэргээр цус гаргалгүйгээр цаазлуулдаг: “Анд нөхөр минь соёрхож, Амийг минь үтэр тонилговол, Ариун зүрх чинь амарч, Амгалан жаргах болно, Анд чи соёрхож, Асгарах цусыг гаргалгүй, Алуулж өршөө намайг хэмээн Жамуха өчдөг.”¹²⁶ Чингис хаан түүний дүү Хасартай муудан бага дүү Отчигиныг нь гутаан доромжилсон Тэв тэнгэр бөөгийн амийг

мөн адил цус гаргалгүйгээр хөнөөдөг. Түүний цусыг гаргалгүйгээр нурууг нь хугалан хөнөөв. Чингис хаан нэгэн бор гэрийг авчруулж, Тэв тэнгэрийн дээр нь бариулаад гэрийн өрхийг нь бүтээж, үүдийг дарж хүнээр сахиулбал, гурав дахь шөнө нь үүр цайх үеэр гэрийн өрх нээгдэж, Тэв тэнгэрийн цогцос түүгээр гаран алга болдог.”¹²⁷

3.2.3. Гутаан доромжлох: “Бага зэргийн зөрчил гаргасан тохиолдолд ард иргэд дургүйцлээ илэрхийлж, нүүр рүү нь нулимдаг: “Бусдыг нь гавлан ташуурдан хөөн оруулж ирэхэд Ван хаан тэдэнд: “Уйгар нутгаар тангуд газраар яаж явсан гэж та нар хэлсэн бэ? Та нар муусайн юу гэж бодов?” гээд нүүр рүү нь нулимж, гэрт байсан ард цөмийг босгон нулимуулж, тэдний хүлгийг тавиулав.”¹²⁸ Мөн доромжлол нь үл хүндлэлтэй холбоотой байж болно. Яг ийм тохиолдол Чингис хаан найман аймгийн толгойлогчийн эхтэй нь уулзахад тохиолддог: Чингис хаан Таян хааны эх Гүрбэсүүг дуудан ирүүлээд ийнхүү өгүүлдэг: “Чи монголчуудаас өмхий үнэртдэг гэж хэлсэн? Тэгээд чи юунд ирээв? гэж хэлээд түүнийг өөртөө авдаг.”¹²⁹ Доромжлолын өөр нэг хэлбэр нь тухайн хүнийг хаан хүлээж авалгүй зөвхөн гэрийн хананы цаанаас ярих¹³⁰ эсвэл түүнд дорд үзсэн нэр¹³¹ өгөх байв. Төрийн өмчөөс хулгайлан үрэн таран хийж хайхрамжгүй хандсан хүмүүсийн

¹²² *Lásd: 3.2.1.1.*

¹²³ *Монголын нууц товчоо 87. Lásd még: Dashtsedен 1990. p. 42*

¹²⁴ *Монголын нууц товчоо 140; 188*

¹²⁵ *Монголын нууц товчоо 137. További példa: Монголын нууц товчоо 149*

¹²⁶ *Монголын нууц товчоо 200-201*

¹²⁷ *Монголын нууц товчоо 245-246*

¹²⁸ *Монголын нууц товчоо 152*

¹²⁹ *Монголын нууц товчоо 196*

¹³⁰ *Монголын нууц товчоо 267. Lásd még: 3.2.1.1.*

¹³¹ *Монголын нууц товчоо 267: Burkannak a Sidurku (Meghódolt) nevet adta Dzsingisz kán; MTT 277: Altan kánnak a Szeüsze (Legény) nevet adta Ögödej kán.*

хамрыг хутгаар тасдаж шийтгэдэг байв.¹³²

3.2.4. Хаан өршөөл үзүүлэх: Эсрэг талын овог аймгуудын цэрэгт тулалдаж явсан хүмүүс өөрийн хаандаа өргөсөн тангарагтаа үнэнч байх тохиолдлууд байсан. Чингис хаан өөрөөс нь болон дайсных нь удирдагчаас урвасан хүнийг уламжлалт заншлын дагуу шийтгэдэг байсан бол түүний эсрэг тэмцэж өөрийн хаандаа үнэнч үлдсэн хүмүүст өршөөл үзүүлдэг байсан. Энэ нь тухайн үеийн тал нутгийн ард түмнүүд, овог аймгуудын дундах цэргийн цааз буюу “олон улсын” хуулийн цар хүрээг харуулж байна: “Чингис хаан: “Хууль ёсны хаанаасаа урвалгүй тулалдаж, хаанынхаа амийг авран зугтаалгаж буй хүн бол эр хүн юм? Ийм хүнтэй нөхөрлөх нь зохистой” хэмээн хэлээд түүний амийг өршөөдөг.”¹³³ Чингис хаантай ийм замаар нөхөрлөсөн хүмүүсийн нэг бол Наяа юм. Тэрээр өмнө түүний дайсан Таргудай Хирилтугийн албат байсан ч толгойлогчоосоо урваагүй.¹³⁴ Чингис хаан түүнийг үнэлж, сүүлд Наяаг төвийн түмнийг захирах ноён болгодог.¹³⁵ Тэрээр байлдан дагуулагдсан ард түмнийхээ толгойлогчдын охидыг өөрийн гэр бүлийн гишүүдтэйгээ гэрлүүлэн худ ураг болж аав, ах нарыг нь өршөөж байсан тохиолдол байдаг: Тухайлбал, Ван ханы дүү Жаха-хамбугийн хоёр

охины эгчмэд болох Ибагаг Чингис хаан өөрөө авч, дүү Сорхагтанийг хөвүүн Тулуйд өгдөг. Иймээс Жаха-хамбугийн харьяат иргэдийг довтлон талж дээрэмдээгүй, харин Жаха-хамбуг тэрэгний нөгөө арал мэт яв хэмээгээд түүнийг соёрхон өршөөдөг.”¹³⁶ Өөр нэгэн сурвалжид тэмдэглэснээр Чингис хаан түшмэдийнхээ зөвлөснөөр дайны олзоо өөртөө үлдээсэн гурван хүүгээ ялаас хэлтрүүлдэг.¹³⁷

3.2.5. Дархан – “ялаас хэлтрүүлэх”: Дархан хэмээх хүндэтгэгдсэн хүн ял шийтгэлээс есөн удаа чөлөөлөгдөнө гэсэн үг юм: “Одоо бүгдийн дээр суулгаж, есөн удаа осол гаргавч ял хэлэлцэхгүй болгоё.”¹³⁸ Мөн хүндэтгэлийг Тэмүүжинтэй хамт өссөн Зэлмэ¹³⁹ болон Чингис хааны хоёр хүүгийн амь насыг аварсан Борохул нар авдаг.¹⁴⁰

3.3. Нийтийн эрх зүй: Нийтийн эрх зүйн элементүүд нь гол төлөв хаан сонгох 1206 оны Их хуралдайн шийдвэрүүдэд тусгагдсан байдаг. Төрийн Их заргачаар Шихихутугийг томилж, хууль цаазыг бичгээр үйлдэснээр Их Монгол Улсын хууль цаазын эрин эхэлсэн.

3.3.1. Ардчилсан сонгууль: Хааныг ард түмний Их хуралдайгаар сонгодог. Чингис хааныг 1206 онд Их хаанд өргөмжилсөн.¹⁴¹ Өөр нэгэн сурвалжид тэмдэглэснээр: “Тэгээд эсгий туургатан улс энх шударга болж, барс жил

¹³² Монголын нууц товчоо 280. *Lásd:* 3.3.2.

¹³³ Монголын нууц товчоо 185

¹³⁴ Монголын нууц товчоо 149

¹³⁵ Монголын нууц товчоо 220

¹³⁶ Монголын нууц товчоо 186

¹³⁷ Монголын нууц товчоо 263. *Lásd még:* 3.4.5.

¹³⁸ Монголын нууц товчоо 203

¹³⁹ Монголын нууц товчоо 211

¹⁴⁰ Монголын нууц товчоо 214 *További említésék:* Монголын нууц товчоо 219,

¹⁴¹ Монголын нууц товчоо 123

(1206) Онон мөрний эхэнд хуралдаж, есөн хөлт цагаан тугаа мандуулаад Тэмүжинд Чингис хаан (Далай хаан) цолыг өгөв.”¹⁴² Ардчилсан сонголтын хамгийн тод жишээ бол Өгөдэй хааныг хаан ширээнд залахтай холбоотойгоор илэрдэг. Хэдийгээр тэр Чингис хааны хамгийн том хүү байгаагүй ч ах дүүс нь түүнийг хаан суухад хамгийн тохиромжтой хэмээн үзсэн. 1227 онд эцгийгээ нас барахад тэрээр шууд их хаан бололгүй 1228-оны хуралдайн шийдвэрээр хаан болдог.¹⁴³ Их хаан Өгөдэй төр барьж байх хугацаандаа хийсэн дөрвөн сайн болон дөрвөн муу зүйлийнхээ талаар хожим нь Их хуралдайд тайлагнадаг нь ардчиллын нэг хэлбэр юм. Сайн зүйлсийнх нь талаар дурдвал тэрээр Алтан улсыг¹⁴⁴ довтлон эрхшээлдээ оруулдаг; шуудан харилцаа өртөөг бий болгосон; усгүй газруудад худаг бий болгосноор бэлчээр, ус ундны гачигдлаас ангижирсан.”¹⁴⁵ Түүний муу зүйлсээс дурдвал архинд донтох, эмсийн үгэнд орох, Отчигин ноёны харьяат нутгаас хүүхнүүд авчруулсан; Чингис хаанд амь насаа үл хайхран зүтгэсэн Доголхуг нууцаар хөнөөлгөсөн; байгалийн хуулийг зөрчиж: “Тэнгэр газрын заяагаар төрсөн гөрөөсийг бусад ах дүү нарын нутагт очих болуузай гэж харамлаж, шавар хэрэм бариулж, ах дүү нараасаа гомдлын үгийг сонссон,”¹⁴⁶ Өгөдэй хаан олон нийтийн өмнө өөрийнхөө сайн мууг дэнсэлсэн нь XIII зууны үеийн

Европын эрх баригчдын дунд ер бусын байсан байж магадгүй юм.

“Монголын нууц товчоо”-ны 12 дугаар бүлгийн 282-р хэсэг нь дараах өгүүлбэрээр төгсдөг: “Их хуралдай болж, хулгана жилийн (1240) хуран (долдугаар) сард Хэрлэний Хөдөө арлын Дэлүүн болдог, Шилхинцэг хоёрын завсар хааны орд бууж байхад бичиж төгсгөв.”¹⁴⁷ Он сар өдөр, газрыг үнэ бодитоор зааж өгсөн нь түүх бичигчийн өгүүлсэн үйл явдал бодитой болохыг харуулж байна.

Албан бичгийн эхлэлийг тавьсан өөрчлөлтийг номын зохиолч тод харуулж өгсөн; Тухайлбал, өнөөгийн гэрээтэй адил хууль зүйн баримтыг албан ёсны болгож баталгаажуулдаг болсон бөгөөд энэ мөчөөс эхлэн адуугаар тахилга хийх, цусан тангараг өргөж гэрээг баталгаажуулах шаардлагагүй болсон байна.

3.3.2. Эрх мэдлийн хуваарилалт: Хууль тогтоох эрх мэдлийг хуралдайгаар хэрэгжүүлдэг байсан. 1206 оноос шүүх эрх мэдлийг хааны эрх мэдлээс салгасан. 1206 оны хуралдайн хамгийн шинэлэг шийдвэр нь бичиг үсэгтэй Шихихутугийг төрийн Их заргачаар томилсон явдал бөгөөд тэрээр уламжлалт хуулийн хэрэгжилтийг “Хөх дэвтэр”-т тэмдэглэдэг болсон.¹⁴⁸

Чингис хааны залгамжлагч Өгөдэй хаан өөрийн ууган хүү Гүюгийг

¹⁴² Монголын нууц товчоо 202. *Temüdzsinből már 1189-ben lett Dzsingisz kán (eredeti kiejzése: Csingisz-hatalmas, nagy, tenger jelentésű szó), amikor a hamag mongol fejedelemség vezetőjévé választották.*

¹⁴³ Монголын нууц товчоо 269-270

¹⁴⁴ *Az Észak-Kínát uraló Jin-dinasztiára utaló név.*

¹⁴⁵ Монголын нууц товчоо 281

¹⁴⁶ Монголын нууц товчоо 281

¹⁴⁷ Монголын нууц товчоо 282

¹⁴⁸ Монголын нууц товчоо 203

зөвлөхүүдийнхээ зөвлөснөөр шүүгч заргачдын шийдвэрийн дагуу шийтгэсэн байдаг.

Чингис хааны гэрээслэлээр хээр болсон асуудлыг хээр шийддэг, гэр бүлийн асуудлыг гэр дотроо шийдэх ёстой байсан: “Хээр болсон хэрэг тул үүнийг Бат шийтгэвэл зохино. Гүүг Аргасун хоёрыг Бат мэдтүгэй!”¹⁴⁹ Их хаад шүүх эрх мэдлээс гадна гүйцэтгэх эрх мэдлийн тодорхой салбаруудад үйл ажиллагаа явуулдаг төрийн янз бүрийн алба, эрх мэдлийн бүтцийг байгуулсан. Тухайлбал, Өгөдэй хааны байгуулсан бэлчээр хариуцсан даамал юм: “Ард иргэн, уужим суухыг хүснэ. Чанай, Уйгуртай хоёр тэргүүтэй нутагчныг явуулж, говь цөлд худаг малтуулж хашууль”¹⁵⁰ Үүний өөр нэгэн баталгаа бол үр тарианы агуулах хариуцсан даамлуудыг томилсон явдал юм.¹⁵¹ Өртөө шуудангийн үйлчилгээг бий болгосон нь төрийн маш нарийн шинэлэг зохион байгуулалтын хэлбэрийг харуулж байна.¹⁵²

Нийтийн өмчид хайр гамгүй хандсан хүнийг маш хатуу цээрлүүлэхээр зарлигдсан байдаг: “Хэрвээ өртөө хариуцсан хүмүүс, улаачид улааны морь, шүүсний хонь, саалийн гүү, хөллөх үхэр, ачих тэрэг зэргийг тогтоосон хэмжээгээр бэлтгэж, охор шидэмс дутуулбал уруулын хагасыг огтолно. Халбага хигээс дутуулбал хамарын хагасыг огтолно.”¹⁵³

3.3.3. Аян дайнаас үүдэн бэлэвсэрсэн эмэгтэйчүүд, өнчирсөн хүүхдүүдэд төрөөс олгох халамж, тэтгэмж: Цэргийн зохион байгуулалттай аян дайнч ард түмэн тулааны талбарт амь үрэгдэгсдийн ар гэр, эхнэр хүүхэд төрөл төрөгсдийг халамжлах асуудлыг маш амжилттайгаар шийдвэрлэсэн байдаг. Бэлэвсэрсэн эхнэр, өнчирсөн хүүхдүүдэд төрөөс зохион байгуулалттайгаар янз бүрийн хөнгөлөлт, халамж, тэтгэмж олгодог байсан: “Хуилдарын зүтгэсний тул түүний ургийн ураг хүртэл өнчдийг тэтгэх хишгээс хүртэж яв” гэж зарлиг болгов.¹⁵⁴

“Монголын нууц товчоо”-ны 12 дахь бүлэгт, дайнаас бэлэвсэрсэн эхнэр, өнчирсөн хүүхдүүдэд олгох халамж тэтгэмжийг Чингис хаан жагсаасан байдаг: “Чингис хаан, Цагаан гуагийн хөвүүн, Нарийн-Тоорилд өгүүллүүн: “Чиний эцэг Цагаан гуа чинь зоригийг барьж байлдсаар Даланбалжудын байлдаанд Жамухад алагджээ. Одоо эцгийн гавьяаг хүртэж, өнчдийн тусламжаас авч бай.”¹⁵⁵ гэжээ.

3.3.4. Нийгмийн хууль: Их хаан тулааны үед удирдлагагүй болсон хэвтүүлүүдийг цуглуулан мянгат болгож, хонь хариулагч Дэгэйд захируулав.¹⁵⁶ Өгөдэй хааны авсан хамгийн чухал арга хэмжээнүүдийн нэг нь ядууст санаа тавих явдал байв. Тиймээс Өгөдэй хаан бусдын тусламжийг санхүүжүүлэхийн тулд хонины хөлийн татвар авахаар шийдвэрлэсэн: “Хаан эцгийн бэлэн

¹⁴⁹ Монголын нууц товчоо 277

¹⁵⁰ Монголын нууц товчоо 279

¹⁵¹ Монголын нууц товчоо 280

¹⁵² Монголын нууц товчоо 280

¹⁵³ Монголын нууц товчоо 280

¹⁵⁴ Монголын нууц товчоо 185

¹⁵⁵ Монголын нууц товчоо 218

¹⁵⁶ Монголын нууц товчоо 222

суурийг эзлээд иргэнийг үл зовоохыг эрхэм болгоно. Шөл шүүс болгож харьяат улсын сүрэг хонь бүрээс нэжгээд хонь жил тутам авч байна. Зуун хониноос нэжгээд хонь гаргаж, улсын доторх үгээгүй ядуусын тусламж болгож өгтүгэй. Бас олон ах дүү эр цэрэг, агт морь дарааллан чуулах бол чуулагсдын ундыг тухай бүр ардаас татварлан авах нь зохилдохгүй.”¹⁵⁷

Өгөдэй хааны хийсэн шинэчлэлүүдээс дурдвал нийтийн агуулах бариулсан, худаг гаргасан, ус бэлчээрийг хүн амд хуваарилсан зэрэг юм: “Бас улс иргэнийг нутаг усыг хувааж өгье. Нутгийг хувааж сонгож нутаглахад мянгат бүрээс нутагчныг ялгаж гаргавал болно.”¹⁵⁸

3.4. Тулааны хууль, байлдааны журам

3.4.1. Цэргийн зохион байгуулалт

Чингис хаан 1206 оны хуралдайгаар сонгогдсоныхоо дараа Монголын төрийн бүтцийг шинэчилсэн. Энэ ажлынхаа хүрээнд тэрээр цэрэг болон аймгийн толгойлогчдыг салгаж овог, аймгийн хамаарлыг сулруулсан. Эзэлж авсан ард түмнээ эрт цагт байсны адилаар 10-тын системээр 10, 100, 1000, 10000-т хуваадаг байсан.¹⁵⁹

Сударт өгүүлснээр, 1206 онд 95 түмтийг байгуулсан: “Ойр иргэдийг оруулалгүйгээр Чингис хаан

монгол овог аймгуудаас 95 түмтийг байгуулсан.”¹⁶⁰ Удирдан чиглүүлж, тушаал өгөх, хариуцлага тооцох эрхийг тодорхойлохгүйгээр дайны ажиллагаа амжилтад хүрэхгүй тул Их хаан аян бүрийг тодорхой хүнээр удирдуулахаар томилдог байсан. Хаан гэрээслэлээ үлдээхдээ Өгөдэй хааныг залгамжлагчаараа нэрлэсэн.¹⁶¹

Нэг овог аймгаас гаралтай цэргүүдийг цуг нэг бүрэлдэхүүнд хуваарилах нь маш ховор байсан бөгөөд сайн дураараа дагаар орсон овгийн захирагчид онцгой ач ивээл болгож, цугт нь хуваарилах явдал мэр сэр байсан: “Сартуул хүмүүсийн дотроос Ялалавачи болон Маскут нарыг тухайн хотуудын зан заншил хууль цаазыг сайн мэддэг байсан тул Хятад улсыг захирах монгол дарга нарын дэргэд зөвлөгчөөр томилсон.”¹⁶² 1228 оны хуралдайгаар Чингис хааны залгамжлагчаар сонгогдсон Өгөдэй хаан ах Цагаагадын зөвлөснөөр гэр бүл болгоноос хамгийн ахмадыг нь аян дайнд оролцуулахаар болсон: “Хөвүүдийн ах аялбал цэрэг арвин болно. Цэрэг олон бол үзэгдэх сүр хүч их болно. Тэнд дайсны хүн үлэмж, харийн улс олон бий.”¹⁶³ Энэхүү шинэчлэгдсэн цэргийн хүч нь дараа нь Эзэнт гүрнийг хадгалж үлдсэн. Учир нь шинээр байлдан дагуулсан ард түмэн энэ системд амархан багтах боломжтой байв.

¹⁵⁷ Монголын нууц товчоо 279

¹⁵⁸ Монголын нууц товчоо 279. *A legelőfelügyelet kvázi közigazgatási hatóságként működött. A feladata annak biztosítása volt, hogy a nagykán tulajdonában álló legelőket megfelelően használják azok, akik erre használati jogot kaptak. Lásd még: 3.1.6., 3.3.2. Említi a legelőfelügyeletet Dashtsedен is: Dashtsedен 1990. p. 46.*

¹⁵⁹ Монголын нууц товчоо 224

¹⁶⁰ Монголын нууц товчоо 202

¹⁶¹ Монголын нууц товчоо 258. *Lásd még: 3.1.3.*

¹⁶² Монголын нууц товчоо 263

¹⁶³ Монголын нууц товчоо 270

3.4.2. Харуул хамгаалалт зохион байгуулалт: Эзэнт гүрний удирдлага их хааны гарт төвлөрч байсан тул түүний аюулгүй байдалд ихээхэн ач холбогдол өгч байв. Тиймээс хэвтүүл болон харуулын бүрэлдэхүүнийг онцгой анхаарч зохион байгуулсан.¹⁶⁴ “Монголын нууц товчоо”-ны 10-р бүлэгт тэднийг шагнаж, өргөмжлөл цол хүртээсний дараа хаан ширээнд суух хүртэл нь итгэлийг хүлээн хамт байсныг дурдан талархал илэрхийлсэн талаар тэмдэглэсэн байдаг.¹⁶⁵ Чингис хааны бие хамгаалагч арван мянган хэвтүүл цэргийг хамгийн бяр чадалтай ерэн таван мянган цэргийн дотроос сонгодог. Их хаан өөрөө болон түүний залгамжлагчид нь тэднийг анхаарч халамжлах үүргийг хүлээдэг.¹⁶⁶ Шөнийн хэвтүүл харуулын үүргийг их хаан нарийн тодорхойлсон байдаг бөгөөд харуул хамгаалалт хэвтүүл цэргийн үүрэг гүйцэтгэж буй тэдгээр чербинүүдийг дайнд мордуулбал хариуцлага тооцохоор хуульчлан цэргийн дайчилгаанаас чөлөөлж, дайнд явбал зөвхөн хааныг хамгаалж явахаар зарлигдсан байдаг: “Олон давхар ажил эрхэлдэг тул тэднийг аян дайнд явуулахгүй”.¹⁶⁷ Хэвтүүл хамгаалагч нарын хоорондын зөрчил маргааныг төрийн Их зарагч Шихихутугийг оролцуулан шийдвэрлэж, хөсөг тэрэг, адуу мал болон арын албаны захирагчаар Додай чэрбиг томилсон:

¹⁶⁴ Монголын нууц товчоо 225-229

¹⁶⁵ Монголын нууц товчоо 230

¹⁶⁶ Монголын нууц товчоо 231

¹⁶⁷ Монголын нууц товчоо 232-233

¹⁶⁸ Монголын нууц товчоо 234

¹⁶⁹ Монголын нууц товчоо 278

¹⁷⁰ Lásd: 3.2.2.

¹⁷¹ Монголын нууц товчоо 153. Ezt a taktikát alkalmazták a Magyar Királyság területén is 1241-ben, amikor menekülést szinleltek, majd visszafordulva megtámadták az őket üldöző magyar sereget. Ezt a harcmodort korábban még a honfoglaló magyarok is alkalmazták.

“Бүх хишигтэн, торгууд ба ордны дэргэд явах хөвүүд адуучин, хоньчин, тэмээчин үхэрчнийг Додай чэрби захиртугай”, “Додай чэрби, хотол ордны хойноос дагаж, хог идэж, хомоол түүж явтугай” хэмээн зарлигдсан.”¹⁶⁸

Өгөдэй хаан эцгийнхээ үндэслэсэн хишигтэн хэвтүүл цэргийн үүргийг шинэчлэн боловсронгуй болгосон. Энэ нь бие бүрэлдэхүүнийг хариуцах захирагчийг томилж, цэргийн гэмт хэрэгт оногдуулж, хариуцлага тооцох хатуу шийтгэлийн төрлүүдийг тодорхойлсон. Их хаан цэргийн эрх мэдлийг өөртөө авсан.¹⁶⁹ Их Монголын төр нь цэргийн зохион байгуулалтанд тулгуурласан улс байсан бөгөөд цэргийн хэргийг шүүх, хариуцлага тооцох арга зам нь цэрэг армийг хүчирхэг, үр дүнтэй ажиллуулах чухал хэрэгсэл болсон юм.

3.4.3. Байлдааны журам, тактикийн дүрэм

3.4.3.1. Зугтсан дүр эсгэх

Цэрэг арми нь амь насаа алдах эрсдэлтэй хатуу тушаалыг хаанаас авдаг.¹⁷⁰ “Дайсныг дарах цагт олзонд бүү саатагтун. Дайсан нэгэнт дарагдвал тэдний юм хэзээ ч бидний олз болох тул хувааж амжина. Хэрэв бид ухрахад хүрвэл анх довтолсон байрандаа даруй эгж ирвэл зохино. Уг байрандаа эгж ирээгүй хүнийг алтугай.”¹⁷¹ Энэхүү цэргийн тактиктэй холбоотойгоор

ийнхүү тэмдэглэсэн байдаг: “Хэрэв дайсныг бүсэлвэл тэдний шугам цэгцтэй хэвээр үлдэнэ. Тэд ухрахдаа цэгцтэй байдаг.”¹⁷²

3.4.3.2. Дайснаа хуурах: Тэдний сайн мэддэг тактик бол дайснаа төөрөгдүүлэх байв. Үүний нэг жишээ нь 1204 онд Найман аймагтай дайтахдаа хэрэглэсэн арга бөгөөд тэд байлдахынхаа өмнө шөнө цэрэг бүр таван түүдэг асааж, цэргээ тоо томшгүй олон мэт харагдуулж дайснаа хууран мэхэлдэг.¹⁷³ Цэргээ дагуулан тогтсон замаар давшилгүй, дайсныхаа урьдчилан тооцоолоогүй газраар зам гаргах, ой жимээр сүхээр моддыг зам гарган дайсныхаа гол хүч рүү довтлох нь монголчуудын онцлог тактикийн нэг байв. Дөрвөдийн Дөрбэй догшин Хорь түмэдийг довтлохдоо: “Дөрбэй догшин цэргээ аваад урьд цэргийн явж, харуулын сахисан зам сүвээр цөөн цэргийг явуулж сүр үзүүлж мэхлээд өөрөө олон цэргээ авч, Улаан бухын харгуйгаар урагш давшив. Цэргийн хүний зүрх шантарвал жанчихын тулд хүн бүрд арван саваа (торлог) үүрүүлж, эр бүрийг сүх, ооль, хөрөө цүүцээр зэвсэглүүлээд Улаан бухын явсан мөрөөр урагш давшиж, мөрт тохиолдсон модыг огтчин цавчуулж, хөрөөдүүлж замыг цэвэрлээд, уулан дээр гараад, хуримлан суугаа түмд иргэний орой дээрээс довтлон оров.”¹⁷⁴



7. зураг: Гэрийн дотор тал, гэрт гэрэл гэгээ оруулдаг тооно. Монгол улс, Дадал сум (Зургийг авсан: Фолуш Оршүёо, 2024 оны 5-р сар)

1200 онд Хятад руу довтлохдоо мөн дайснаа хуурах тактикийг ашигласан: “Дайсныг өдөж бэхлэлтээс гаргаад байлдъя.”¹⁷⁵

3.4.4. Бууж өгөн дагаар орох: Өс хонзон авах зорилгогүй бол овог аймаг бүрт довтлохын өмнө элч илгээдэг байв. Хэрэв тухайн овог аймаг сайн дураараа бууж өгч дагаар орвол дайталгүй тэднийг удирдах захирагчийг томилдог байжээ: “Байлдалгүй дагаар орсон тул Чингис хаан тэднийг тайван орхисон.”¹⁷⁶ Зарим тохиолдолд төрийн эрхээ төвшитгөн хадгалж үлдэхийн тулд дагаар орсон овог аймгуудтай ураг барилдах замаар худ ургийн холбоо тогтоодог байсан: “Чингис хаан, Арсланыг байлдсангүй дагав гэж сайшаан соёрхож, охиноо өгье гэж зарлиг болов.”¹⁷⁷ Мөн уйгурын

Reginónal a 889. évnél olvashatunk arról, hogy a magyarok kerültek a közelharcot, a várostromokhoz nem értenek, s a színlelt megfutamodás mesterei: "fugam simulant... paulo post pugnam ex fuga repetunt" Monumenta Germaniae Historica Scriptores in usum scholarum 7. Hannover, 1890. p. 132–133. ad annum 889. https://archive.org/details/sim_monumenta-germaniae-historica_1890/page/172/mode/2up (2024. 11. 22.)

¹⁷² Монголын нууц товчоо 170

¹⁷³ Монголын нууц товчоо 191-193

¹⁷⁴ Монголын нууц товчоо 247

¹⁷⁵ Монголын нууц товчоо 176. *További példa: Монголын нууц товчоо 182*

¹⁷⁶ Монголын нууц товчоо 235

¹⁷⁷ Монголын нууц товчоо 235 *Lásd még: 3.1.2.4.2., Монголын нууц товчоо 248, 249*

удирдагч Идүүд дагаар орсон тул Чингис хаан түүнд Алалтун бэхи охиноо өгч, тавдугаар хөвгүүнээ болгодог.¹⁷⁸ Дагаар орж буй хаад Их хаанд охидоо өгөхөөс гадна хөвгүүдээ өгөх тохиолдол ч мөн гардаг байсан: “Алтан хаан Нанжин (өмнөд нийслэл) орж найрамдъя хэмээн мөргөж, Тэнгэр нэрт хөвүүнээ зуун нөхөдтэйгөөр Чингис хаанд шадар цэрэг болтугай! гэж илгээв.”¹⁷⁹



Зураг 8: Харбалгас, Орхон голын ойролцоох эртний Уйгур улсын нийслэл хотын туурь. UNESCO дэлхийн өв (Фото зураг: Фалуш Оршуёо, 2024. оны 5-р сар)

3.4.5. Дайны олз: Дайны бүх олз нь хааных болдог. Аян дайнд ялсны дараа зөвхөн Их хаан олзыг хувааж, хишиг хүртээдэг байсан:

“Хэрэйд улсыг эзэлж,
Хэнд ч дутаалгүй
Хэсэглэж хувааж авав.
Түмэн түбэгэнийг номготгож,
Түүнийг бүрнээ тасчиж
Түгээн хувааж орхив.”¹⁸⁰

Бүх олзоо Их хаанд өгөөгүй жанждад тогтсон заншлын дагуу цэргийн шийтгэл оногдуулдаг байв. Жунду хотыг эзэлсний дараа ноёд тангаргаа зөрчиж, зөвхөн Шихихутуг л

хааны олзыг хуваалцахаас татгалздаг: “Тэгэхэд Чингис хаан, Үнгүр Архай хоёрыг маш буруушаан донгодов. Харин Шихихутугийг “Чи их ёсыг сэтгэжээ” хэмээн сайшаан соёрхож, “Чи миний үзэх нүд, сонсох чих бишүү” гэж зарлиг болов.” Их хааны өөрийнх нь хөвгүүд хүртэл олзоо түүнд хүргүүлээгүй учир буруутгаж байв.

Зүчи, Цагаадай, Өгөөдэй хан хөвгүүд Үргенч хотыг эзэлсний дараа дайны олзоо хуваан авч, аян дайны олз хуваахтай холбоотой заншлыг зөрчив. Чингис хаан өөрийн хөвгүүдийн гаргасан үйлдлийг буруушаан хатуу шийтгэл оногдуулах гэтэл түүний зөвлөхүүд болон төрийн Их заргач Шихихутуг Их хаанаас хан хөвгүүдийг өршөөхийг хүсчээ.¹⁸¹

Дүгнэлт: “Монголын нууц товчоо” дахь эрх зүйн түүхийн сургамж

Түүхэн сурвалжид хуулийн түүхийн үүднээс нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд Чингис хаан болон түүний залгамжлагч Өгөөдэй хаан нь арга билгээр Эзэнт гүрнээ байгуулсан нь батлагдаж байна. Тэд эргэн тойрон дахь овог аймгуудаа ээлж дараалан байлдан дагуулсны дараа нь газарзүйн хувьд аль болох өргөн уудам нутгийг эрхшээлдээ оруулахыг зорьсон. Тэд өөр улс орныг довтлохоосоо өмнө элч илгээдэг байсан нь өөрсдийн цэргийн хүчийг эрсдэлд оруулахыг хүсдэггүй байсантай холбоотой юм. Зөвхөн тэдэнд эсэргүүцэл үзүүлж, элчийг нь хөнөөсөн улс үндэстэнтэй дайтдаг байсан: Тэд дайснаа хүчээр дарж, хаад ноёдыг нь хөнөөн ард

¹⁷⁸ Монголын нууц товчоо 253

¹⁷⁹ Монголын нууц товчоо 187

¹⁸⁰ Монголын нууц товчоо 252

¹⁸¹ Монголын нууц товчоо 260

иргэдийг нь боол болгон авч оддог байсан. Бууж өгч дагаар орсон улсыг довтлолгүй зүгээр орхин ураг барихад, цусан тангараг өргөж анд бололцох, ураг барилдан анд худ бололцох эсвэл эцэг хүү бололцдог байсан. Дагаар орсон овог аймгийн захирагчаар тэдэнд үнэнч тухайн нутгийн соёл ёс, заншлыг мэддэг хүнийг томилдог байсан. Цэргийн зохион байгуулалттай төрийг байгуулсан. Энэ хүрээнд тэд цэрэг армия хүчирхэгжүүлж, зохион байгуулалттай болгож, Цэргийн болон Цэргийн эрүүгийн хуулийг бичгээр журамласан. Мөн хишигтэн цэрэг, харуул хамгаалалт хэвтүүл цэрэгт тусад нь үйлчлэх хууль журмыг бий болгосон. Дайнаас болж бэлэвсэрсэн эмс, өнчирсөн хүүхэд хөгшдөд нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлж, мэдээллийг түргэн шуурхай дамжуулахын тулд шуудан холбоо буюу өртөөг бий болгосон.

Бүхий л салбарт хууль тогтоомж, заншлын эрх зүй тууштай хэрэгждэг байсан учир төрийн үндэс нь эрх зүйн тогтолцооны зохион байгуулалтанд оршдог байсан; цусан тангараг, адуугаар тахилга өргөх, тангараг өргөж цустай дарс уух, хуримлах, хуримын инж өгөх гэх мэт. Хаад ганцаараа бие даан шийдвэр гаргадаггүй байсан бөгөөд тэд өндөр мэдлэгтэй түшмэдээсээ зөвлөгөө авдаг байсан. Чингис хаан бичиг үсгийг гарамгай эзэмшсэн Шихихутугийг улсын Их заргачаар өргөмжилж, шүүсэн хэрэг заргаа “Хөх дэвтэр”-т тэмдэглэж байхыг үүрэгдсэнээр шүүхийн эрх мэдлийг тусгаарлаж, уламжлал дээр тулгуурласан заншлын хуулийг тэмдэглэн баримтжуулсан нь Вебөцигийн гурвалсан ном гарахаас олон зуун жилийн өмнө хууль эрх зүйн

болон албан ёсны бичгийн үндсийг бий болгож, хурлын тогтоолуудыг кодчилсон юм; Мөн шүүх эрх мэдлийн тодорхой чиглэлээр эрх мэдэл, харьяаллын дүрмийг тодорхойлсон. Ерөнхий болон тусгай урьдчилан сэргийлэх сонирхлын үүднээс хатуу шийтгэл ногдуулж, шударга ёсыг аливаа болзолгүйгээр хангасан.

Хаан ширээ автоматаар уламжлагддаг байсан. Их хаан амьд ахуй цагтаа хаан болоход тохиромжтой гэж үзсэн хүүгээ (заавал ууган нь биш) тодруулдаг байсан ч шинэ хааныг сонгох Их хуралдайн санал хураалтаар хаан ширээнд өргөмжилдөг байсан.

Их хаан хуралдай дээр хийх ажлаа танилцуулан тайлагнадаг байсан. Төрийн албан хаагчид, албан газрууд хэсэгчлэн тусгаарлагдсан гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааг хангадаг байсан. Төрийн өмчийг шамшигдуулж, шударга бусаар удирдаж, завшсан этгээдүүдэд хатуу шийтгэл оногдуулдаг байсан. Нийгмийн тэгш бус байдлыг арилгахын тулд халамжийн арга хэмжээг нэвтрүүлсэн. Жишээлбэл: Өгөдэй хаан ядууст зориулан хонины татварыг бий болгосон, хаад бэлчээр ашиглах эрхийг олгодог байсан; Өгөдэй хаан бэлчээрийг хууль ёсны дагуу ашиглах асуудлыг засаг захиргааны хагас эрх мэдэл бүхий “бэлчээрийн хяналт”-ын газрын мэдэлд оруулсан. Өгөдэй хаан нийтийн агуулах байгуулсан; Өгөдэй хаан олон нийтийг ундаалах худгуудыг гаргасан.

Энэхүү түүхэн бүтээл нь Их Монгол Улсын ёс заншил, эрх зүйн тогтолцооны өөрчлөлтийн талаар хууль зүйн түүхэн чухал хувь нэмэр оруулсан бөгөөд судалгааны төлөвлөгөө зөв болох нь эх сурвалжийн шинжилгээнээс харагдаж байна.

Мэдэгдэл

Энэхүү судалгааны ажил нь Фолуш Оршуёогийн 2024 оны 5-р сарын 1-31-ний хооронд хоёр улсын хоорондох судалгаа шинжилгээний тэтгэлгийн хүрээнд (АК-00013-003/2023) Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн сургуульд хийсэн судалгааны үр дүнгүүд юм.

Дүгнэлт:

“Монголын нууц товчоо” бүтээлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр өнөөг хүртэл Их Монгол Улсын төрийн зохион байгуулалт, түүнийг үүсгэн байгуулсан Чингис хааны төрийг удирдах ухааны талаар олон дэлгэрэнгүй бүтээл хэвлэгдэн гарсан ч “Яса”, “Хөх дэвтэр”-ээс гадна энэ үеийн ёс заншлын эрх зүйн баримт бичгүүд арвин байгаа боловч энэ талаар нэг дор бид хаанаас ч уншиж чадахгүй юм. Судалгааны төлөвлөгөөнөөс харахад “Монголын нууц товчоо”-г хууль зүйн түүхчдийн үнэ цэнэтэй эх сурвалж мөн хэмээн тайлбарлаж болно. Мөн энэхүү судалгааны үндэс болсон судалгаа нь мал аж ахуй эрхэлдэг нүүдэлчин ард түмэн төр улсаа ямар зарчмаар зохион байгуулж, өргөн уудам тал нутгийн эзэнт гүрнээ хэрхэн удирдаж байсан талаар дүгнэжээ.

Түлхүүр үгс: “Монголын нууц товчоо”; Монголын эзэнт гүрэн; Загалын хууль, хууль эрх зүйн түүхийн эх сурвалж; үр дүн, дүгнэлт

Abstract:

Despite the fact that, based on the analysis of *The Secret History of the Mongols*, many detailed works on the state organization of the Great Mongol Empire and the leadership habitus of Genghis

Khan, who created it, have been published to this day, nowhere can we read that, in addition to the *Yassa* and the *Blue Book*, this the work also abounds in data on the customary law of the time. According to the research hypothesis, *The Secret History of the Mongols* can also be interpreted as a valuable source for the legal historian. The research that forms the basis of this study also draws conclusions from it regarding the principles on which the herding peoples organized their states and how they operated the vast steppe empire.

Keywords: *The Secret History of the Mongols*; Great Mongol Empire; customary law; source of legal history; conclusions

Zusammenfassung:

Obwohl auf Grundlage der Analyse von *Die geheime Geschichte der Mongolen* bis heute viele detaillierte Arbeiten über die Staatsorganisation des Mongolischen Großreichs und den Führungshabitus von Dschingis Khan, der es schuf, veröffentlicht wurden, können wir nirgends lesen, dass dieses Werk neben der *Yassa* und dem *Blauen Buch* auch reich an Daten über das Gewohnheitsrecht der Zeit ist. Der Forschungshypothese zufolge kann *Die geheime Geschichte der Mongolen* auch als wertvolle Quelle für den Rechtshistoriker interpretiert werden. Die Forschung, die dieser Studie zugrunde liegt, zieht daraus auch Schlussfolgerungen hinsichtlich der Prinzipien, nach denen die Hirtenvölker ihre Staaten organisierten und wie sie das riesige Steppenreich verwalteten.

Schlüsselwörter: *Die geheime Geschichte der Mongolen*; Mongolisches Großreich; Gewohnheitsrecht; Quelle der Rechtsgeschichte; Schlussfolgerungen

БӨӨГИЙН ОРГОЙ МАЛГАЙН ХЭВ ЗАГВАР БА ХҮНИЙ ХӨРӨГ ДҮРИЙН УРЛАХУЙН ОНЦЛОГ

Дашзэвэгийн Амараа

Соёл урлагийн их сургуулийн Дүрслэх урлагийн сургуулийн докторант

Abstract: The terminology and interpretation of the unique clothing and artifacts created for specific rituals among shamanistic communities vary significantly due to various factors, including the spiritual beliefs and lifestyle of the ethnic groups. An essential part of this shamanistic clothing culture is the headwear, particularly the “Orgoi” hat, which features an open crown. The body of this hat is traditionally adorned with symbolic imagery crafted using conventional methods and design principles, resulting in a distinct aesthetic appearance. This study aims to elucidate the terminology, design patterns, crafting techniques, and distinctive features of human imagery in shamanic headgear, as well as the associated traditions, composition, color, and appropriate relationships between forms and symbols.

Түлхүүр үгс: Онгод, язгуур дүрс, самалга, тэгш хэм, орон зай














Оршил

Бөөгийн хувцас хэрэглэл болон түүнтэй холбоотой эд өлгийн зүйлсийг урлаж бүтээсэн арга технологи, дэг уламжлал нь дүрслэх урлагийн томоохон судлагдахуун болдог. Үүнд уран дархан, арьсан урлал, хувцас загвар, нэхмэл хатгамал, сийлбэр, чимэглэх урлаг зэрэг олон төрлийг нэгтгэсэн өвөрмөц онцлогтой урлахуйн соёл уламжлал олон зууны дамжин өөрийн гэсэн хэв

маяг дүр төрхийг бий болгон өнөөг хүрчээ. Энэхүү бөөгийн хувцасны томоохон соёлын нэгээхэн хэсэг оргой малгайн талаар онцлон өгүүлж бусад дурсгалуудтай харьцуулах, дүр дүрслэлд ангилал хийх, урлах арга барил, утга бэлгэдлийг судлан тодруулахыг хичээв. Уг судалгаанд гадаад, дотоодын судлаачдын судалгааны бүтээлд хэвлэгдсэн 8, Монголын үндэсний музейн сан хөмрөгт 4, Хөвсгөл аймгийн музейд буй 1, нийт 13 ширхэг (Монгол улс-10, ОХУ, Тува-3) оргой малгайг хамруулсан бөгөөд №1-13 хүртэл тоогоор дугаарлаж судалгаанд хэрэглэсэн болно (*Зураг 1*). Эдгээр оргой малгайнууд нь бүгд их бие дээрээ хүний хөрөг дүртэй бөгөөд 10 оргой (Монгол улс) нь 1960 оны үед Дархад угсаатан (Хөвсгөл) бөө нарын хэрэглэж байсан эдлэл юм. 1959-1962 оны хооронд Угсаатны зүйч С. Бадамхатан Хөвсгөл аймгийн дархад ястны дунд хээрийн судалгаа хийх үедээ №3, 4, 7, 9 зэрэг оргой малгайнуудыг авч ирэн одоогийн МҮМ-д өгсөн байна. Мөн судалгаанд хамрагдсан №6, 7, 8, 11 дугаартай оргой малгайн гэрэл зургуудыг Унгарын угсаатны зүйч Диосэги Вилмош (1923-1972) авсан юм. Тэрбээр 1960 онд Монголд 3 сар хээрийн судалгаа хийж, энэ хүрээнд бөөгийн 100 гаруй эд өлгийн зүйл, 800 гаруй гэрэл зураг авчээ (С.Чулуун 2023, 4). Оргой малгайд дүрсэлсэн сагалгар мод, нар сар, шулуун дүрсүүд, эвэр зүүлт, хонхинуур, зэрэг

бусад эд зүйлийн талаар нарийвчлан судалгаандаа дэлгэрүүлж өгүүлэхийг судлах шаардлагатай учир хожмын зорьж байна.

Хүний хөрөг дүртэй бөөгийн “Оргой” малгай (Монгол улс)

 <p>№1. Дархад бөөгийн малгай. Хөвсгөл аймгийн музей.</p>	 <p>№6. Бөөгийн эд хэрэглэл. Угсаатны зүйн музей. Диосеги Вилмош (Будапешт), (Бирталан Агнеш, 2020, 93)</p>
 <p>№2. Бөөгийн хувцас хэрэглэл. Монголын үндэсний музей (National Museum of Mongolia 2009, 106)</p>	 <p>№7. Дархад бөөгийн малгай. Монголын үндэсний музейн сан хөмрөг.</p>
 <p>№3. Дархад бөөгийн малгай. Монголын үндэсний музейн сан хөмрөг.</p>	 <p>№8. Бөөгийн малгай. Монгол улс, Улаанбаатар хот. Улсын төв музей, (Чулуун, 2023, 83)</p>
 <p>№4. Дархад бөөгийн малгай. Монголын үндэсний музейн сан хөмрөг.</p>	 <p>№9. Дархад бөөгийн малгай. Монголын үндэсний музейн сан хөмрөг.</p>
 <p>№5. Цагаан соёл бөөгийн малгай. Хөвсгөл аймгийн музей, (Чулуун, 2023, 83)</p>	 <p>№10. Дархад бөөгийн малгай. (Бадамхатан, 1965, 243)</p>
<p>Тува бөөгийн Оргой малгай (ОХУ)</p>	
 <p>№11. Бөөгийн малгай. (Дэвлет, 1980, 248)</p>	 <p>№12. Бөөгийн малгай. (Вайнштейн, 2016, 318)</p>
 <p>№13. Бөөгийн малгай. (Вайнштейн, 2016,)</p>	

Зураг 1. Хүний хөрөг дүртэй бөөгийн оргой малгай. (Монгол улс, ОХУ, Тува)

Бөөгийн малгайн нэршил

Хүн (удган, зайран) -онгод гэсэн биет, биет бус хоёр дүрийн хоорондын харилцаа хамаарал, хоёр бие нэгдэх, нэг цул биет болж хувирах үзэгдлийн илэрхийлэл нь бөөгийн хувцас бөгөөд бодитоос бодит бус тодорхой заагтай орших орон зайд шилжихэд гол үүрэгтэй. Энэхүү хувцасны үүрэг, зориулалт нь тухайн хүний (бөө)-г муу нөлөөнөөс хамгаалах... өмсгөл нь бөөгийн өмсгөл биш онгон сахиусны өмсгөл (С.Бадамхатан 1965, 233) гэж үздэг байна. Бөөгийн хувцсанд малгай чухал үүрэгтэй бөгөөд битүү оройтой (даавуу, амьтны арьс, өд сөд, эвэр, төмөр тоног), оройгүй (даавуу, шувууны өд сөд, гөрөөсний арьс, малын ноос, үс, явуу, төмөр тоног) гэсэн хоёр үндсэн хэлбэр зонхилдог. Малгайн нэршлийн тухай түүхч Ч.Далай бугын эврийн дүрсийг цуглан отго болгон суулгасан төмөр буюу оргой гэдэг малгай өмсөнө (Ч.Далай 1959, 32) мөн Я.Цэвэлийн толь бичигт оргой [oryci] бөө нарын онгодоо тайж урихдаа өмсөх малгай (Я.Цэвэл 2013, 584) гэсэн тайлбар зүүлт хийжээ. Бөө судлаач О.Пүрэв Даяндээрхийн халх бөө нар мөн товорцог... буриад, барга, хорчин зэрэг Зүүн Монголын бөө нар ийм товорцог, буриадаар майхавч (О.Пүрэв 2006, 190) гэсэн бол Баруун Монголын бөө удган нар ихэнх нь намхан оройтой малгай өмсөж, зарим нь алчуураар толгойгоо боодог (Ч.Далай 1959, 32) тухай бүтээлдээ дурдсан байна. Угсаатны зүйч эрдэмтэн С.Бадамхатан Цаатан бөөгийн малгай бөртө (С.Бадамхатан 1965, 39), урлаг судлаач Л.Батчулуун дөрвөд, баядын нутагт намхан оройтой товь малгай өмсдөг (Л.Батчулуун 2021, 9-17) хэмээн онцлон өгүүлжээ. Буриад бөөгийн

даавуун малгайг гавал, төмрөөр хийсэн эвэр зүүлт бүхий тоног өмсгөлийг бөөгийн дуулга (Баре 2023, 224) гэж тэмдэглэсэн байна. Дээрх судлаачдын судалгаанаас үзэхэд, бөөгийн малгайн нэрийг газар нутаг, овог угсаатны онцлог, малгайн ерөнхий хэв загвараас үүдэн зарим нутагт оргой, алчуур, товорцог, майхавч, товь, бөртө, гавал, дуулга хэмээн дуудаж заншжээ. Бид энэхүү судалгаандаа түүхч Ч.Далай, судлаач С.Бадамхатан, О.Пүрэв болон Л.Батчулуун нарын бүтээлд дурдагдсан бөөгийн малгайн нийтлэг нэршил болох оргой нэрийг хэрэглэв.

Үндсэн хэсэг

Бөөгийн хувцас урлах үйл явц нь онгодын хүсэлт хэрэгцээ, болзолт шалгуурт нийцэх тогтсон дэг жаягтай агаад урлах бүтээх санаа сэдэл, дүр дүрслэлийг урлаач өөрийн хүслээр үйлдэх бус “онгодын” чиглүүлэг зааврын дагуу урладаг. Энэхүү хувцас хэрэглэл, овог, ясны сүлд онгод, язгуур шүтлэгийн хэлбэр агуулгатай дүр дүрслэл нь тэр чигтээ залгамж байдлаар өвлөгдөн удам дамжин уламжлагдах үйл явц бөгөөд байгаль дээр юу ч шинээр үүсдэггүй юмс үзэгдэл зөвхөн тойргоор л эргэлдэж байдаг (М.Ф.Овсянников 1987, 157) хэмээн Гегелийн үзэл санаатай давхцах ажээ. Оргой малгайн урлалаас бөөгийн бусад хувцас, эд өлгийн зүйлс дээрх бэлгэдэлт дүрсийг харж болохоос гадна заавал дүрслэгдэх кодлогдсон дүрсүүд байх ба тэдгээрийн бэлгэдэл утга агуулга нь шүтлэг, зан үйл (хориг цээр)-ийн шинж давамгайлдаг. Бөө судлаач О.Пүрэв малгайн задгай оройны талаар онгодтойгоо толгойн оройгоор шууд харьцаж бөөлдөг учраас

бөө малгай оройгүй болсон (О.Пүрэв 2006, 196) хэмээн бүтээлдээ дурджээ. Энэхүү малгайг урлах арга барил ашигласан материал зэргээс харахад тухайн угсаатан ард түмний сэтгэлгээ, шүтлэг бишрэл, амьдралын хэв маяг, газар нутгийн онцлог шинжийг өөртөө агуулдаг. Уг оргойг урлахдаа нүүдэлчид ахуйдаа эртнээс түгээмэл

хэрэглэж ирсэн дүрслэх урлагийн нэгэн төрөл зээгт наамал, хатгамлын аргыг хослуулан биет хэлбэр үүсгэх, эрчилсэн утас, даавуу, цаа буга болон амьтны үс, сур, явуу, өд зэрэг материал ашиглах бөгөөд хонин холбоо, хөвөрдөх, шидэх хавах, үйл урлал, арга ажиллагаа шаарддаг байна (Зураг 2).



Зураг 2. Оргой малгай дахь хүний хөрөг дүр урлах арга ажиллагааны онцлог.
(оргой №4, 7, 9, 5)



Оргой малгайн оройгүй загвар нь дээд хэсэг, их бие, доод хэсэг гэсэн гурван хэсгээс бүрдэнэ. Бөө мөргөлд тоон утга илэрхийлэл, үзэл ойлголтууд түгээмэл агаад түүхч Ч.Далай бүтээлдээ гурван ертөнцийн тухай ойлголт ертөнцийг үзэх үзлийн гол хэсэг нь болдог (Ч.Далай 1959, 42) гэсэн бол судлаач С.Дулам гурвалжин дүрсийн бэлгэдэл утга нь хүмүүн, тэнгэр, газар гурвын хэлхээ, орчлон ертөнцийн бичил загвар бэлгэдэл (С.Дулам 2018, 61) хэмээн үзжээ. Оргой малгайд энэхүү бичил ертөнцийн загвар буй бөгөөд дээд хэсэгт жигүүртний өд өдөө тэмүүлэх босоо чигтэй гурвалжин тэнгэр, их бие дээрх хүний дүрс бол тэнгэр, газрын холбоос, дамжуулагч үүрэгтэй хүмүүн, доод талын олон өнгийн цацаг байдлаар сул унжуулах нүүр царайг (бөө) хаах

хамгаалах зориулалт бүхий самалга (О.Пүрэв 2006, 194) нь доош чигтэй гурвалжин газар хэмээх ойлголтын бэлгэджээ. Мөн гурван ертөнц дээд, дунд, доод (тив), орон зай (ирээдүй, одоо, өнгөрсөн) цаг хугацааны илэрхийлэл байж болох юм. Их биеийн зохиомжид буй хүний хөрөг дүр төвтэй бусад дүрсийн харьцаа хамаарал нь

хүмүүн - тэнгэр (нар, сар)

хүмүүн - газар (саглагар мод)

хүмүүн-орон зай (дүрс) хэмээн илэрхийлэгдэх ба хоёрдогч дүрсүүд (саглагар мод, нар сар, орон зай) хүний хөрөг дүрийн хоёр талд үргэлж хосоор нь тэгш хэмтэй урладаг онцлогтой.



Зураг 3. Оргой малгайн үндсэн бүтэц (дээд хэсэг, их бие, доод хэсэг).



Хэвтээ (оргой)-Босоо (сүүл нуруу) дээрх дүрсийн байрлал. а) Оргой малгай дүрсүүд (Вайништейн 2016, 318). б) Хорол удганы өмсгөлийн дүрсүүд (О.Пүрэв 2006, 237).

Тэнгэр (босоо цагаан гурвалжин), газар (хөмөргөн хар гурвалжин) (С.Дулам 2018, 61) хоёр дүрсийн давхцал давхар чойнжин буюу зургаан өнцөгт гурвалжинд багтсан оргойн дүрсийн өгүүлэмж нь дүрсийг амьдчлан үзэж, тэдгээр нь үл үзэгдэх өөр өөрийн эзэдтэй (Л.Батчулуун 2021, 118) хэмээх тайлал мөн уг дүрсүүд салангид бус нэгдмэл, цул бүхэл хэмээх утга илтгэнэ. Бидний судалж буй оргойд хэвтээ хэмжээс дээр дүрсийг шугаман аргаар төв голчтой байдлаар өрдөг бол бөөгийн оройтой малгайн ар хэсэг, өмсгөлөөс зүүдэг “сүүл нуруу” (О.Пүрэв 2006, 237) хэмээх нарийн урт босоо хэмжээст дээр мөн адил загвараар дүрсээ байрлуулдаг. Энэхүү хэвтээ-босоо хэмжээсийн дүрсийн тэгш хэмт зохиомжийн харьцаа, дараалал нь үндсэндээ адил бөгөөд нүдэнд

харагдаж байгаа бус, утга санаагаа байх ёстой тодорхой тэмдэгт дүрээр харьцуулан илэрхийлэх (С.Батчулуун 2020, 119) үндсэн зарчмыг баримтлах бөгөөд ертөнцийг дүрст хураангуйлж шингээсэн хэлбэр юм (**Зураг 3**). Оргой малгайн дүрсийг утга бэлгэдэл, хэлбэр агуулгаар нь:

- а) Үндсэн дүрс (хүмүүн)
- б) Язгуур дүрс (мод, нар, сар)

в) Үүсмэл дүрс (тэмдэгт) хэмээн ангилж үзлээ. Дээрх а), б), в) дүрсүүдийн байрлал, дараалал нь зохиомжийн зохист харьцаагаар илэрхийлэгдэх бөгөөд а) Үндсэн дүрсийг 50%-иас багагүй хэмжээтэй дүрсэлдэг. Жишээлбэл оргой №1-д а) 50%, б), в) дүрс нийлээд 50% гэсэн хувь хэмжээс нь оргойн тогтсон дараалал, тэг зурлага гэж үзэж болно (**Зураг 4**).



Зураг 4. Бөөгийн оргой малгайн дүрсийн (үндсэн, язгуур, үүсмэл) зохиомжийн харьцаа.

Бөө мөргөлд өнгө хэмээх ойлголт нь бодит ба бодит бус бэлгэдлийн шинжтэй бөгөөд орон зай (зүг чиг), шим ертөнц (газар орон, лус, харын, шарын, цагааны тэнгэрүүд) тоо хэмжээс, (55, 44), эзэн дүр (онгод савдаг, хүн, амьтан)-ийг илэрхийлдэг. Судлаач О.Пүрэв бүтээлдээ бөөгийн шашинд хорвоогийн өнгө, хүний сэтгэл санааны өнгө, яс овгийн өнгө гэсэн гурван зэрэглэлд хувааж үздэг (О.Пүрэв 2006, 190) хэмээсэн тодорхойлолт бол бөө мөргөлд өнгөний талаарх үзэл баримтлал сэтгэлгээний маш дээд түвшинд хүрснийг илтгэнэ. Оргойн үндсэн өнгөнд хар, улаан өнгө зонхилох бөгөөд хүний сэтгэл санаанд хүчтэй нөлөөлдөг өнгөнүүд юм. Самалганд дан хар өнгөнөөс гадна олон өнгийг (дулаан хүйтэн) дагнаас байдлаар хоршуулсан нь бэлгэдлийн утгатай. Өнгөний ерөнхий харьцааг харахад дээрээс хар бараан цул өнгө доош зөөлөрч, самалганд олон өнгө хуваагдан өнгөний шилжилт харагддаг. Энэ нь бөө бөөлөх үед олон өнгө хөдөлгөөнд орж хувьсан өөрчлөгдөж байдаг (*Хавсралт 1*).

Хүний хөрөг дүр, урлахуй онцлог

Бөө мөргөлд онго, онгод буюу бодит ба бодит бус хүн төвтэй сэтгэлгээний

ойлголт нь оргой малгайн дээр хүний хөргийг томоор дүрсэлж дүрийг чухалчлан үзэж буйгаас харагдана. Хүн дүрслэл нь бөөгийн онго, хувцас, хэнгэрэг болон бусад эд зүйлд нэгэн адил дүрслэгдэх бөгөөд цөм нэгдэж цогц утга бэлгэдэл бүхий урлаг болж илэрхийлэгддэг. Шүтлэгтэй холбоотой цалиг дүр, сүлд дүр, онгодын дүр (С.Дулам 2018, 157-166) хэмээх энэхүү дүрүүдийн уг сурвалж, урлахуйн эх үндэс язгуур уламжлалыг эртний хадны зураг, чулуун онго, буган хөшөө, хүн чулуун урлагт тод томруун дүрсэлснээс харж болно. Хадны сүг зурагт дахь хүний нүүр дүрслэлийг судлаачид хүний нүүрийн баг (Н.Батболд 2021, 123), хүний нүүрний дүрст хадны зураг (Ван Сиаокун 2021, 16) гэсэн нэршлийг хэрэглэж шүтлэг бишрэл, зан үйлтэй холбон тайлбарлажээ. Бөө мөргөлд энэхүү хүний хөрөг дүрслэлийг хэрхэн үздэг талаар ихэвчлэн аман яруу найрагт (Д.Бум-очир 2017, 45) домог зүйн хэлбэрээр үлдсэн бөгөөд Цаатан Тож бөө нарын тамлагад:

“...7 өдтэй малгай минь

Лагшин тунгалаг уу?

Хамт нисье. Хамт нисье гэсэн тамлага бий. Малгайн дахь хүний дүрс нь онгон,

сахиусыг дүрсэлж бүргэд болон хувирч нисэхийг уриалсан утга бүхий...” хэмээжээ (С.Бадамхатан 1965, 234). Дархадын Жамбын Дамдин зайрангийн өгүүлсэн Гунан Улаан баатрын домгийг¹ угсаатны зүйч С.Бадамхатан тэмдэглэж авсан бөгөөд Халхын Гунан Улаан баатар домогтой төстэй учир хожим үүсэн домог гэж үзсэн байна. Бөө судлаач О.Пүрэв уг саналыг дэмжиж бурхны шашны дэлгэрэлттэй холбоотой болох талаар бүтээлдээ бичжээ. Оргойн их биеийн үндсэн улаан өнгийг хөрөг дүртэй холбон хар дархад, маанжраг ясны зайран бөө нар малгай дээрх хүний нүүрний дүрсийг орон дэлхийн тийрэн, савдагтай нөхцсөн бөө хүний толгой бөгөөд улаан хүрэн, ногоон өнгө нь тэрхүү тийрэн савдгийн царай юм (О.Пүрэв 2006, 194) гэсэн сонирхолтой тайлбар өгүүлжээ. Урлаг судлаач С.Батчулууны бөө удган нар шүтдэг онгоныхоо нүүр, толгойг дүрсэлсэн (Л.Батчулуун 2021, 16) гэж үзсэн таамаг илүү бодитой байж магад.

Энэхүү хөрөг дүртэй холбоотой домгийн шинжтэй тайлбарууд дотор (Гунан Улаан баатар, тийрэнтэй нөхцсөн савдаг) хувь бодгаль шинжтэй


дүрүүд байгаа бол оргой №4-д гурван хөрөг дүр байгаа нь олон онгод даадаг, зэрэг буудаг үйл явцыг буюу тэдгээр онгодын дүрийг зэрэгцүүлэн дүрсэлсэн байж болох юм. Бөө бөөлөх үед удмын онгодоос гадна ойр тойрны онгодууд орж ирдэг (Л.Чулуунбаатар 2006, 146) талаар судалгааны баримт² дурджээ. Зарим бөөгийн малгай урд хэсэгт хүний дүрийг биет хэлбэр баг (маск) байдлаар мод, металлаар урлаж хадах нүүрийг халхлан зүүх бөгөөд дүрслэлийн хувьд эртний чулуун соёлд дүрслэгдсэн онго шүтлэгтэй (тотем) төстэй. Эдгээр баг (маск) нь оргойн их биеийн хөрөг дүр, доод хэсэг самалгатай адил тэрхүү бөө, удганы нүүрийг халхалж танигдуулахгүй болгож байгаа зүйл (С.Бадамхатан 1965, 209) бөгөөд хамгаалах үүрэгтэй ажээ.

Оргой малгайд дүрслэгдсэн хүний хөрөг дүрийг урласан арга барилаар нь:

- а) Хүний нүүр хүрээлэх (№3, 4, 5, 6, 13)
- б) Хүний нүүр хүрээлээгүй (№1, 2, 7, 8, 9, 10, 11, 12)
- в) Хүний нүүр чимэглэх (явуу) (№6, 7, 8, 9) хэмээн харьцуулалт хийв (Зураг 5).

¹ “...Малгай дээрх хүний дүрс нь Чингисийн үед бурхны шаашинтай тэмцэлдэж байсан хойд зүгийн баатар бөгөөд эвэртэй лустай тэмцэлдэж дийлсэний нь бэлэг дурсгал болгож малгайн өдний хажуу талд эвэр хадах болсон гэнэ. Малгайн өд буруу харуулж хадсан учир нь тэр Гунан улаан баатар лустай тэмцэхдээ өөрийгөө танигдуулахгүйн тул малгайгаа буруу харуулдаг болсон гэнэ...”


² “...2005 оны зун Хөвсгөл аймгийн Улаан –Уул сумын Соёо багийн бөө Доржийг бөөлөх үед 7 онгод орж ирлээ хэмээн хэлсэн байсан. 2004 оны зун Хөвсгөл нуурын хөвөөнд бөөлсөн 70 гаруй настай Долгор удган 11 онгод орж ирлээ хэмээж байсан...”



Зураг 5. Хөрөг дүрийг урлах арга барил.

Эдгээр оргой малгайн зохиомж, үндсэн хэв загвар адил бөгөөд дүрсийн хувьд хязарлагдмал цөөн өгөгдөлтэй боловч урлах арга барил, материал, өгүүлэмж нь давтагддаггүй учир өөр өөрийн хэв маяг онцлог шинжтэй болдог. Жишээлбэл: оргой №2, 9, 11-д дүр, дүрслэлийг ерөнхий байдлаар харуулсан бол оргой №1, 13-ийн урласан арга барил нь тэгш хэмт үндсэн зохиомжийг баримталсан хэдий ч их биеийн өнгө, шулуун зураас, дүрсийн хөдөлгөөн орон зайн тоглол нь бусад оргойн дүрслэлээс эрс ялгарна. Дүр дүрслэлийн хэмжээ харьцаа, байрлалын тухайд гадна ерөнхий хэлбэрт (өд, их бие, самалга) шугаман хуваалт хийж

үзэхэд хөрөг дүр зохиомжийн төв цэгт таарч байгаа нь зохист харьцаа буюу хөрөг дүр чухал байр суурь эзэлж буйг илтгэнэ. Доорх оргойн их биеийн голлох босоо төв шугам тэгш өнцөгтийн захаас холбоход гурвалжин өнцөгт дүрс үүсэх ба зохиомжийн голлох үндсэн, язгуур зурлагууд огтлолцож байна. Хүний хөрөг дүр ямагт голлох төв байр сууриа хадгалах бөгөөд хүрээлсэн дүрсүүд нь олон нөхцөл, учир шалтгаанаас үүдэлтэй хэлбэр дүрс, зурлага нь өөрчлөгдөж хувьсдаг бол зарим оргойнд хоёрдогч дүрсүүдийг огт дүрслээгүй зөвхөн хөргийг дангаар нь урласан байна (Зураг 6).



Зураг 6. Бөөгийн оргой малгайн дүрслэл дэх зохиомжийн харьцаа

Оргой малгайн их бие дээр хүний хөрөг бүтээхдээ нүүрний хэлбэр болон нүд, хөмсөг, хамар, ам, хацар, чих зэрэг долоон сүвийг (О.Пүрэв 2006, 193) дүрслэхдээ илэрхийлэх, арга барил, хэллэгийн хувьд бага зэрэг ялгаатай хэдий ч тогтсон уламжлалыг ямагт баримталдаг. Зарим хөрөгт хүний


зан авирын онцлог шинжүүдийг тод томруун харуулахыг эрмэлзсэн байдаг. Явууг оёж тогтоохдоо дүрсийн хөдөлгөөнийг дагуулан хэлбэр үүсгэх ба тод цагаан өнгө нь бараан дэвсгэр дээр ялгарч, дүр дүрслэлээ улам тодруулах үүрэг зорилготой ажээ (*Зураг 7*).

	Зураг. №1	Зураг. №2	Зураг. №5	Зураг. №6	Зураг. №9	Зураг. №10	Зураг. №11	Зураг. №13
НҮД ХӨМСӨГИЙН ХӨРӨГ								
ХАМАРЫН ХӨРӨГ								
АМНЫ ХӨРӨГ								
ЧИХНИЙ ХӨРӨГ								

Зураг 7. Хүний хөрөг дүрийн харьцуулалт

Хүний хөрөг дүрийн зарим дүрслэл болох ам №12, чихийг №9, 11 оргойд урлаагүй байгаа нь сонирхолтой бөгөөд XIII-XIV зуунд хамаарах зарим зөвхөн хөрөг дүртэй хүн чулуунд (Зүүн нүхт, Сүхбаатар) мөн адил хөргийн чих, ам зэргийг дүрслээгүй нь зан үйлийн болон утга бэлгэдлийн хувьд төстэй байж болох юм (*Зураг 8*). Хадны сийлмэл зурагт (Хахуулын гол, Өмнөговь) бөөгийн малгайн оройд байдаг салаа эвэр, өд? мөн хоёр хацрыг дүрсэлсэн “уул усны эзэн савдаг” (У.Эрдэнэбат 2008, 36-56) дүртэй болно. Оргой №1, 2-т хөргийн хацрыг хоёр дугуй дүрсээр улаан, цагаан өнгөтэй урласан бөгөөд хацрыг улаан өнгөөр дүрсэлсэн нь амин сүнс гэж үздэгтэй холбоотой (О.Пүрэв 2006) хэмээн үзжээ.

Дээрх бүх оргойд дүрслэгдсэн хөрөг дүрийн нийтлэг шинж нь эгц өмнө талаас харсан дэлгэмэл байдлаар урласан нь хадны сүг зураг, хүн чулуунд дүрслэгдсэн хөрөг дүрийн зохиомж дүрслэлээс уламжлалтай илтгэнэ. Энэхүү оргойн хөрөг дүр болон бусад дүрслэлээс зураас зурлага, донж хэтрүүлэг, урлахуйн сэтгэмжээр илэрхийлэгдэх хүн-байгаль, газар-тэнгэр, бодит-хийсвэр, бэлгэдэл-сэтгэлгээ, уламжлал-зан үйл, биет-биет бус, арга-билэг, тэгш хэм-тиг зохирол, хэмнэл-хөдөлгөөн, цаг хугацаа-орон зай, алслал-зүг чиг, энерги-тэнцвэр, хатуу-зөөлөн гэсэн ойлголт агуулгыг товч хэллэгээр харуулах чадвар нь урлаачийн уран сэтгэлгээний илрэл юм.



Зураг 8. Хадны сүг зураг болон хүн чулуунд дахь хүний хөрөг дүрслэл.

Хадны зураг (Монгол) : 1-2 Сүхбаатар, Жаргалантийн адгийн ширээ, (гар зураг Д.Амараа). 3-5 Өмнөговь, Хахуулын гол (Хаданд сийлсэн эртний урлаг. 2022, 29).

6. Өмнөговь, Цагаан бухтын гол. (Т.Санжмятав гар зураг.1988). 7. Өмнөговь, Цагаан дэрсний Бичигтийн ам (Хаданд сийлсэн эртний урлаг.2022, 28).

Хадны зураг (ОХУ) : 1-7 .Мугур-Сарголын хадны зураг. (М.А.Дэвлет 1980, 49-143).

Хадны зураг (БНХАУ) : 1-2 Авга хошуу, Байшин худаг, (Авга музей), 3-6 ӨМӨЗО-ны Улаанхад хотын хадны зураг. (Ван Сиаокун 2021, 47, 52).

Хүн чулуу (Монгол) : 1-5 Сүхбаатар, Зүүн нүхтийн хүн чулуу (Д.Амараа 2021, 90).

Дүгнэлт

Манай улсад 1960 он хүртэл бөөгийн хувцас хэрэглэл нь уламжлалт байдлаараа хэрэглэгдэж ирсэн нь дээрх хоёр судлаачийн (С.Бадамхатан, Диосэги Вилмош) судалгаа, олж цуглуулсан бөөгийн холбогдолтой эд өлгийн зүйлсээс тодорхой харагдаж байна. Эдгээр оргой малгайн хувилбаруудаас үзэхэд урлах хэв загвар, арга технологи нь цаг хугацааны явцад хувцасны

соёлын хэлбэр болж бүрэлдэхэд овог удам дамжих (тотем, онго шүтлэг) эртний уламжлалаа дагаж мөрдөх, чанад баримталдаг энэхүү зарчим нөлөөлсөн бололтой. Бөөгийн хувцас хэрэглэл нь нийтийн түгээмэл бус цөөнхийн хэрэглээ хэрэгцээнд зориулсан зарим нууцлаг шинж агуулдаг мөн шүтлэг бишрэлтэй холбоотой эд өлөг гэж үздэг учир тун бага судлагдсан байна.

1. Бөөгийн оргой малгай нь хэв маяг, ур хийц, утга бэлгэдлийн хувьд бие даасан шинжтэй бөгөөд дүрслэх урлаг тэр дундаа хөрөг зургийн төрөлд шинэлэг өнгө аяс хэллэгтэй өвөрмөц дүр төрх нь сонирхолтой судлагдахуун болно.
2. Хүн чулуу бол бодит эзэнтэй дүр, тахилга тайлгын зан үйлийн зориулалт бүхий дурсгал гэж үздэг болоргойн хөрөг нь хийсвэр шинжтэй ад зэтгэр, тийрэнг дарах, зайлуулах, төөрүүлэх, эзэнээ (бөө) хамгаалах үүрэгтэй дүр гэж үзэж болохоор байна. Бөөгийн онго сахиус мөн олон тооны хүний дүрстэй байдаг нь мөн адил, муу зүйлээс хамгаалах зорилготой байдаг. Оргойн хөрөг дүрийг тойрсон хос дүрсүүдийг нэгтгэн харилцан хамаарал, холбоос үүргийг сайн судлах аваас хөрөг дүр бүтээх болсон сэжмийг тодруулж болох юм.
3. Хадны сүг зураг, хүн чулуу, эртний онго шүтлэгт дүрслэгдсэн шүтлэг бишрэлийн шинжтэй хүний хийсвэр дүрслэлийг оргойн хөрөг дүртэй ерөнхийлөн харьцуулах аргаар үзэхэд дүрслэх арга барил нь адил төстэй хэдий ч бие биедээ нөлөөлсөн гэж үзэх таамаглал төдий юм. Эх сурвалж болох уг эртний хөрөг дүрслэл нь хөгжлийн явцад тус тусдаа хувьсаж өөрчлөгдсөн ч оргойн дүрслэлд язгуур хэв шинж зурлага нь илүү хадгалагдаж үлдсэн харагдаж байна.
4. Бөөгийн хувцасны үндсэн агуулга бол хүн-байгалийн харилцаа, оршихуйн үндэс шим ертөнц хийгээд “Тэнгэр, газар, хүмүүн” гурвалсан холбоосын үр дүнд бий болсон бодит

ба бодит бус сэтгэлгээний илрэл оргой малгайны загварт тусгалаа олжээ. Уг судалгаанд бололцоо нөхцөлийн хүрээнд зөвхөн Дархад (Монгол), Тува (ОХУ) бөөгийн цөөн тооны малгай өмсгөл хамруулсан ба эдгээр оргой малгайн ур хийц, хэв маягт томоохон өөрчлөлт ялгаатай байдал үгүй бөгөөд учир нь Дархад, Тува ястнууд бол нэг бүс нутаг, амьдралын хэв маяг, соёл ахуй, зан заншил адил төстэй юм. Цаашид Халх, Буриад, бусад ястнууд болон эртний бөө мөргөлтэй бусад улс орнуудын ижил төстэй малгай өмсгөл, эд өлгийг харьцуулан өргөн хүрээнд судлах шаардлагатай байна.

Талархал

Монголын үндэсний музейн сан хөмрөгт буй бөөгийн оргой малгай судалгаа хийх нөхцөл бололцоогоор хангасан Монголын Үндэсний музейн захирал Г.Энхбат (Ph.D) болон тус музейн хамт олонд талархал илэрхийлж, цаашдын ажилд нь өндөр амжилт хүсье.













Ашигласан материалын жагсаалт

1. Амараа, Д. 2021. “Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын “Зүүн нүхт”-ээс шинээр илрүүлсэн хүн чулууд”. Монголын археологи-2021. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, Монгол Улс: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
2. Бадамхатан, С. 1962. *Хөвсгөлийн цаатан ардын аж байдлын тойм*. Улаанбаатар, Монгол Улс: Шинжлэх Ухааны Академийн хэвлэл.
3. Бадамхатан, С. 1965. *Хөвсгөлийн*

- дархад ястан.* Улаанбаатар, Монгол Улс: Шинжлэх Ухааны Академийн хэвлэл.
4. Батболд, Н. 2014. *Хадны зураг дахь эртний нүүдэлчдийн шүтлэг биширэл, оршуулгын зан үйлтэй холбогдох нь.* Археологи судлал. Tomus XXXIV. Улаанбаатар, Монгол Улс.
 5. Батчулуун, Л. 2012. *Бөөгийн хувцас, тоногийн учир холбогдол.* Mongolica VoL (45). Улаанбаатар, Монгол Улс.
 6. Батчулуун, С. 2020. “Нүүдэлчдийн уран сайхны сэтгэлгээний онцлог”. Монголын дүрслэх урлаг, дизайны хөгжил. Улаанбаатар, Монгол Улс: “Бэмби сан” ХХК
 7. Бирталан Агнеш. 2020. *Унгар дахь монголын өв соёлын дурсгалууд.* Улаанбаатар, Монгол Улс: Адмон ХХК.
 8. Болдбаатар, Ч. 2000. “Монголын хадны зургийн уран сэтгэмж дүрслэлийн сакраль шинж.” Ph.D диссертац., Монгол Улсын Соёл Урлагийн их сургууль. Улаанбаатар, Монгол Улс.
 9. Бум-Очир, Д. 2017. *Монгол бөөгийн зан үйл: Аман яруу найргийн төрөл зүйлс.* Улаанбаатар, Монгол Улс: МУИС Пресс хэвлэлийн газар.
 10. Вайнштейн, С.И. 1975. *История народного искусства Тувы*” Москва.
 11. Вайнштейн, С.И. 2016. *Загадочная Тува.* Москва.
 12. Ван Сиаокун, Жан Вэнжин. 2021. *Хадны зураг дахь шүтлэг.* Улаанбаатар, Монгол Улс.
 13. Далай, Ч. 1959. *Монголын бөөгийн мөргөлийн товч түүх.* Улаанбаатар, Монгол Улс: Шинжлэх Ухаан, Дээд Боловсролын Хүрээлэнгийн Эрдэм Шинжилгээний хэвлэлийн газар.
 14. Дулам, С. 2018. *Домог зүй, бөө мөргөлийн судалгаа: Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган.* Улаанбаатар, Монгол Улс: МУИС-ын Монгол судлалын хүрээлэн.
 15. Дэвлет, М. А. 1980. “Петроглифы Мугур-Саргола” Москва.
 16. Кристал Брае. 2023. *Дани дахь монголын өв соёлын дурсгалууд.* Улаанбаатар, Монгол Улс. 東京外国語大学論集第 72 号
 17. Luvsanjav, Chuluunbaatar 2006. “Монгол бөөгийн онгодын хүч”
 18. Овсянников М. Ф. 1987. *Гегель.* Улаанбаатар, Монгол Улс. Улсын хэвлэлийн газар.
 19. Пүрэв, О. 2006. *Монгол бөөгийн шаашин.* Улаанбаатар, Монгол Улс.
 20. Rolf Gilberg. 2024. *Mongolian and Siberian Shamans.* Yale University press, Aarhus University press. The national Muzeum Of Denmark.
 21. Цэвэл, Я. 2013. *Монгол хэлний их тайлбар толь.* Улаанбаатар, Монгол Улс.
 22. Чингис хаан музей. 2023. *Диосэги Вилмошийн Монголын тухай гэрэл зургууд (1960).* Ред.Чулуун, С., На Батболд., Силалы Жолт. Улаанбаатар, Монгол Улс.
 23. Эрдэнэбат, У. 2008. “Хахуулын голын хадны зураг”. Археологи судлал. Tomus (VI) XXVI. Улаанбаатар, Монгол Улс: “Мастер принт” ХХК.

Хавсралт 1.

Оргой малгайн хэлбэр, өнгөний харьцаа

№	Зураг. №3	Зураг. №4	Зураг. №9
Үндсэн ОРГОЙ			
Өнгөний харьцаа	 <p>Зураг№3</p> <ul style="list-style-type: none"> ■ Хар өнгө(өд) 42.8% ■ Улаан хүрэн өнгө(их бие) 19.3% ■ Ногоон өнгө(самалга) 12.2% ■ Цэнхэр өнгө(самалга) 8.5% ■ Цагаан өнгө(самалга) 17.2% 	 <p>Зураг№4</p> <ul style="list-style-type: none"> ■ Цайвар бор өнгө(их бие)27.0% ■ Бор хүрэн өнгө (өд) 23.7% ■ Улаан өнгө (самалга) 10.8% ■ Цагаан өнгө(самалга)10% ■ Хар өнгө(самалга)3.65% ■ Цайвар цэнхэр(самалга)3.65% ■ Ногоон өнгө(самалга)7.3% ■ Бараан цэнхэр өнгө (самалга)7.3% ■ Улбар шаргал өнгө (самалга)7.3% 	 <p>Зураг№9</p> <ul style="list-style-type: none"> ■ Улаан өнгө(их бие)26.1% ■ Бор хүрэн өнгө (өд) 20.1% ■ Ногоон цэнхэр өнгө (самалга) 14.0% ■ Цайвар ногоон өнгө(самалга)14.0% ■ Бор шаргал өнгө(самалга)10% ■ Цагаан өнгө (самалга)15%
Ерөнхий хэлбэр (гадна) Өнгөний харьцаа (хүнд хөнгөн)			
Самалганы үзүүрийн хэлбэр			

МОНГОЛ-УНГАРЫН ШУА-УУД ХООРОНД ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ МОБИЛИТИ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ТУХАЙ

Омбоосүрэнгийн Эрдэнэчимэг

*ШУА-ийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний
тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), дэд профессор
Мобилити судалгааны Монголын талын төслийн удирдагч*

Монгол Улсын ШУА болон Унгар Улсын ШУА-ийн хамтарсан “Орчин үеийн Монголын нийгмийн өөрчлөлт: онцлог, сургамж” сэдэвт мобилити төслийг 2024-2026 онуудад хэрэгжүүлэхээр шалгарч Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/48 тушаал гарч уг төслийн үйл ажиллагаа эхэлсэн болно.

Төслийг Монголын талаас ШУА-ийн Философийн хүрээлэн, Унгарын талаас Унгарын ШУА-ийн Нийгмийн угсаатны зүйн хүрээлэн хамтран хэрэгжүүлж байна. Монгол-Унгарын ШУА хооронд хэрэгжүүлж буй тус мобилити судалгааны хэрэгцээ шаардлага нь Монгол, Унгар улсууд нь 1990 оны социалист нийгмийн өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцын үр дүнд тухайн улс орнуудын улс төрийн тогтолцоо, нийгмийн байгуулал үндсээрээ өөрчлөгдөж, шинэ хөгжлийн замаар замнаж, өнөөдөр 30 гаруй жил өөр өөрийн өнгө аясаар хөгжиж ирлээ. Энэ хугацаанд улс орон бүр өөрийн бэрхшээл сорилтыг даван туулсан ба мөн тус тусын ололт амжилтыг бий болгон хөгжиж байна. Тиймээс эдгээр орнуудын улс төр, эрх зүй, нийгэм, эдийн засаг, оюун санааны өөрчлөлт хэрхэн явагдав, ямар ололт амжилтанд хүрэв, ямар сорилт бэрхшээл тулгарав гэдгийг

задлан шинжилж, харьцуулан дүгнэж, дүн шинжилгээ хийх, цаашдын гарц шийдлийг тодорхойлох шаардлагатай гэж үзсэн. Зорилго нь нэгдүгээрт: шинэ залуу эрдэмтэн судлаачдыг бэлтгэх, сургах, дадлагажуулах, тэднийг гадаадын сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагаатай танилцуулах; хоёрдугаарт: Монгол, Унгарын эрдэмтэн судлаачдыг харилцан солилцох, туршлага судлах; гуравдугаарт: хамтарсан төслийн үр дүнд англи хэл дээр нэг сэдэвт бүтээл гаргах зорилготой юм.

Монгол-Унгарын ШУА хоорондын мобилити судалгааны төсөл авсанаас хамтын ажиллагаа эхлэнгүүт Унгарын талын төслийн удирдагч С.Жолт Монгол улсад айлчлан ирж төслийн нээлтийн уулзалтыг хийж, 2024-2026 онд хийх ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Мөн төслийн багийн судлаачдын мэргэшсэн байдлыг харгалзан сонгон шалгаруулалт хийж, ажлын чиглэлийг эртнээс гарган хуваарилж, өөрсдийн хариуцсан чиглэлээр илтгэл, өгүүлэл бэлтгэн ажиллаж байна.

2024 оны 05 дугаар сарын 25-наас 06 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл Монгол улсын ШУА-ийн Философийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн

дарга М.Анара, тус хүрээлэнгийн Бодлого судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан Д.Чулуунгэрэл нар Унгар улсын ШУА-ийн Нийгмийн угсаатны зүйн хүрээлэнд зочилж мөн бусад нийгмийн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачидтай уулзан туршлага судалж, судалгааны материал цуглуулж амжилттай ажиллаад ирсэн. Энэ хүрээнд тухайлбал, ELTE Нийгмийн Шинжлэх Ухааны Судалгааны Төвийн Улс Төрийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн судалгааны профессор,

социологич доктор Валух Тибор, ELTE Хүмүүнлэгийн Ухааны Судалгааны Төвийн Философийн Хүрээлэнгийн судалгааны ажилтан доктор Сабадош Беттина, ELTE Нийгмийн Шинжлэх Ухааны Судалгааны Төвийн Социологийн Хүрээлэнгийн судалгааны профессор доктор Ковач Имре нартай зөвлөлдсөн.

Мобилити судалгааны Монголын талын судлаачдын судалгааны чиглэл буюу ажил үүргийн хуваарийг та бүхэнд танилцуулъя. Үүнд:

№	Гүйцэтгэх ажил	Ажил гүйцэтгэгчийн нэр	Хугацаа	Тайлбар
1	Монголын нийгмийн оюун санааны өөрчлөлт: Боловсрол, ёс зүй, хүний хөгжлийн асуудал	М.Анара (Философийн хүрээлэнгийн ЭНБД)	2024-2026	
2	Монголын нийгмийн оюун санааны өөрчлөлт: Соёлын бодлогын асуудал	Д.Чулуунгэрэл (Философийн хүрээлэнгийн ЭША)	2024-2026	
3	Монголын нийгмийн өөрчлөлт: Нийгмийн бодлого, эрүүл мэндийн үйлчилгээ, амьдралын хэв маягийн өөрчлөлт, нийгмийн халамж хамгааллын үйлчилгээ, хүний хөгжлийн асуудал	С.Энхжин (МУБИС-ийн Түүхийн багш)	2024-2026	

4	Улс төр, хуулийн өөрчлөлт: Улс төрийн орчны тухай (сонгуулийн тухай, улс төрийн нам, төрийн алба, иргэний нийгэм г.м), хууль тогтоох институцийн өөрчлөлт (төрийн тэргүүн, үндсэн хууль, хууль тогтоох институт, гүйцэтгэх засаглал, хуулийн шинэчлэл, өөрчлөлт, нуггийн удирдлага г.м)-ийн асуудал	В.Удвал (Шихихутаг ИС-ийн эрх зүйн багш) О.Эрдэнэчимэг (Философийн хүрээлэнгийн Ёс зүй, сэтгэл судлалын салбарын эрхлэгч) Ж.Бямбасүрэн (Философийн хүрээлэнгийн ЭША)	2024-2026	
5	Эдийн засгийн бодлого, зах зээлийн тогтолцоонд шилжсэн нь, хөдөлмөрийн зах зээл, мөнгөний бодлого, экспорт, импорт	Даваасүрэн (Олон улс судлалын хүрээлэн)	2024-2026	
6	Дүгнэлт бичих	О.Эрдэнэчимэг (Философийн хүрээлэнгийн Ёс зүй, сэтгэл судлалын салбарын эрхлэгч)		
7	Хариуцсан сэдвээрээ мэдээллийн сан бүрдүүлэх	Төслийн багийн гишүүд	2024-2025	
8	“Унгарын нийгмийн өөрчлөлт” сэдэвт номыг олох	О.Эрдэнэчимэг (Философийн хүрээлэнгийн Ёс зүй, сэтгэл судлалын салбарын эрхлэгч)	2024	
9	Хариуцсан сэдвээрээ англи хэл дээр өгүүлэл бичнэ. Өгүүлээ Унгар руу илгээж хэвлүүлнэ.	Төслийн багийн гишүүд	2024-2026	

10	Унгар явж судалгааны ажилтай танилцах (төслийн хугацаанд жилд 2-3 судлаачийг томилолтоор явуулах)	Төслийн багийн гишүүд	2024-2026	
11	2026 онд харьцуулсан судалгаагаар нэг сэдэвт бүтээл англи хэл дээр гаргах	Төслийн багийн гишүүд	2026	

Бидний хэрэгжүүлж буй Мобилити судалгааны онцлог нь судлаачдын харилцан туршлага судлах ирж очих замын зардлыг тухайн ШУА хариуцна, харин очсон газрын байр, хоолны зардлыг тухайн ШУА хариуцахаар гэрээ хэлэлцээрт тусгагдсан болно. Манай хамтарсан Мобилити судалгааны төслийн багийн гишүүд цаашид “Орчин үеийн Унгарын нийгмийн өөрчлөлтүүд: Социализмаас өнөөг

хүртэлх” номын орчуулгыг өөр өөрсдийн сэдвийн хүрээнд хийх юм. Мөн 2025 оны 5 дугаар сард “Орчин үеийн Монголын нийгмийн өөрчлөлт: онцлог, сургамж” Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг Улаанбаатар хотод зохион байгуулахаар ажиллаж байна. Бидний эцсийн зорилго англи хэл дээр нэг сэдэвт бүтээл гаргах явдал хамгийн чухал зорилт юм.

МОРЬТОН НҮҮДЭЛЧДИЙН ОЙРЫН ЗАЙН ТУЛААН

Др.Хидан Чобо Ласло

Кароли Гашпарын Шинэчлэлийн Их Сургууль, Археологич-түүхч

Цөөн хүнийг илдээр устгадаг харин олон мянган хүнийг нум сумаа харван хөнөөдөг, учир нь тэд нарийн нумаараа маш мэргэн чадварлаг харвадаг тул сумнаас хамгаалах хамгаалалт бараг байдаггүй хэмээн X зууны үеийн унгарчуудын дайтах урлагийн талаар Регина Руми Апад онц цагийн сударт бичсэн байдаг.

Тал нутгийн морьтон нүүдэлчдийн морин дээрээсээ нум сумаар харвах нь хамгийн аюултай байсан бөгөөд нум сум тэдний хувьд хамгийн чухал зэвсэг байв.

Нүүдэлчид урагш довтолходоо болон ухрахдаа морин дээрээсээ маш сайн харвадаг байсан нь дайснуудадаа өөрсдийгөө хамгаалах боломж олгодоггүй ихэнхдээ үхэл авчирдаг байсан.

Ромын түүхчдийн тэмдэглэснээр, хүннүчүүд тулааны үед галзуурсан мэт аашилсан ч гэсэн, байгаа маш мэргэн онодог байсан. Өөр нэгэн түүхч Хүннүгийн хаадын нууц нь чадварлаг морьтнуудад оршдог хэмээн тэмдэглэсэн байдаг. Эртний үеийн урлагийн бүтээлүүд болон дундад зууны үеийн сурвалжуудад тал нутгийн нүүдэлчдийн талаар тэмдэглэхдээ, нумаа хөвчилсөн баатрын дүрээр дүрсэлдэг. Алдарт Куль Обогийн Скифийн олдвороос хөвчилсөн нум сум барьсан хүний алтадсан дүрс олдсон. Еэли Пэй жононгийн зосон зурган

дээр тал нутгийн аймшигт эвэр нумыг дүрсэлсэн байдаг.

Сасанидийн мөнгөн тавганууд дээр нум сум, жижиг дүрснүүдийг дүрсэлсэн байдаг бол Кримийн хойг болон Төв Азийн Саяны уулсад тал нутгийн морьтон харваачид зориулсан хөшөө дурсгал босгосон байдаг. Дундад зууны үеийн Баруун Европын нэгэн мөргөлийн бичигт “Бурхан минь биднийг унгарчуудын сумнаас хэлтрүүлж өгөөч” хэмээн бичсэн байдаг. Нүүдэлчдийн байлдааны тактикийн эсрэг, тэр тусмаа морьтон унгарчуудын эсрэг барууныхан тухайн үедээ яаж ч чаддаггүй байсан. Энэ нь олон зуун жилийн өмнө хүннүчүүдийн довтолгооны эсрэг барууныхан хүчин мөхөстөж байсантай адилхан юм.

Тал нутгийн нүүдэлчдийн тактикийн нууц нь юунд байна?

Дайснаа тагнах, гэнэтийн довтолгоо, бүслэлт, ухарч зугтан отоонд оруулах гэх мэт тактик нь эрдэмтэн Балашигийн хэлснээр “нүүр тулсан амьд тулаан” байсан.

Олон судлаачдын дунд нүүдэлчид ойрын тулаанд ордоггүй байсан гэсэн буруу ойлголт тархсан байдаг. Түүхэн сурвалжууд, эртний дурсгалуудыг анхааралтай уншиж судалсан хүмүүс “Энэ бол маш буруу ойлголт” хэмээн няцаалт хийдэг. Үнэн хэрэгтээ маш олон төрлийн зэвсэг морьтон нүүдэлчдээс

үүсэл гаралтай байдаг. Скифүүд урт илд ашиглаж байжээ. Тухайлбал, Казакын Тукасканаас олдсон булшнаас 125 см урт хоёр талдаа иртэй илд гарч ирсэн. Мөн Сийкей нутгийн Албудайгийн Скифийн булшнаас 118 см урт илд олдсон. Эдгээр илднүүд нь ишэн дээрээ хөндлөн төмөртэй байсан. Кавказийн Ереван хотоос холгүй Каблибурын булшнаас мөн Скифийн үеийн урт илдийг олсон байдаг. Скифүүд маш олон төрлийн цохих, цавчих зэвсгийг ашигладаг байсан бөгөөд ийм төрлийн олдворууд Монголоос мөн олдсон байдаг.

“Чингисхаан” Үндэсний музейд Скифийн үеийн олон жоотуу байгаа. Скифүүд жоотууг төмрөөр хийдэг байсан бөгөөд одоо миний гар дээр нэг талдаа морины толгойтой төстэй иртэй нөгөө талдаа аймшигт сүхтэй цохидог скиф жоотуу байна.

Нүүдэлчдийн бүтээсэн өөр нэгэн зэвсэг бол Хүннүгийн урт илд юм. Миний гар дээр дөрвөн иртэй печенег үндэстний муна байна. Барууны цэргүүд ялтсан хуяг өмссөн үед тал нутгийн нүүдэлчин мунаар цохиод л ясыг нь хугалдаг байсан. Тал нутгийн нүүдэлчид мөн богино илдийг ашигладаг байсан. Хүннүчүүд гурван төрлийн илд ашигладаг байсан.

Мөн надад Хүннүгийн богино илд байна. Жаматугайн булшнаас хоёр талдаа иртэй ишийг нь хөндлөн төмрөөр бэхэлсэн урт илд, богино хэмжээний иш нь хамагалалтгүй илд болон жижиг байлдааны хутга гарч ирсэн.

Морьтон нүүдэлчдийн бас нэгэн ололт нь сэлэм байсан. Он-Угорын хоёр удаагийн довтолгоон буюу унгарчуудын нүүдэлтэй холбоотойгоор сэлэм нь

Карпатын сав болон Зүүн Европт тархсан. Дэлхийн 1-р дайныг хүртэл тал нутгийн нүүдэлчдийн хувьд сэлэм нь хамгийн чухал цавчиж хатгадаг зэвсэг хэвээр байсан.

Хамгийн сонирхолтой нь, төмөр хуягийг нэвтэлдэг жоотуу сүхний үзүүр нь нүүдэлчдийн хувьд том байдаг. Вашар болон Каркар нутгийн дархчуулын урласан бүтээлүүдийг Нодьсентмиклошийн 2-р булшнаас олдсон олдворуудаас харахад хөнгөн ялтсан хуягийг хэрэглэдэг байсан байна. Перм нутгийн баатрууд хөлөө хүртэл битүү хамгаалсан ялтсан хуяг өмсдөг байсан. Хуягийг скифүүдийн үеэс хэрэглэж эхэлсэн. Арпандаас олдсон Скифийн булшнаас цээжээ хамгаалахад зориулагдсан төмөр, хүрлээр хийсэн хуяг олдсон. Мөн тухайн булшнаас жад болон жоотуу сүх гарсан. Түүхэн сурвалжуудад скифүүд ойрын зайд тулалдсан тухай мөн тэдний ойрын зайн зэвсгийн талаар дурдсан байдаг. Херодот тэмдэглэлдээ, скифүүд цусан тангараг өргөхдөө аяганд дарс хийж, дээр нь цусаа дусаан түүндээ зэвсэг (илд, жад, жоотуу, сум)-ээ дүрдэг байсан талаар дурдсан байдаг. Лукианус Херодотын адил цусан тангаргийн талаар дурдсанаас гадна хоёр удаагийн халз тулааны тухай тэмдэглэсэн байдаг. Скифийн Арсокумас баатар болон Аланы Адирмах баатар хоёр морин дээрээс халз тулалддаг. Арсокумас эсрэг талын баатрыг жадаар хоёр хуваан устгадаг. Лукианус мөн Амастесийн театрт халз тулаан зохион байгуулдаг байсан тухай тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, Шишинес гэдэг скиф асар том биетэй грек эрийг илдээр цавчин алдаг. Скифийн баатар Шишинес хуягтай байсан боловч дуулга өмсөөгүй байсан талаар мөн тэмдэглэсэн байдаг.

Скифүүд дуулга өмсдөг байсан. Үүний баталгаа нь Монголын Хутаг-Өндөрөөс олдсон Келермесээс олдсон дуулгатай төстэй скифийн хүрэл дуулга юм. Монголын түүхэн сурвалжуудад хоёр болон гурван давхар ялтсан хуягны талаар тэмдэглэсэн байдаг. “Их шар” сударт Харагчуг нэртэй баатартай тулалдахдаа хоёулаа гурван давхар хуяг өмссөн байсан тухай тэмдэглэсэн байдаг. Скиф болон монголчуудын хувьд аль аль нь тал нутгийн морьтон дайчид юм. Орхоноос олдсон “Култегений бичиг”-т тулалдааны үеэр хуяг өмсдөг байсан тухай тэмдэглэсэн байдаг. Хүрэл болон зэсээр урласан хуяг руу нь 100-аас дээш тооны сум зоогдсон тухай тэмдэглэсэн байна.

Нүүдэлчдийн ойрын зайн тулалдааны хувьд жад бол маш хөнөөлтэй зэвсэг бөгөөд өмнө нь дурдсанчлан Арсокумас баатар Адирмахыг жадаар хоёр хуваан цавчиж устгасан байдаг. Култегений “Орхоны бичээс”-т бичсэнээр 10 удаагийн халз тулааны найм нь жад, нэг удаа илд, нэг удаа нум сум ашигласан байдаг. Сонирхолтой нь, Ипотескийн сударт кипчакуудын талаар бичихдээ, тогоруунууд хошуугаа хөдөлгөж буй мэт тэд жадыг маш сайн эзэмшсэн хэмээн дурдсан байдаг. Бела IV хааны 1243 оны 7-р сарын 5-нд бичсэн Детребанд хишиг хүртээх захидалд, түүний тулалдааны үеэр байгуулсан гавьяаг дурсан “Тэрээр хамгийн түрүүнд тулаанд орж 2-3 удаа жадаа эргүүлэн дайсныхаа тэргүүн эгнээг задалж, олон дайсныг устгасан” хэмээн дурдсан байдаг. “Жамми Ал Таварых”-ын сударт монголчуудын жадаар дайтах чадварыг дүрсэлж үлдээсэн байдаг. “Жамми Ал Таварых”-ын судар 1306 онд бичигдсэн. Ялтсан хуягаар хуяглаж, нум саадгаа агссан монгол баатрууд сэлэм, жадаар

тулалдаж буйг дүрсэлсэн бөгөөд мөн хоёр гараараа жадаа барин тулалдаж буйг дүрсэлсэн байдаг. Хоёр гараараа жад барин тулалдах нь нүүдэлчдийн хувьд нэлээн тархсан тулалдааны арга барил юм. Монголчууд өнөөдрийг хүртэл адуугаа уургаар барьдаг ба тэд морио уургалахдаа уургаа хоёр гараараа барьдаг. Дундад зуунд монголчуудын дэгээтэй жад маш аймшигт зэвсэг байсан. Би 30 жилийн өмнөөс сэлэм, жоотуу, сүх, жад зэрэг зэвсгээр долоо хоног бүр тогтмол дасгал сургуулилт хийдэг. Миний хийдэг дасгалаас үзэхэд, монгол дэгээт жад бол маш аюултай зэвсэг юм. Хүннүчүүд 11 төрлийн хатгах, цавчих зэвсгийг ашигладаг байсан. Тэдэнд гурван төрлийн илд (урд, дунд, богино илд, алтан илд, ишийг нь эрдэнийн чулуугаар чимэглэсэн илд) байсан. Хүннүчүүд хоёр гараараа барьдаг урт илдийг мөн ашигладаг байсан. Энэ бол Зүүн Европоос олдсон Хүннүгийн хоёр гараараа барьдаг илдний хуулбар юм. Азийн Тувозвоны болон Зүүн Европын Тураёваас олдсон булшнуудаас Хүннүгийн хоёр гартаа барьдаг илдийг археологичид олсон.

- Хүннүгийн хөндлөн иштэй илд ийм байсан. Хөндлөн төмрөөр ишийг хамгаалж, бат бөх төмрөөр ишний төгсгөлийг урласан байдаг.

Морьтон нүүдэлчид маш олон төрлийн цохих болон цавчих зэвсгийг ашигладаг байсан. Алмуш болон Арпадын унгарчууд найман төрлийн зэвсэг ашигладаг байсан бол аварууд ч мөн найман төрлийн зэвсэг ашигладаг байсан.

Сонирхолтой нь, хүнд хуягаар хуягласан дайсныхаа эсрэг дэгээт жоотууг ашигладаг байсан байна. Энэ бол Арпадын унгарчуудын

дэгээт жоотуун сүх юм. Энэ ойрын зайн тулааны аймшигт зэвсгийн нэг бөгөөд нэг талаар нь цавчиж, нөгөө талаар нь дайсныхаа дуулгыг цөмлөх зориулалттай зэвсэг юм. Мөн энэхүү зэвсгээр дайсныхаа гарыг ороон хөшиж, зэвсгийг нь алдуулан гарыг нь гэмтээх боломжтой. 110-120 см урт зэвсгийг хоёр гараараа атган мушгихад маш их хүч гаргана. Энэхүү зэвсгээр дайсныхаа зэвсгийг алдагдуулна эсвэл бугуйг нь хөшиж хугалах боломжтой.

Товчхон дүгнэж хэлэхэд, тал нутгийн нүүдэлчин ард түмэн маш олон тооны ойрын зайн зэвсгийг бүтээсэн бөгөөд энэ бүгдийг археологийн малтлагуудаас гарч ирсэн олдворууд баталж байна. Тал нутгийн нүүдэлчин ард түмний булшнаас гарч олдворууд, түүхэн сурвалжуудаас үзэхэд тэд зэвсгийн эрдмийг төгс эзэмшсэн байсан байдаг. Олон эх сурвалжуудад тэд зэвсгээс гадна нүцгэн гараараа хүртэл маш тулалдаж чаддаг байсан тухай тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, Константинополь

хотын өмнө Бодон баатар Грекийн баатарыг нүцгэн гараараа барилдан ялсан тухай тэмдэглэсэн байдаг. Мөн Монгол нутгаас Карпатын сав газар хүртэл амьдарч буй ард түмнүүд хамгийн алдартай бөхчүүдтэй ард түмэн гэдгийг бид мэднэ. Казакийн кизыл кус, монголын бөх, татарын кирпинар, унгарын си барилдаан эдгээр нь ойрын гардан тулааны хамгийн хүнд хэлбэрүүд нь юм.

Төгсгөлд нь энэхүү ойрын тулааны зэвсгүүд нь ямар үүрэгтэй байсныг хэдэн үгээр дүгнэе. Унгарын хаадыг хаан ширээнд өргөмжлөхөд үйлддэг зан үйл бөгөөд хамгийн сүүлд 1916 онд Карой хааныг хаан ширээнд залахад тэрээр морьтойгоо толгод дээр гарч ирээд гэгээн Иштван хааны илдээр дөрвөн зүгт хүндэтгэл үзүүлэн аль зүгээс дайсан ирсэн ч ард түмнээ хамгаална хэмээн тангараг өргөдөг. Сэлэм бол 1300 гаран жил тал нутгийн нүүдэлчдийн ялалтын бэлгэ тэмдэг болсон зэвсэг байсан.

ТӨМСНИЙ БУЛЦУУ ҮҮСЭЛТ БОЛОН НАВЧНЫ ХӨГЖЛИЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Жофия Банфалви¹, Хонгорзул Одгэрэл^{1,2}, Эдина Чаквари¹,
Жени Жосе^{1,2} Михайл Кондрак²


Хураангуй

Гантай хуурай нөхцөл нь төмсний ургацад хамгийн их нөлөөлдөг хүчин зүйл юм. Харин эрт ургацын төмс нь орчны таагүй хүчин зүйлсэд бага өртөмхий бөгөөд энэ нь ургалтын үед стресс сөргөөр нөлөөлөхөөс урьдаар боловсорч дуусдагтай холбоотой. Түүнчлэн эрт ургацын сортуудын ургацын ашиг шимт чанар, гарц зэрэг нь хожуу сортуудынхаас илүү байдаг. Иймд судлаачид эрт ургацын төмсний сорт гарган авах, үржүүлэх судалгаанд их төвлөрдөг ба бидний судалгааны зорилго нь хоёр ялгаатай сортын төмсийг залгах буюу графтингийн аргаар ургуулж, түүний молекул механизмыг судлах явдал юм. Судалгааны үр дүнгээр хүлэмжийн нөхцөлд бортогонд ургуулсан 2 сортын төмсийг өөр хооронд нь залгаж ургуулахад газрын дээд хэсгийн хөгжлөөс газрын доод хэсгийн булцуу үүсэх процесс хамаарч байгааг тогтоосон. Навчны хөгжлийг сааруулж, хэмжээг багасгадаг *Arabidopsis*-ийн гентэй ортолог 3 генийг тодорхойлон, төмсний навчны хэмжээг өөрчлөх боломжийг судлахаар тодорхой хэсгүүдийг ПГУ-аар олшруулан төмсөнд антисенс байрлалд шилжүүлэн үр дүнг боловсруулав.

Түлхүүр үг: *Solanum tuberosum*, булцууны хөгжил, навчны хөгжил, транскрипцийн зохицуулга

Оршил

Төмсний булцуу гэдэг нь дүрс хувирсан иш бөгөөд газрын доод хэсэгт столоны суналт явагдсаны дараа түүний үзүүрийн хэсгээс булцуу үүсэлт эхэлдэг нь генетикийн хувьд тодорхойлогдсон физиологийн процесс юм. Булцуу үүсэх нь эсийн хуваагдал болон суналтын ээлжилсэн процессоор явагдана (Cutter 1978).



Зураг 1. Төмсний булцуу үүсэхэд оролцдог генүүдийн бионийлэгжлийн зам

Булцууны бионийлэгжлийн зам нь *Arabidopsis*-ийн цэцэглэлтийн үеийн бионийлэгжлийн замтай маш төстэй (Зураг 1). CONSTANS төст (CO1) транскрипцийн фактор нь булцуу үүсэхэд гол үүрэг гүйцэтгэдэг бөгөөд түүний нийлэгжлийг CYCLING DOF FACTOR 1 (CDF1) дарангуйлдаг. Түүнээс гадна GIGANTEA (GI1) болон

¹ Генетик, Биотехнологийн хүрээлэн, УХААИС, Гөдөлө

² Биологийн хүрээлэн, ШУА, Улаанбаатар

FLAVIN-BINDING KELCH REPEAT F-BOX PROTEIN (FKF1) - циркадийн хэмнэл болон цэнхэр гэрлийн мэдрэг байдлыг хариуцдаг уургууд байгаа бөгөөд CDF1-тэй холбогдвол задралд орж, их хэмжээний CO1 уураг үүснэ. CO1 нь SELF-PRUNING 5G (SP5G)-ийн нийлэгжлийг өдөөдөг бөгөөд энэ нь цаашлаад булцуу үүсэх замын өдөөдөг мобил пептид болох SELF-PRUNING 6A (SP6A)-ийн нийлэгжлийг дарангуйлдаг. Тиймээс CDF1 нь SP6A-ийн нийлэгжил болон столоноос булцуу үүсэх процессд шууд бусаар оролцох ба MADS-бокс транскрипцийн факторуудаар дамжуулан булцууны хөгжлийг эхлүүлдэг гэсэн таамаг бий (Kloosterman et al. 2013; Gao et al. 2018).

Булцууны үүсэлт, хөгжил нь навчны бодисын солилцооны болон транскрипцийн зохижуулгаас хамаарна. Метаболитууд нь навчнаас флоэмээр дамжин булцуунд хүрнэ. Навчны генотип нь булцууны хөгжилд хэрхэн нөлөөлдөг вэ, хэрэв бид навчны хөгжлийг түргэсгэвэл булцууны хөгжлийг хурдасгаж чадах уу? гэсэн асуултуудад хариулахын тулд графтингийн туршилтыг эхлүүлж, төмсний булцуу үүсэлтийг түргэсгэх генийн судалгааг хийв.

Материал, арга зүй

Ургамлын дээж материал болгон төмсний (*Solanum tuberosum* L.) ‘*Désirée*’, ‘*White Lady*’ болон ‘*Hórehely*’ гэсэн 3 төрлийн худалдааны сортуудыг ашигласан. Ургамлыг *in vitro* нөхцөлд 2% сахароз болон 0.8% агар (витамингүй MS тэжээлт орчин - Murshige&Skoog 1962) агуулсан RM тэжээлт орчинд өсгөвөрлөн олшруулж, 16/8 цаг гэрэлтэй/харанхуйд (75 мкмоль

м-2 с-1), 24°C температурт ургуулав. Нэг сарын дараа ургамлыг хүлэмжийн нөхцөлд (12-14 цагийн гэрэлтэй, 20-24°C) ариутгасан хүлэрт хөрстэй саванд ургуулж, дасан зохицсоны дараа графтинг буюу залгаж ургуулсан. Ингэхдээ 100 мл-ийн багтаамжтай бортгонд тарьсан ургамлуудын ишийг навчны бариулын доогуур ташуу, зориулалтын хурц иртэй хутгаар зүсэн нэг ургамлын дээд хэсгийг нөгөө ургамлын доод хэсэгт залгасан. Залгасан хэсгийг зориулалтын хуванцар хавчаараар (Brinkman PT7 1.5 мм) холбон тогтоосны дараа ургамлуудыг тагтай саванд хийж, нэг долоо хоногийн турш бага гэрлийн эрчимд байлгаж хүлэмжний нөхцөлд ургуулсан. Хоёр долоо хоногийн дараа залгасан хавчаарыг авч, ургамлыг 1 литрийн багтаамжтай бортгонд шилжүүлэн суулгасан. Навчны хөгжлийг тоон үзүүлэлтээр тодорхойлохын тулд зургаан долоо хоногтой ургамлын хамгийн том таван навчийг цаасан дээр дугуйлж, хайчилж аваад, цаасыг аналитик жин дээр жигнэсэн. Булцууны хөгжлийг тодорхойлохын тулд ургамлыг хөрстэй нь савнаас гаргаж, үүссэн булцууны тоо, хэмжээг тэмдэглэн авав.

Төмсний *Arabidopsis*-той ортолог генүүдийг BLAST (Basic Local Alignment Search Tool) ашиглан тодорхойлж, ПГУ праймерийн тусламжтай хүсэж буй хэсгүүдийг олшруулсан. ПГУ праймеруудыг Primer-BLAST онлайн програмаар зохион Integrated DNA Technologies компанид нийлэгжүүлэв. Темплэт ДНХ-г ‘*Désirée*’-ээс Shure et al.-ийн аргаар (1983) ялгаж, Dream Taq полимеразыг протоколын дагуу ашигласан (Thermo Fisher Scientific). ПГУ-ын бүтээгдэхүүнийг агарозын гель дээр гүйлгэн, BIOMI ХХК-д дарааллыг




уншуулсаны дараа сонирхож буй ПГУ-ын хэсгийг pGEM-T Easy клонинг вектор (Promega Corporation) оруулан, олшруулав. Үүссэн ДНХ-ийн дарааллыг BLAST программаар шалгасан.

Үр дүн

Төмсний булцууны хөгжлийг навчнаас хамааруулан судлах зорилгын хүрээнд 'White Lady' ба 'Hórehely' (WL, HP) гэсэн сортуудыг үндэсний сток болон навчны дээж болгон ашиглаж, графтингээр залган ургуулав. Ургамлыг анх *In vitro*-д өсгөвөрлөн авч хөрсөнд шилжүүлсэн ба графтингээр залгаж ургуулаагүй ургамлуудыг хяналт болгон авсан. 6 долоо хоногийн дараа залгасан болон залгаагүй ургамлуудын хамгийн таван навч, нэг ургамлаас үүссэн булцууны тоо, хөгжлийг хэмжсэн ба бүх туршилтыг 2 удаа давтсан.

Судалгааны үр дүнгээр White Lady-ийн навчны хөгжил Hórehely-ээс илүү байгаа (зураг 2) нь графтинг Hórehely-ийн хөгжилд нөлөө үзүүлсэн гэдгийг илтгэнэ. Графтингийн үр дүнгээр булцууны хөгжил болон навчны хэмжээ нь эерэг хамааралтайг тогтоолоо.

Зураг 2. 'Hórehely', 'White Lady'-ийн графтингийн амжилт, булцуу болон навчны хөгжлийн хамаарал



HP, 'Hórehely'; WL, 'White Lady'; ◊, 1-р туршилтын үр дүн; ♦, 2-р туршилтын үр дүн

Навчны хөгжлийг түргэсгэхийн тулд *Arabidopsis* мутантуудын фенотип дээр үндэслэн гурван генийг сонгосон ба эхний ген нь GIGANTEA (GI) болно. GI мутантууд нь урт өдрийн нөхцөлд оройтож цэцэглэхээс гадна вегетацийн хугацаа нь оройтсоноос болж розеттэ хэлбэрийн аварга навчтай байдаг шинж чанарыг үзүүлдэг бөгөөд Редей (1962)-н нэрээр нэрлэгдсэн ген юм. Одоогийн байдлаар GI уураг нь төмсний булцууны хөгжилд оролцдог гэдэг нь мэдэгдэж буй ба (Park et al. 2016). Дараагийн сонгосон генүүд нь убихитин рецепторын уураг болох DA1 болон E3 убихитин лигаза ген BIG BROTHER (BB) бөгөөд эдгээр генүүдийн мутантууд *Arabidopsis*-д навчны хөгжлийг түргэсгэх шинж тэмдэг үзүүлсэн байна (Vanhaeren et al. 2017).

Сонгосон генүүдийн төмсний ортологуудыг BLAST программаар тодорхойлж, тодорхой хэсгүүдийг зохиосон праймеруудыг ашиглан ПГУ-аар олшруулсан (Хүснэгт 1, Зураг 3). ПГУ-ын бүтээгдэхүүнийг ДНХ секвенцингээр тодорхойлон улмаар


клоны векторт шилжүүлэн олшруулж, *Agrobacterium*-аар дамжуулан төмсөнд шилжүүлсэн. Бид ургамлын ургалтыг түргэсгэх зорилгоор түүнд оролцдог генийн нийлэгжлийг зохицуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хүснэгт 1. 'Desirée'-ийн геномын ДНХ-с зохиосон ПГУ-ын праймерууд

Ген	Ген банкны дугаар	Дараалал 5'→3'	PCR нөхцөл	Урт bp
GI	XM_006361555.2	*GAATTCACCATGGGAAGCACACCTAATA GGTACCGGCCAAATCTGAAGCATCTAA	95°C 5', (95°C 30", 54°C 30", 72 °C 1') x 34, 72 °C 10'	250
DA1	XM_015304888.1	GAATTCGACCCCTTTTTGAATGCTTGA GGTACCGTGCTGCAACCTGCACATAC	95°C 5', (95°C 30", 58°C 30", 72 °C 1' 10") x 34, 72 °C 10'	485
BB	XM_006356318.2	AGAATTCACATCAAAGCGGTGAAGCAAA AGGATCCACAGAACACGTGGTACAAAGC	95°C 5', (95°C 30", 56°C 30", 72 °C 1' 10") x 36, 72 °C 10'	210

*Рестрикцийн энзимийн сайтуудыг доогуур нь зурж тэмдэглэв.

Зураг 3. 'Desirée'-н геномын ДНХ-ээс олишруулсан GI, DA1 болон BB генүүд



Талархал

Энэхүү судалгаа нь NKFI -ийн NN 124441 дугаартай Грант төслийн хүрээнд хийгдсэн болно.

Эх сурвалж

Cutter, E.G. (1978): Structure and development of potato plant. *In: The Potato Crop*, Harris P.M. (ed.) Chapman and Hall Press, London, pp. 70-125.

Gao, H., Wang, Z., Li, S., Hou, M., Zhou, Y., Zhao, Y., Li, G., Zhao, H., Ma, H. (2018): Genome-wide survey of potato *MADS-box* genes reveals that StMADS1 and StMADS13 are putative downstream targets of tuberigen StSP6A. *BMC Genomics*, **19**, 726.

Kloosterman, B., Abelenda, J.A., Gomez, M.D.M.C., Oortwijn, M., de Boer, J.M., Kowitzanich, K., Horváth, B.M., van Eck, H.J., Smaczniak, C., Prat, S., Visser, R.G., Bachem, C.W. (2013): Naturally occurring allele diversity allows potato cultivation in northern latitudes.

Nature, **495**, 246-250.

Murashige, T., Skoog, F. (1962): A revised medium for rapid growth and bioassays with tobacco tissue cultures. *Physiologia Plantarum*, **15**, 473-497.

Park, H.J., Kim, W.Y., Pardo, J.M., Yun, D.J. (2016): Molecular interactions between flowering time and abiotic stress pathways. *International Review of Cell and Molecular Biology*, **327**, 371-412.

Rédei, G.P. (1962): Supervital mutants of *Arabidopsis*. *Genetics*, **47**, 443-460.

Shure, M., Wessler, S., Fedoroff, N. (1983): Molecular identification and isolation of the *Waxy* locus in maize. *Cell*, **35**, 225-233.

Vanhaeren, H., Nam, Y.J., De Milde, L., Chae, E., Storme, V., Weigel, D., Gonzalez, N., Inzé, D. (2017): Forever young: The role of ubiquitin receptor DA1 and E3 ligase BIG BROTHER in controlling leaf growth and development. *Plant Physiology*, **173**, 1269-1282.

ТӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТАЛААРХ УНГАРЧУУДЫН СЭТГЭГДЭЛ

Кишш Роберт Рихард

Кодоланий Яаношын Их сургуулийн декан, дэд профессор

Унгарчууд төрийн хууль тогтоомж, төрийн байгууллагуудын талаар ямар бодолтой байгаа талаар судалгаа хийсэн юм. 1000 гаруй хүнээс судалгаа авсан бөгөөд босоо болон хэвтээ хэмжээсээр Унгарын нийгмийн бүлгүүдийн төлөөллийг түүврийн аргаар сонгон авч, судалгаагаа хийсэн.

Өнөөгийн Унгарын нийгэмд хууль тогтоомж нь хүн төрөлхтний өөрийн бүтээл хэмээн олон хүн үзсэн бол тодорхой хэсэг нь хууль тогтоомжийг бурхан бүтээсэн гэж хариулжээ. Гадны хүчин зүйлсийн нөлөөгөөр олон жил үргэлжилсэн социалист норматив хэм хэмжээний үр дүнд XXI зууны эхэн үед Унгарын төрийн байгууллагуудын гаргасан шийдвэр, бий болгосон норматив хэмжээг хууль хэмээн ойлгодог нэг хэсэг мөн байсан. Тэгвэл хуулийг байгаль, бурхадтай холбон тайлбарладаг хэсэг мөн байсаар байна.

Судалгаанд хамрагсдын 4% нь хуулийг байгаль болон бурхантай холбож үзсэн бол 27% нь бурхан хүн хоёр бүтээсэн хэмээжээ.

Байгалийн хуульд 3 том үе байдаг:

- Балар эртний үе
- Христийн үе
- Классик үе

Дэлхийн 2-р дайны дараа дайны гэмт хэрэгтнүүдийг шүүхтэй холбоотойгоор уламжлалт хуулийг баримтлах нь учир дутагдалтай байсан. Энэ үед Олон

Улсын шүүхийн хүрээнд ч бурханы сургаалыг дурдах болсон.

Хуулийг улс төр бий болгодог хэмээн олон хүн онцолдог. Зарим хүмүүс хуулийг үл үзэгдэгч эрх мэдэл удирддаг хэмээн үздэг. Шамо Михай өнөөгийн Унгарын улс төрийн систем дэх хэтэрхий их улс төржилтийг илэрч буй нийгмийн олон эмгэгүүдийн нэг хэмээн үзсэн. Хуулийн идеологи хамаарал нь хэмжээнээсээ хэтэрсэн хууль журам, хуулийн аноми болон хуулинд ойр ойрхон өөрчлөлт оруулах явдал юм. Хэтэрсэн хууль дүрэм нь хуулийн биелэлтэнд сөргөөр нөлөөлдөг. Унгарын нийгмийн улс төрөөс хамаарах хүчтэй хамаарал эртний уламжлалтай. Улс төртэй холбоотой хамаарал нь эдийн засгийн, нийгмийн болон урлагийн талбарт эрх мэдэлд хүрэх арга зам байсаар ирсэн.

Нийгмийн бүлгүүдийн улс төрөөс хамааралтай байдал нь нийгмийн бүлгүүдийн орчин үеийн дүр төрхийг хууль эрх зүйн гарал үүслийн хязгаарлагдмал бүтэцтэй холбох арга зам юм.

Шоую Андраш 1974 онд хийсэн судалгаандаа Унгар улсад хуулийг хэн баталдаг вэ хэмээн асуусан. 16 аас доош насныхны 41 хувь нь нам гэж хариулсан.

Одоогийн судалгаанд хамрагсдын 62.3% хувь нь хууль батлах үүргийг Парламент хүлээдэг хэмээн үзсэн.

Хуулийн гарал үүсэл болон хууль батлах нь тусдаа асуудлууд юм.

Үүнтэй холбоотойгоор эхний судалгаанд хамрагсдын 4%, сүүлийн судалгаанд хамрагсдын 10% бурхан чухал үүрэгтэй хэмээн үзсэн.

Унгар Улсад шүүх эрх мэдлийн байгууллагууд хуулийг боловсруулдаг хэмээн үздэг хэсэг маш олон байна. Хууль батлах явцыг нэгдсэн байдлаар нь авч үзвэл энэ нь үнэний ортой юм. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээс үзэхэд хууль, хуулийн байгууллагуудыг хууль батлахаас салгаж үзэж болохгүй юм.

Хуулийн гарал үүсэлтэй холбоотойгоор Ромын үед сургалт байсан бөгөөд түүнээс өмнө ч мөн байсан байдаг. Тэгэхээр төрт улсууд бий болсноор хууль зүй бий болсон гэж үздэг. Грек, Ромын үеэс хууль эрх зүй бий болсон гэж олон хүмүүс үздэг. Сонирхолтой нь, Ази тивийн талаар дурддаггүй.

Сонирхолтой судалгаанд хамрагсдын 8% нь хууль баячуудад үйлчилдэг хэмээн үзсэн байна. Гэвч 44% нь хэрэг заргыг шүүхэд л хууль үйлчилдэг үздэг.

Парламент, Засгийн газар, шүүх, цагдаа, татварын байгууллагууд шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд хууль үйлчилдэг хэмээн 16.8% үзсэн байдаг. Хууль нь ядуусын эрхийг хамгаалдаг хэмээн 6,6% үзсэн байдаг. 48% хувь нь хууль шударга ёсыг бий болгоход зориулагдсан хэмээн үзсэн байна. Тэгэхээр судалгаанд оролцогчдын тал хувь нь хууль нь шударга ёс хэмээн үздэг байна. Гэхдээ өөр олон төрлийн хариултууд мөн ирсэн бөгөөд тэдгээр нь нийт судалгаанд оролцогчдын дунд эзлэх хувь нь маш доогуур буюу хангалттай биш байсан. Тухайлбал,

хууль нь хүн өөрийгөө хамгаалахад зориулагдсан гэх мэт. Эсвэл гэмтнийг гэгсгээхэд чиглэгдсэн гэсэн хариултууд мөн ирсэн. Энэхүү судалгаа бичгээр хэвлэгдэн гарах үед та бүхэн диаграммуудаас хуулийн норматив хэм хэмжээний талаар унгарчууд ямар бодолтой байна, хуулийн гарал үүслийн талаар юу бодож байгаа талаар харах боломжтой юм.

Сонирхолтой нь, судалгаанд хамрагсдын 67,8% буюу гуравны хоёр нь хууль хүнээс гаралтай хэмээн үзсэн. Ёс суртахуун бурхантай холбоотой хэмээн үздэг цөөн хэсэг өнөө үед мөн байсаар л байна. Дүгнэн хэлэхэд, хууль боловсруулахад улс төрчид чухал үүрэгтэй бөгөөд хууль батлахад мэдээж олон нийтийн саналыг тусгасан байх ёстой хэмээн нэг хэсэг нь үзсэн байна.

Санал асуулгад оролцогчдын тал хувь нь хуулийн гарал үүслийг Грек, Ромоос гаралтай хэмээн үзсэн байна. Тэгэхээр тэд Грек, Ром үүсэвчээр л хууль бий болсон хэмээжээ. Хууль боловсруулагчдын дээр ямар нэгэн байгалийн хүч үйлчилдэг гэж үзсэн хүмүүс байсан нь маш сонирхол татсан. Үүнийг ёс суртахуунтай холбон тайлбарлаж болно.

Төр гэж юу юм бэ гэсэн асуултанд энэхүү судалгаа мөн чиглэгдсэн. Төр болон нормативын хооронд ямар хамаарал байна? Бид социологийн үүднээс мэргэжлийн түвшний хариултуудыг судалгаанд оролцсон дундаж хүнээс авна гэж тооцоолоогүй. Өдөр тутмын хариултууд нь мэргэжлийн чиглэлийн тодорхойлолтуудтай нийцэх нь ховор юм.

Төрийн байгууллагын функцууд их чухал юм. Энэ тухай Аристотель маш

олон тодорхойлолтыг хэлсэн байдаг. Платон, Маккавелли төрийн үүрэг юу вэ гэдэгт олон хариултууд өгсөн байдаг. Монтескио, Руссо нар төрийн тухай олон судалгаа хийсэн байдаг. Төрийн функц нь эдийн засаг, зохион байгуулалт, батлан хамгаалах хэмээн олон хүмүүс үздэг. Бид судалгаандаа хүмүүс төрийн тухай юу боддог вэ гэдэгт анхаарсан.

Төрийн ямар функцууд байна, төрийн үүрэг ямар вэ?

Бидний судалгаагаар төрдхаламжийн маш том үүрэг байдаг хэмээн олон хүн үзсэн байна. Унгарчууд бид төр хэрвээ ард түмэн бидэнд анхаарал хандуулж байвал шинэ зүйлсийг бүтээхдээ урам зоригтой байна гэж үзсэн байна. Төрөөс чиглүүлэн боломжуудыг нээж өгч байвал ард иргэд их дуртай байдаг.

Төрийн үүргийн ангилалтай холбоотой судалгаандаа бид амархан ойлгогдох асуултуудыг тавьсан. Бид асуултуудаа философи, хууль зүйн талаас тавиагүй. Төрийн гүйцэтгэх хэрэгжүүлэх үүргүүдтэй холбоотой асуулгаа боловсруулсан.

Абстракт маягаар шийдвэр гаргах түвшний үүрэгтэй холбоотой асуулгыг тавьсан.

Судалгаанд оролцогчдын тодорхой хэсэг нь төрийн тогтвортой байдал гэдэг дээр саналаа өгсөн байна. Төрийн хууль хэрэгжүүлэх шийдвэр гаргах үйл ажиллагаатай холбоотой саналууд мөн өгсөн байдаг. Дээр үед хаадын шийдвэр үйлчилдэг байсан бол өнөө үед Үндсэн хууль болон бусад хуулиуд төрийн шийдвэр гаргах хүрээг тодорхойлж байна.

Судалгааны явцад төрийн мэдээлэл харилцааны үүрэгтэй холбоотой

саналууд гарсан. Мөн төрийн нийгмийн хуваарилалт, халамжтай холбоотой саналууд ч өгсөн байна. Төрийн эдийн засаг, нийгмийн халамжийн үүрэг, батлан хамгаалах үүрэгтэй холбоотой саналууд мөн гарсан байдаг. Мөн улс төрийн имижийн тухайд, тухайн орны талаар гадаад орчинд сайн сайхан ойлголттой байх хэрэгтэй гэсэн саналууд байсан. Өнөө үед интернет орчинд Унгар Улсын талаар, Монгол Улсын талаар хүмүүс ямар бодолтой байна вэ гэдэг нь мөн чухал юм. Тиймээс энэ нь төрөөс явуулж буй соёл, урлаг, мэдээлэл харилцаагаар дамжсан үүргээ биелүүлэх арга зам юм. Энэ хүрээнд тухайн орны үнэ цэнэ, онцло, давуу талуудыг тодруулах нь чухал юм. Тэгэхээр энэ бүхэн нь төрийн мэдээлэл харилцааны үүрэгтэй холбоотой. Гадаад орчинд ямар имиж бүрдүүлэх вэ гэдэгтэй холбоотой шийдвэрийг мэдээж төрийн эрх баригчид гаргадаг. Тэгэхээр энэ бүх мэдээлэл харилцааны үүрэг нь тухайн орны соёлыг сурталчлах хэлбэрээр гадаад орчинд явагддаг. Тиймээс төр нь мөн соёлыг түгээх үүрэгтэй байдаг. Төрийн соёлын үүрэг дээр идеологийн болон ёс суртахууны функцүүд холбогддог. Тэгэхээр төр улсынхаа үнэ цэнийг гадаад орчинд сайн зөвөөр таниулах нь төрийн чухал функц юм. Төрийн гадаад орчинд бий болгосон эерэг имиж, үнэ цэнэ нь төрийн өөрийгөө хамгаалах дархлаанд эерэгээр нөлөөлдөг.

Өнөөгийн Унгарын нийгмийн хууль эрх зүйн тухай ойлголт, төрийн тухай ойлголтыг судлах явцад дээрх сонирхолтой судалгааны үр дүнд хүрлээ. Энэ судалгааг хийсний үр дүнд бид хачирхмаар үр дүнгүүдийг олж авсан. Тухайлбал, хүмүүс хуулийн талаар ямар ойлголттой байдаг ямар

хэмжээнд итгэл хүлээлгэдэг гэх мэт. Судалгаанд оролцогчдын ихэнх нь шүүхээр ороогүй хүмүүс байсан. Судалгаанд хамрагдагсад шүүх, татварын байгууллагуудад хэрхэн итгэл хүлээлгэж байна вэ гэдэг нь чухал юм. Дүгнэж хэлэхэд, судалгаанд оролцогчдын дийлэнх нь уламжлалт хуулинд бус орчин үеийн хууль зүйд итгэдэг нь харагдаж байна. Мэдээлэл харилцаа төрийн чухал үүргүүдийн нэг гэдгийг судалгаанаас харж болж

байна. Төгсгөлд нь хэлэхэд, 10 мянгаас хол давах хуулиуд байдаг боловч тэр бүгдийн талаар сайн харилцан ойлголттой байх нь чухал юм. Энэ бүх 10000 гаруй хуулийг энгийн хүн битгий хэл мэргэжлийн өмгөөлөгч хүн ч бүгдийг нь ойлгож уншиж чадахгүй. Тэгэхээр судалгаагаар төрийн хууль тогтоомж, төрийн эрх үүрэг, харилцаа холбооны үүргийн талаар хүмүүс ямар ойлголттой байгаа вэ гэдгийг үзлээ.

МОНГОЛ УЛС, ХАНГАЙН НУРУУНЫ ШАШНЫ ТАРХАЦ

(Үндэсний судалгаа, Хөгжил болон Инновацийн газар – NKFIH,
FK 138052, 2021–2025)

Телеки Кристина (PhD)

Еөтвөш Лорандын Шижлэх Ухааны Их Сургууль

Хэл шинжлэлийн факультет,

Төв Ази Монгол судлалын тэнхим, Монгол судлалын төв

Хангайн нуруу (4008 м) нь Төв Азийн бүс нутаг дахь өндөр уулсын нэг бөгөөд Монгол Улсын төв, баруун хэсэгт байрладаг. Энэхүү уул нь таван аймгийн нутагт оршдог бөгөөд тухайн бүс нутгийн нүүдэлчин ард түмэн уул овоогоо хүндэтгэн, бишрэн шүтэж холбоотой амьдарсаар ирсэн.

Төвдөөс гаралтай Буддын шашны шар малгайтны урсгал (гэлүгба) нь XVI зуунд Монголд тархсан: 1586 онд Хангайн бүс нутагт Монголын анхны хийд Эрдэнэзуу баригдаж, улмаар шарын шашныг дэлгэрүүлэгчид энд төрж олон сүм хийд байгуулсан. Буддын шашны сүм хийд, гэгээнтэн, хувилгаан, лам нарын тоо асар хурдацтай нэмэгдэж байсан ч социализмын үед 1937 онд сүм хийд сүйрсний улмаас өмнө нь Буддын шашинтай байсан тус улсад шашны үйл ажиллагаа хаалттай байдалд орсон.

1990 онд Монгол улс зах зээлийн нийгэмд шилжсэнээр шашны сэргэлт маш хүчтэй өрнөж, олон сүм дуганууд нээгдэж, шашнаа уламжлалт замаараа үргэлжлүүлэн шүтэхийг эрмэлзэж байна.

Судалгааны ажлын зорилго

Миний дөрвөн жилийн судалгааны зорилго бол Хангайн бүс нутаг дахь

Буддын шашны судалгаа (XVI-XXI зуун) юм. Монгол, Төвд бичгийн эх сурвалж, хээрийн судалгаанд үндэслэсэн өмнөх үе болон орчин цагийн сүм хийдийн түүх, шашны зан үйлийн судалгаа; тухайн нутаг дахь гэгээнтнүүд болон хувилгаадын уламжлалыг танилцуулах; Хангайн нурууны ноён оргил, уул, усны сүм хийдийн ерөөл, уншлага бичвэрүүдийн орчуулга юм. Монголчууд нутаг усныхаа лус савдгийг аргадан баясгаснаар тухайн нутгийн цаг агаар таатай байж, нүүдэлчдийн аж амьдрал, мал сүрэг өсөхөд дөхөм болдог хэмээн үздэг. Хангай нутаг бэлчээр гол усаар арвин учир хүн ам олноор суурших боломжийг олгохоос гадна даваануудын цаадах нуугдмал хөндийнүүд нь томоохон сүм хийдүүд ариун дагшин газруудыг бий болох боломжийг бүрдүүлсэн байна. Тухайн бүс нутагт нүүдэлчин хүн ам олноор амьдарч байсан тул гурван зууны турш сүм хийдийн амьдрал, шашны үйл ажиллагаа цэцэглэн хөгжиж байв.

Тухайн нутгийн лус савдгийг аргадах нь цаг агаарын таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой хэмээн үздэг байсан тул XVII зууны үеийн лам нар (голчлон гэгээнтэн, хувилгаад, сүм хийдийн хамба лам нар) Хангай нурууны зарим оргилуудад

сүсэглэн залбирч, энэ тухай олон ариун бүтээл туурвиж, ном хурах зан үйлийг нэвтрүүлсэн нь өнөөгийн сэргээн босгосон ихэнх сүм хийдүүдэд мөн мөрдөгдсөөр байна.

Судалгаанаас үзэхэд, сүм хийд болгон өөр өөрийн онцлогийг харуулсан уншлагатай байсан бөгөөд Хангай нурууны уулс тэр дундаа ноён оргилууд болон уул усанд нь сүсэглэн залбирдаг байсан.

Хангайн уулсад зориулсан ариун уншлагуудын ихэнх нь Улаанбаатар хот болон орон нутгийн архивт хадгалагдаж байгаа бөгөөд зарим хэсгийг хангай нутагт байгаа сүм хийдүүдийн лам нар уншсаар байна.

Судалгааны нэг зорилго бол хангай нутаг дахь нэгэн төрлийн “мэдээллийн урсгал” юм. Хээрийн судалгаанаас үзэхэд, бие биенээсээ алслагдсан сүм хийдүүд өмнөх үеийн уншлагуудаас бусад сүм хийдүүдийн туршлагуудын талаар илүү их мэдлэг олж авдаг байсан тул өнөөгийн сүм хийдүүдийн харилцааны хөгжил үүнээс үүдэлтэй юм.

Хангай нурууны тахилгын талаар Монголын болон Олон улсын түвшинд маш бага судлагдсан: зөвхөн хамгийн өндөр ноён оргил болох Отгонтэнгэрийн талаар хоёр судалгаа хийгдсэн (Vesna A. Wallace, University of California), мөн Хангай нутгийн савдгийн талаар судалсан нэг бүтээл туурвигдсан. (Isabelle Charleux, CRNS). Монголын судлаачдаас О.Сүхбаатар

монгол хэл дээр энэ чиглэлийн өгүүлэл хоёрыг бичсэн байна. Энэхүү судалгаа нь голчлон Монгол судлал, Төвд судлал, Буддын шашны судалгааны салбарт шинэ үзэл санааг дэвшүүлж, Төв Азийн уулсын сүсэг бишрэлийг судлахад хувь нэмрээ оруулж байна.

Судалгааны сэдэв, үе шатууд

Судалгаа нь дөрвөн чиглэлээр Хангайн нурууны өндөр уулсын Буддын соёлын бүс нутгийн тодорхой сэдвүүд дээр үндэслэгдсэн болно:

1. Хангайн бүсийн хуучны болон өнөөгийн сүм хийдүүд: тэдний түүх, үйл ажиллагаа, шашны амьдрал
2. Хангай нутгийн алдартай лам нар, гэгээнтнүүд, дахин төрөлтийн хэлхээ,
3. Хангай хан, Хангайн эзэн савдгийг аргадах уншлага
4. Хангайн нурууны ноён оргилууд гол, ус, нууруудын ариун уншлага

Судалгаа Еөтвөш Лорандын Шинжлэх Ухааны Их Сургуулийн Төв Ази Монгол судлалын тэнхимд хийгдэж байгаа бөгөөд Монгол улс дахь судалгааны ажлын хүрээнд Улаанбаатар хотын номын сан, архивуудын боломжит эх сурвалжууд дээр судалгаа хийж улмаар Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Хөвсгөл зэрэг таван аймагт хээрийн судалгаа хийсэн болно.

ТӨВ АЗИАС КАРПАТЫН САВ ГАЗАР ХҮРТЭЛ КУНСАЛЛАШ-ФҮЛӨПЯКОБИЙН АВАРЫН ҮЕИЙН ЯЗГУУРТНЫ БУЛШ

М.Лежак Габриэлла

Хүннүчүүд, аварууд болон өнөөгийн нутагтаа суурьшсан унгарчуудын генетикийн судалгаагаар Карпатын сав газар дахь тал нутгаас гаралтай угсаатны бүлгүүд нь ижил төстэй давхардсан популяциас бүрддэг болох нь генетикийн судалгаагаар нотлогдсон.³ Аварын Хаант улсын язгууртны давхаргын генетикийн судалгааны үр дүнгүүд нь тэд эртний Хятадын сурвалжуудад тэмдэглэгдсэн Жужан (мандарин хэлний дуудлагаар роуран) улсаас гаралтай⁴ харуулдаг. Эцэг талын ген нь өнөөгийн Монгол улсын нутагт амьдарч байсан Азийн хүннүчүүдтэй холбоотойг ч баталдаг.⁵ Эцэг талын энэхүү ген нь Карпатын сав газрын хүннүчүүд болон Унгарын язгууртнууд мөн өнөөгийн буриад, монголчуудын генд их хэмжээгээр агуулагддаг.⁶

Жужаны Хаант улс НТ IV-VI зууны дунд үе хүртэл өнөөгийн

Монгол Улсын нутаг дэвсгэрт оршиж байсан. НТ 552 онд болсон Түрэгийн бослого нь Төв Азийн Аварын Хаант улсыг мөхөөсөн бөгөөд тэдний удирдагч давхаргын язгууртнууд Хүннүгийн Хэфталит улс руу дүрвэсэн. 557-558 оны үед аварууд Византийн Эзэнт гүрний хилд дөхөж очоод Кавказын умард⁷ хэсгээр нутагласан. Аварууд 567 оны үед Карпатын сав газрыг эрхшээлдээ оруулсан. Өнөөгийн Монгол улсын нутгаас гаралтай байх нотолгоог Дунай болон Тиса голын хооронд орших Аварын үеийн язгууртнуудын ДНХ-ийн судалгаа баталсан.⁸ Генетикийн судалгааны 20-30 хувьд нь аварууд нүүдлийнхээ замд холилдсон Умард Кавказын ард түмнүүд болон Азийн баруун хэсгийн ард түмний ул мөр генийг хадгалсаныг тодорхойлсон (Зураг 1).⁹

¹ Булишийг 1967-1979 оны хооронд Х.Тот Элвира (1929–2015) археологич малтсан, малтлагаас гарсан олдворуудыг М.Лежак Габриэлла судалсан.

² М.Лежак Габриэлла, PhD, археологич, Эрдэм шинжилгээний ажилтан, HUN-REN Хүмүүнлэгийн Шинжлэх Ухааны Судалгааны төв, Унгарын эртний түүх судлалын алба (Будапешт). Email: lezsak.gabriella@abtk.hu

³ Непарацки et al. 2019.


⁴ Энэ тухай Визант болон Хятадын эх сурвалжууд дээр үндэслэн анх 1757 онд бичсэн. Вида 2021, 75.

⁶ Непарацки et al. 2019; Maroti et al. 2022.

⁷ Садески-Кардосс 1998, 14–15.

⁸ Чаки et al. 2023; Гнеччи-Русконе et al. 2024.

⁹ Непарацки et al. 2019; Чаки et al. 2020; Чаки et al. 2023; Гнеччи-Русконе et al. 2024.



Зураг 1. Кунсаллашийн генетикийн судалгаа

Эцгийн болон эхийн удмынх нь хаплогруппууд дийлэнхдээ Төв Азиас гаралтай байгаа тул тэд Европт ирэхдээ зөвхөн цэргүүдээс бүрдээгүй харин гэр бүлээ мөн авчирсан байх магадлалтай юм.¹⁰

Карпатын сав газрын Аварын үеийн хүн ам нь холимог олон янз байсан бөгөөд удирдагч язгууртны давхарга нь монголоид зүстэй байсныг антропологийн судалгаагаар тогтоосон байдаг.¹¹ Язгууртнуудын бие даасан булшууд нь голчлон Дунай-Тиса голын хойд болон дунд хэсгээс олдсон. Өнөө хүртэл


хамгийн баялаг олдвортой булшийг 1971-онд¹² Кунбабон (Бач-Кишкун вар аймгийн, Кунсентмиклош сум)-ий ойролцоогоос илрүүлсэн. Хааны гэр бүл Дунай, Тиса голын хооронд оршин суудаг байсан байх магадлалтай юм. Бүхэлд нь хийсэн геномын дүн шинжилгээгээр тухайн бүс нутагт байх Аварын үеийн язгууртнуудын бусад булшны нэгэн адил Кунсаллаш-Фүлөпякобийн (Кечкемет тосгон, Бач Кишкун вар аймаг) булш нь Кунбабонид оршуулсан хааныхтай нэг удам угсаатай болохыг харуулж байна (Зураг 2).¹³

¹⁰ Vida 2021, 85.

¹¹ Bartucz 1935, 107.

¹² H. Tóth 1992.

¹³ Gneccchi-Rusccone et al. 2024. *Internetes hozzáférés: <https://www.nature.com/articles/s41586-024-07312-4>*



Зураг 2. Кунбабоний хэсэг

Түүнчлэн язгууртнууд нь тодорхой хүрээнд гол төлөв хоорондоо гэрлэж, уугуул нутгийн хүн амтай бага хэмжээгээр холилдсон байдаг нь судалгаагаар тогтоогджээ.¹⁴ Генетикийн шинжилгээгээр Аварын нийгмийн бүтцэд язгууртнуудын том гэр бүлүүд, овог, аймгийн зохион байгуулалттай байсан байх магадлалтай хэмээн бид бичмэл эх сурвалж, антропологи, археологийн судалгаанд үндэслэн дүгнэж байна.

Энд судлагдсан Кунсаллаш-Фүлөпякобийн оршуулгын газарт оршуулсан бүх эрчүүд нь эцгийн талаараа Кунбабонийн хааны удмынхтай ижил гаплогрупп (N1a1)-т харьяалагддагаараа онцгой

ач холбогдолтой юм.¹⁵ Бүхэлд нь хийсэн геномын шинжилгээгээр энэхүү булшнууд нь Кунбабонийн хааны булштай илүү ойрхон хамааралтай болохыг нотолсон. 35-р булшинд буй олдвор хааны охиных байсан, 37-р булшинд оршуулсан эрэгтэй хүн нь хааны 4 дэх үеийн ач хүү бол 8-р булшнаас олдсон эмэгтэй нь хааны 9 дэх үеийн садан төрөл байсан.¹⁶

Олон зуун жилийн өмнө ихэнх хэсгийг нь тонуулчид тоносон ч гэсэн эдгээр булшнуудаас тухайн үеийн аваруудын эрхэлж байсан аж ахуй амьдралын талаар бид ихийг мэдэх боломжтой.

¹⁴ Vida 2021, 85; Gnechi-Ruscone et al. 2024.

¹⁵ Csáky et al. 2020; Vida 2021, 84. A kunbábonyi kagánra vonatkozó genetikai adatokat ld.: Gnechi-Ruscone et al. 2022. [https://www.cell.com/cell/fulltext/S0092-8674\(22\)00267-7](https://www.cell.com/cell/fulltext/S0092-8674(22)00267-7)

¹⁶ Тодорхойлолт өгсөн Төрөк Тиборт талархал илэрхийлье.

Булшнаас гарсан материаллаг зүйлсийн соёл, оршуулгын зан заншил, удамшлын мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ нь нэгэн цагт одоогийн Хомокхатшагийн хойд хэсэгт (3-р зураг) амьдарч байсан том гэр бүлийн гарал үүсэл, тэдгээрийн хоорондын хамаарал,


Карпатын сав газар болон дорно зүгийн харилцааны талаарх судалгааг тодорхой тусгасан болно. Төв Ази дахь уугуул нутагтайгаа холбоотойг нь харуулсан археологийн ул мөрийг оршуулгын зан үйлд голчлон үлдээсэн байдаг.



Зураг 3. Өнөөгийн Кунсаллаш

Оршуулгын газрын баруун чиглэсэн байрлалтай 61 булнаас хойд талаас зүүн урагш (Зураг 4: 14 эрэгтэй, 27 эмэгтэй, 22 хүүхдийн оршуулгын газрын зургийг үзэх) булш олдсон.¹⁷

¹⁷ А 61 дугаартай булнаас нийт 63 шарил олдсон. 5-р булинд залуухан бүсгүйг нялх хүүхдийнх нь хамт оршуулсан байдаг бол том, эвдэрсэн 20-р булинд хоёр залуугийн шарил байсан нь генетикийн шинжилгээгээр тогтоогджээ.



Зураг 4. Кунсаллашийн бушины газрын зураг

Эдгээр булшнуудаас гарсан харьцангуй баялаг олдворуудаас гадна тухайн газрын зураг, генетикийн болон C14 изотопын шинжилгээ нь оршуулгын газрын харьцангуй ба үнэмлэхүй он цагийн дарааллыг тодорхойлоход дөхөм болсон.

Бүхэлдээ хийгдсэн геномын судалгаанаас харахад 150-200 жилийн хугацаанд цусан төрлийн холбоотой нэгэн том гэр бүлийн гишүүдийг зургаан үеийн турш тухайн оршуулгын газарт оршуулсан байдаг.¹⁸

Монголын хамгийн эртний түүхэн сурвалж болох “Монголын нууц товчоо”-нд (XII зуун) өгүүлснээр эцгийн голомтыг хамгийн отгон хүү сахидаг (монголоор: отчигин). Тэрээр эцэг эхээ асарч гал голомтоо өвлөн авч явдаг байсан.¹⁹ Оршуулгын газарт

хийсэн генетикийн шинжилгээгээр бэлэвсэрсэн эмэгтэй нас барсан нөхрийнхөө дүүтэй гэрлэсэн левират гэрлэлтийн хоёр тохиолдолд байсныг баталсан.²⁰ Элит том гэр бүлүүдийн харилцаа нь экзогам гэрлэлтийн зан үйл, нийтлэг удам угсааны талаарх ойлголтоор тодорхойлогддог бөгөөд эдгээрийн нэгдэл нь фратриал экзогам овгийн бүлгийг бий болгосон байдаг. Монголчууд ийм ураг төрлийн холбоог худ (хүргэн ах) хэмээн нэрлэдэг.²¹ Аварын үеийн Карпатын сав газрын овог, аймгийн суурингийн тогтолцоог Византийн орчин үеийн эх сурвалжууд ч баталж байна.

Византийн Эзэн хаан Маурикиос (582-602) “Стратегикон” хэмээх Цэргийн гарын авлагатаа “Аварууд дайтах өдөр хүртлээ овог, аймгаараа

¹⁸ *Ld. Gneccchi-Ruscione 2024, Fig.1.*

¹⁹ *Obrusánszky 2005, 19.*

²⁰ *Gneccchi-Ruscione 2024, Fig.1.*


²¹ *Rácz 2013, 16.*

таран амьдардаг” хэмээн бичсэн.²²

Кунссаллаш-Фүлөпякабийн оршуулгын газрын анхны булшууд (30, 32-р булш: хамгийн эртний булш)-ыг тухайн газрын дунд хэсэгт байршуулсан цагаас хойш хойд болон өмнөд хэсэг рүү үргэлжлүүлэн оршуулсан байдаг.

Хамгийн сүүлийн үеийн булшнууд оршуулгын газрын зүүн өмнөд хэсэгт байрлалтай байсан.

Харьцангуй хамгийн баялаг оршуулга болох 32-р булшин дахь шарил нь Матурус-сениумын үед нас барсан эрэгтэй хүний шарил бөгөөд булшнуудын төв хэсэгт байрласан байв. Булшнаас цилиндр хэлбэртэй алтан ээмэг, алтадмал мөнгөн таваг дээр сийлсэн хос шаантаг хэлбэртэй сүлжсэн хавчаар, алтадмал мөнгөн таваг, мөнгөн таваг дээр дарж сүлжсэн болон бүсний гоёл чимэглэл, зэр зэвсэг (сэлэм, нум, сумны хошуу) олдсон (5-р зураг).





Зураг 5. Кунсаллаш 32-р булш

²² Szádeczky-Kardoss 1998, 83.

Судалгаагаар эдгээр төрлийн олдворуудыг агуулсан булшнуудыг VII зууны дунд үеэс сүүл үед хамааралтайг тогтоосон.²³

Шарил дахь үнэт эдлэлийн олдворын байршлыг үндэслэн (үс сүлжих хавчаар, ээмэг) урт үсээ хоёр сүлжсэн, зөвхөн зүүн

чихэндээ ээмэг зүүсэн хүнийх болохыг тодорхойлсон.²⁴ Түүнийг оршуулахдаа зориудаар нумыг нь хоёр хувааж хугалсан байх магадлалтай бөгөөд ясан ялтсууд нь түүний гавлын ясны баруун талд багцалсан байдалтайг илрүүлжээ (6-р зураг).



Зураг 6. Кунсаллаш 32-р булш

²³ Garam 1991, 155.

²⁴ *Id.* Gneccchi-Ruscone 2024, Fig.1.

Ийм зан үйлийг Хүннүгийн үеийн булшнаас ч олж болох бөгөөд Аварын үеийн хэд хэдэн булшинд мөн хадгалагдан үлдсэнийг харж болно.²⁵ Хувцасныхаа ханцуйг алтан утсаар чимэглэсэн нь Аварын үеийн бусад язгууртны булш дахь зан үйлтэй адил төстэй байв.²⁶

Судалгаанаас харахад, алтан хувцас өмсөх заншил нь Хүннүгийн үеэс эхтэй бөгөөд “Хүннүгийн залгамжлагч улсууд” (авар, монгол)-д болон Монголын үеийг дуустал байсан.

Ласло Дьюлагийн үзэж буйгаар, Монголын хаадын ордонд хааны ойр дотны язгууртнууд, холбоотнууд болон дагаар орсон овог аймгийн удирдагчид ийм хувцас өмсдөг байсан байна.²⁷ 32-р булшинд буй эрэгтэй (7-р зураг)-н эцэг эх нь тухайн газрыг эзэмшилдээ аваад энэхүү оршуулгын газрыг бий болгосон байх магадлалтай юм.



Зураг 7. 32-р булшнаас гарсан хүний
ясыг компьютерийн аргаар сэргээсэн нь

Тухайн оршуулгын газар зөвхөн эцгийн талынхныг оршуулсан байдгаас гадна тэдний гэр бүлийн гишүүд (хүүхэд эмэгтэйчүүд)-ийг мөн оршуулсан байдаг.²⁸ Оршуулгын газрыг анх бий болгосон эрэгтэйн шарил олдоогүй бөгөөд тэрээр ямар нэгэн аян дайны явцад амь үрэгдсэн байх магадлалтай. Эсвэл Дунай-Тиса голын дунд ганц нэгээр нь оршуулсан удирдагч, овог аймгийн толгойлогчдын булшны нэг нь байж болох юм.

Малтлагын үеэр урт наслан жамаараа нас барсан эхнэрийнх нь шарил (30-р булш) болон 32-р булшинд оршуулсан эрэгтэй хүний эхийнх нь шарилыг генетикийн шинжилгээгээр тогтоосон байна.²⁹ Түүний хамгийн ойрын хамаатан саданг 32-р булшны ойролцоо оршуулсан байсныг генетикийн шинжилгээгээр тогтоосон байна. Эхийнх нь шарилыг агуулж буй 30-р булшнаас гадна 24-р булшинд түүний ач хөвгүүдийн нэгнийх нь шарил байсан. Мөн 10-11 насандаа хорвоог орхисон эрэгтэй хүүхдийн шарилаас алтаар бүрсэн арслангийн хээтэй бүсний чимэглэл гарсан нь тухайн гэр бүлийн нийгэмд ямар байр суурь эзэлж байсныг илтгэнэ (зураг 8).

²⁵ М. Лежак 2009, 145–164; М. Лежак 2017, 399–411; Лежак 2020, 15–27.

²⁶ László 1955, 10, 43, 61..

²⁷ László 1955, 61.

²⁸ Ld. Gneccchi-Rusccone 2024.

²⁹ 32-р булшны эрэгтэй энэхүү газрыг байгуулсан байх магадлалтай юм.



Зураг 8. Кунсаллашийн
24-р булинаас гарсан
бусний арал

Энэхүү 32-р эрэгтэй хүний булшны хажууханд (38-р булш) түүнээс холгүйхэн (36, 40-р булш) харьцангуй залуугаараа нас барсан (35, 36, 38, 40-р булш) эмэгтэйчүүдийн булш нь дээрх булшнуудтай хамааралтай байх магадлалтай юм.

Алт (38, 40-р булш), алтаар бүрсэн мөнгөн (36-р булш) ээмэг нь эндээс олдсон зоосон мөнгөтэй нэг цаг үед буюу VII зууны дунд болон сүүл үед Карпатын сав газарт чамин хэрэглээнд тооцогдож байжээ (9-р зураг).³⁰



Зураг 9. Кунсаллашийн булинаас гарсан чихний ээмэг


³⁰ Garam 1993, 78, 80, 90, 96.

Генетикийн шинжилгээгээр, 35-р булшинд оршуулсан Кунбабонийн хааны охины булшийг тонуулчид бүрэн тонож, дагалдах эд зүйлс юу ч үлдээгээгүй байна. Энэ хэсэг булшны хойд болон өмнөд хэсэгт 32-р булш буюу эрэгтэй булшны арай холын хамаатан садныг нь оршуулсан байна. Тэдгээрийн дотроос тоногдсон 37-р эрэгтэй хүний булшнаас олдсон төмөр сэлэм, нум бүхий олдворууд нь талийгаачийн нийгэмд эзлэх байр суурийг илэрхийлж байна. Мөн 12, 16-р булшин дахь (оршуулгын газрын 4, 5-р үед хамаарах) хүрэл ялтсаар хийсэн дөрвөн гартай бүсний чимэглэл, 32-р булшнаас гарсан өмнөхтэй төстэй хийцийн алтан таваг, туузан эдлэлүүд нь алтны дархны хийц, хээ угалзтай холбоотой уламжлал нь тухайн гэр бүлээс уламжлагдан ирсэн болохыг харуулж байна. Тухайн булшны 4, 5-р үеийнхний хэрэглэж байсан

өвөрмөц олдворууд болох ээмэг, жижиг ирмэгтэй унжлагатай ээмэг, эргүүлэгтэй, зүүний сав зэрэг нь Аварын дунд үеийнх бөгөөд судалгаагаар VII зууны сүүлийн сүүл үед хамаарахыг тогтоосон. Цутгаж хийсэн бүсний чимэглэлүүдийг агуулсан булш (4, 5-р үеийн) нь зөвхөн оршуулгын газрын зүүн болон зүүн өмнөд хэсгээс олдсон. Өмнөх үеийнхний нэгэн адил өрхийн тэргүүнүүдийг үргэлж гэр бүлийн булшны дунд оршуулдаг байв.

Гэр бүлийн 4 булшны бүлгээс 4-өөс нь хүрлээр цутгаж хийсэн бүсний чимэглэл олдсон, 6-р булшнаас гадна өөр 3 булшнаас (20, 52, 59-р булш) алтадсан чимэглэл олдсон.

Судалгаанаас харахад, хангарьд болон хээ угалзаар чимэглэсэн ийм төрлийн бүсийг VIII зууны үед Карпатын сав газарт ашиглаж байжээ (10-р зураг).³¹



Зураг 10. Кунсаллашийн булшнаас гарсан бүсний чимэглэл

³¹ Zábajnik 1991, 219–321.

Тэдний хамаатан садны эдэлж байсан эд зүйлсэд хүрэл утсыг нугалан, хүрлээр цутгасан сувдан унжлагатай ээмэг, шилээр чимсэн, сувдан наалт, алтадмал хүрэл тамга, хүрэл ялтсаар хийсэн энгэрийн зүү, товч, гуурсан ясаар өнгөлж сийлсэн, зүүлт байсан (11-р зураг). Цутгаж хийсэн чихний ээмгийг ихэнх тохиолдолд алтаар

бүрж чимэглэдэг байсан. Өнөө үеийн судлаачдын тайлбарлаж буйгаар эдгээр зүйлс нь VIII зууны сүүл Аварын үед чамин хэрэглээ болж байжээ. Оршуулгын газрын зүүн өмнөд захаас VIII зууны төгсгөлд хамаарах хамгийн залуу гэр бүлийн булш олдсон (6 дахь үеийн 59-р булш).



Зураг 11. Кунсаллашийн булинаас гарсан эмэгтэй хувцас хэрэглэл

Оршуулгын газрыг ашиглаж байсан энэхүү том гэр бүл анхнаасаа өвөг дээдсийнхээ³² Төв Ази дахь нутгаасаа уламжилсан оршуулгын зан үйл буюу дорнын нүүдэлчдийн уламжлалыг хадгалсаар ирсэн байна.

Нас барагсдын умард болон зүүн урагш чиглүүсэн тавьсан байдал, мод болон дүнзээр хийсэн авсыг ашиглах явдал тухайн оршуулгын газар жигд тархсан байдаг бөгөөд зөвхөн цөөн тохиолдолд шарилын байрлалаас хамааран цогцсыг даавуунд ороосон

байсан гэж үзэж болно.


51-р эмэгтэй булшнаас археологичид чихэн бариултай булшийг илрүүлж баримтжуулсан ба дөрвөлжин авснаас гадна хоёр үзүүрт нь гадас шиг цухуйсан өөр нэг том тэгш өнцөгт модон байгууламжийн ул мөрийг олжээ. Малтлагын явцад чихний өндөр нь 197-200 см-ийн хооронд хэлбэлзэж байв.³³ Нотлох баримтад үндэслэн насанд хүрсэн хойноо нас барсан эмэгтэйг “давхар” авсанд оршуулсан гэж таамаглаж байгаа бөгөөд оршуулах

³² 28-р зүүлтийг харах!

³³ Булшны гүн нь 187-200 см байсан.

явцдаа авсыг гадна оршуулах давхар тасалгааг мөн барьсан гэсэн үг юм.³⁴ Үүнтэй төстэй булшны жишээ бол НТӨ I-НТ I зуунд хамаарах Тамир (Монгол Улсад байдаг)-ын Хүннүгийн язгууртны оршуулгын газрын хэд хэдэн булшнаас олдсон байдаг (12-р зураг).³⁵ Гаднах тасалгаа, авсны

модон дүнз, банзыг мөн тээглүүрээр бэхэлсэн байв.³⁶ Бичгийн эх сурвалж, археологийн судалгаануудаас харахад, Азийн хүннүчүүдийн язгууртан давхаргын дунд давхар австай оршуулга түгээмэл байсан ч³⁷ язгууртны оршуулгын хувьд гурван давхар австай байсан жишээ ч бас бий. (Тухайлбал, Ноён Уулын булш).³⁸



Зураг 12. Кунсаллашийн булинаас гарсан ясны үлдэгдэл

³⁴ Харин авсны хадаас, үдээс олдоогүй тул авсны хавтангуудыг бэхлэгээгээр бэхэлсэн байна.

³⁵ Жишээлбэл, 35, 41-р булш (Төрбат-Крюбезы 2021, 91, 93).

³⁶ Жишээлбэл, 35-р булш. (Төрбат-Крюбезы 2021, 91).

³⁷ Сыма Цянь (МЭӨ 145 оны үеэс МЭӨ 86 он) “Хятадын түүхэн сурвалжийн эцэг зохиолч” гэгддэг тэрээр Хүннүгийн үед амьдарч Хүннүгийн давхар авсны зан үйлийн талаар тэмдэглэсэн. (Watson 1993, 137.; Horváth 2022, 222). D.Erdenebaatar (Erdenebaatar 2016, 32–33). Horváth 2022, 193–248.

³⁸ Руденко 1962, 14; 11, 12, 16, 17, 18. зураг.

Кунссаллаш-Фүлопякобийн оршуулгаас мал амьтны яс (голдуу хонины ууц, шувууны махыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн) хоол хүнсийг дагалдуулан тавган дээр тавьсан байдаг нь түгээмэл юм.

Оршуулганд өөр амьтад (хонины ууц, үхрийн толгой, толгойгүй шувууны яс)-аар тахилга үйлдэж,

хамт оршуулсан ул мөр үлдсэн байдаг.


Тахилын зан үйлийн зорилгоор өндөгний хальсыг хамт оршуулах явдал эртний болон хожуу үеийн булшнаас гарсан. 25-р булшинд оршуулсан эрэгтэй хүүхдийн биеийн дээд хэсэгт өндөг тойруулан дугуй хэлбэртэй байрлуулсан байсан (13-р зураг).



Зураг 13. Кунссаллашийн булинаас гарсан сав суулга

Сав суулга дагалдуулан оршуулахтай холбоотойгоор ялгаатай байдал ажиглагддаг: хожуу үеийн бараг бүх булшнаас сав суулга гарсан бол эртний булшнаас сав суулга олдож байсан удаагүй. Савнууд дотроос хавтгай хэлбэртэй, шаравтар улаавтар шаазан болон гараар урлан хийсэн шавар ваарнууд олдсон бөгөөд зөвхөн оршуулганд зориулж хийсэн гэж таамаглаж байна (14-р зураг). Зах дээр

хямдхан бараанд тооцогддог байсан сувд нь хамгийн эртний, хамгийн баялаг олдвортой (32, 36, 38, 40-р) булшны төв хэсгээс огт олдоогүй ч баруун, зүүн жигүүрт байрлах булшнуудад олноороо агуулагдсан байна. Харин бүх булшнаас олдсон олдворуудаас харахад, хутгаа зүүн гар талдаа зүүдэг байсан бөгөөд ажлын багаж (тээрэмний гол, зүүний сав)-аа мөн адилхан тэр талдаа зүүдэг байсан байна.



Зураг 14. Кунсаллаш болон Тамирын булш

Оршуулгын газартай хамаарал бүхий суурин газар нь Сегед хот орох замд Сентеш-Кечкемет-Пешт чиглэлийн худалдааны болон цэргийн замуудын дагуу байрласан³⁹ байдаг. Малтлагаас гарсан олдворуудаас үзэхэд, тэр хавьд амьдарч байсан хүмүүс тухайн барааг зах зээлээс олж аван хэрэгцээндээ ашигладаг байсан байна. Кунбабоний хааны булш нь хойд зүгт 70 орчим км-ийн зайд байдаг нь тус газрын ач холбогдлыг илтгэж байгаа бөгөөд энэ газрыг мөн хаадын оршуулгаар хүрээлэгдсэн гэж үздэг (Жишээлбэл: Боча, Кецел, Петкфисаллаш, Кечкемет-Шаллай гудамж, Баллогсөг, Олпар, Нодькөрөш, Кишкөрөш-Вагохийд).

Эдгээр язгууртны булшнуудын Кунсаллаш-Фөлөпякобын 32-р булшийг цугт нь авч үзэх боломжтой бөгөөд энд оршуулсан хүмүүсийн язгууртны дэв зэргийг тэндээс олдсон хувцасны алтадсан гоёл чимэглэлээр тодорхойлдог. Энд оршуулсан хүмүүсийн амьдралд VIII зууны сүүлээр

өөрчлөлт гарсан бөгөөд тэд амьдарч байсан газраасаа өөр нутаг руу нүүсэн бололтой.⁴⁰

Зургийн зүүлт

1-р зураг: Кунсаллаш-Фөлөпякобийн Аварын үеийн булш дахь эцгийн (ягаанаар тэмдэглэсэн) болон эхийн (олон өнгөөр тэмдэглэсэн) гаплогруппууд нь генетикийн дүн шинжилгээнд үндэслэсэн (Гнеччи-Рускони 2024, 4. болон 8.).

2-р зураг: Судалгаанд хамрагдсан Аварын элит язгууртны оршуулгын газрууд. Улаан өнгийн тойрог зураас: Кунбабоний груп (VII зуун), хар өнгийн тойрог зураас: Тисагийн чанад дахь 2-р давхаргын ноёлох ангийн төвүүд (VII-VIII зуун).

3-р зураг: Кунсаллаш-Фөлөпякобийн Аварын үеийн булш болон ойр хавийнх нь өнөөгийн зураг (Фото зураг: Мойш Золтан).

³⁹ Ласло 1944, 93.

⁴⁰ László 1944, 69, 95–101.

4-р зураг: Булшны газрын зураг.

5-р зураг: 32-р булшны олдворууд.

6-р зураг: 32 дугаартай эрэгтэй хүний булшны зураг болон малтлагын явцад авсан фото зураг.

7-р зураг: 32 дугаартай эрэгтэй хүний булшны дижитал зураг (3D) формат дээр тулгуурлан бэлтгэсэн гавлын яс болон генетикийн нүүрний нөхөн сэргээлт

(Бэлтгэсэн: Киш Лука, Сегеди Шинжлэх Ухааны Их Сургууль, Антропологийн тэнхим).

8-р зураг: Кунсаллаш-Фүлөпякобийн оршуулгын 24-р булшны алтадсан ялтсаар хийсэн бүсний чимэглэл.

9-р зураг: Оршуулгын газраас олдсон ээмэгнүүдийн он дараалал.

10-р зураг: Оршуулгын газраас олдсон бүсний чимэглэлийн он дараалал.

11-р зураг: Эмэгтэй булшнаас олдсон эд зүйлс: гар тээрмийн бутлагч чулуу, зүүний сав, хутганууд, бүсний аралнууд болон 58 дугаар эмэгтэй булшнаас олдсон эмэгтэй хүний хүзүүний пайз, 4-р эмэгтэй булшнаас гарсан гогцоо.

12-р зураг. Оршуулгын газарын 51-р эмэгтэй булшнаас олдсон Төв Азийн Хүннүгийн үеийн (НТӨ I-НТ I зуун) Тамирын хөндийн булш (Монгол Улс) (Төрбат-Крюбезы 2021, 82, 219.).

13-р зураг. 18-р эрэгтэй хүүхдийн булш болон 25-р эрэгтэй хүүхдийн булш өндгөөр тойруулж оршуулсан.

14-р зураг: Булшнаас олдсон сав суулганы төрлүүд.

Irodalom

Bartucz 1935 – Bartucz L. A magyarországi avarok faji összetétele és ethnikai jelentősége. *Ethnographia* 45 (1935), 101–110.

Csáky et al. 2020 – Csáky V. et al. Genetic insights into the social organisation of the Avar period elite in the 7th century AD Carpathian Basin. *Scientific Reports* 10 (2020).

Csáky et al. 2023 – Csáky V. et al. Az avar kori elit eredetének és rokoni szerveződésének archeogenetikai vizsgálata. In: Hadak útján. A népvándorlaskor kutatóinak XXIX. konferenciája. Budapest, 2019. november 15–16. / 29th Conference of scholars on the Migration Period. November 15–16, 2019, Budapest, *MÖK Kiadványok* 4/2. (2023) 59–78.

Erdenebaatar 2016 – Erdenebaatar, D. The culture of the Xiongnu Empire, Ulanbator.

Garam 1991 – Garam É. A Tiszakécske-óbögi avar kori sírok. Adatok az avar kori szabalyákhöz és az egyenes élű kardokhoz. *Awarenzeitliche Gräber von Tiszakécske-Óbög. Angaben zu den Säbeln und zu den geraden einschneidigen Schwerten der Awarenzeit.* *ComArchHung* 1991. 129–166.

Garam 1993 – Garam É. Katalog der awarenzeitlichen Golgegenstände und der Fundstücke aus den Fürstengräbern im Ungarischen Nationalmuseum. *CatMusNatHun. Seria Arch* 1 Budapest 1993.

Gnecchi-Ruscione et al. 2022 – Gnecchi-Ruscione, G. A. et al. Ancient genomes reveal origin and rapid trans-Eurasian

migration of 7th century Avar elites. In: Cell 185 (2022), 1402–1413.

Gnecchi-Ruscione et al. 2024 – Gnecchi-Ruscione, G. A. et al. Network of large pedigrees reveals social practices of Avar communities. In: Nature 629 (2024), 376–383.

Guignes 1757 – Guignes, J. de. Histoire generale des Huns, des Mongoles, des Turcs et des autres Tartares occidentaux. 3 vols. Paris: Desaint & Saillant.

H. Tóth 1992 – H. Tóth E. – Horváth A. Kunbáony. Das Grab eines Awarenkhagans. Kecskemét.

Horváth 2022 – Horváth I. Attila temetésének mondája az ősi ázsiai elit és fejedelmi temetkezési szokások tükrében. // Mítosz és történelem II. Tanulmányok Hoppál Mihály 80. születésnapjára. Első kötet. Szerk.: Hoppál B.–Szabados Gy. Európai Folklor Intézet – Magyar Vallástudományi Társaság. Bp., (2022), 193–248.

László 1944 – László Gy. A honfoglaló magyar nép élete. Magyar Élet Kiadása, Budapest.

László 1955 – László Gy. Études archéologiques sur l'histoire de la société des avars. ArchHung 34 (1955)

M. Lezsák 2009 – M. Lezsák G. A kunszállási avarok temetkezési szokásai. In: „In terra quondam Avarorum...”. Ünnepi tanulmányok H. Tóth Elvira 80. születésnapjára. Archaeologica Cumanica 2. Szerk.: Somogyvári Á. – Székely Gy. Kecskemét, 2009, 145–164.

M. Lezsák 2017 – M. Lezsák G. Törött és rongált íjak a népvándorlás kori és a 10–11. századi Kárpát-medencei leletanyagban. In: Hadak útján XXIV.

Budapest – Esztergom 2017, 399–411.

Лежак 2020 – Лежак, Г.М. О намеренно поврежденных луках из погребений Карпатского бассейна VI–XI вв. In: Первый Молдо–Венгеский археологический круглый стол, посвященный вопросам раннего средневековья Восточной Европы. Eds.:Türk Attila; Budai D. Adorján; Dergačev Liliã V.; Sinika Vitalij S.; Rabinović Roman A., Кишинёв, 10–11 июня 2015. Studia ad Archaeologiam Pazmaniensia; Magyar Őstörténeti Kutatócsoport Kiadványok, 18 (18; 1). Pázmány Péter Katolikus Egyetem (PPKE); Martin Opitz Kiadó; Bölcsészettudományi Kutatóközpont, Magyar Őstörténeti Kutatócsoport, Budapest, (2020), 15–27.

Maróti et al. 2022 – Maróti Z. et al. The genetic origin of Huns, Avars, and conquering Hungarians. In: Current Biology 32, July 11 (2020), 2858–2870.

Neparáczki et al. 2019 – Neparáczki E. et al. Y-chromosome haplogroups from Hun, Avar and conquering Hungarian period nomadic people of the carpathian Basin. In: Nature, 2019.

Obrusánszky 2005 – Obrusánszky B. A mongol népek története. Farkas Lőrinc Imre Könyvkiadó, Budapest.

Rácz 2013 – Rácz A. A mongol társadalom és állam alapjai a XIII. században. In: Dunakavics 2013/3, 11–30.

Руденко 1962 – Руденко, С.И. Культура хуннов и ноинулинские курганы. Москва–Ленинград, 1962.

Szádeczky-Kardoss 1998 – Szádeczky-Kardoss S. Az avar történelem forrásai. Magyar Őstörténeti Könyvtár, Balassi Kiadó, Budapest.

Vida 2021 – Vida T. Az avar kori népesség keleti összetevői a régészeti és a genetikai források fényében. In: Magyar Tudomány, 182 (2021) S1, 75–89.

Төрбат-Крюбезы 2021 – Төрбат, Ц.-Крюбезы, Э. (Ред.). Тамирын Улаан Хошууны Хүннүгийн соёл, Улаанбаатар.

Watson 1993 – Watson, B. Records of the Historian: Han Dynasty II, by

Sima Qian. Revised edition. New York, Columbia University Press, Hong Kong.

Zábojník 1991 – Zábojník, J. Seriation von Gürtelbeschlaggarnituren aus dem Gebiet der Slowakei und Österreichs. (Beitrag zur Chronologie der Zeit des Awarischen Kaganats). In: Jozef Zábojník (ed.): – Problematike stredodunajskej oblasti vo včasnóm stredoveku, Nitra, 219–321.

ЯМААН УСНЫ ХҮННҮГИЙН ЯЗГУУРТНЫ БУЛШНЫ СУДАЛГАА

Доржпүрэвийн Хатанбаатар, Жигжиджавын Мөнхдэлгэр, Сахьяагийн Болормаа, Оюунчимэгийн Болормаа

Ямаан усны дурсгалт газрыг 2021 онд нээн илрүүлж, 3 дахь жилдээ малтлага судалгааны ажил хийгдэж байна. Тус судалгааг Завхан аймгийн Тамгын газар, Огторгуйн цагаан гарьд сангаас санхүүжүүлэн явуулж байгаа ба зөвхөн археологийн малтлага судалгааг дэмжээд зогсохгүй ном бүтээл хэвлүүлэх, үзэсгэлэн хурал семинар зохион явуулах болон соёлын бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр өргөжүүлэх боломжуудыг үүсгэн ажиллаж байгаа билээ. Энэ хугацаанд

дэмжигч байгууллагуудаас 3 удаагийн малтлага судалгаа¹, 3 удаагийн тусгай үзэсгэлэн, 1 хамтын бүтээлийг² ивээн тэтгэж ажилласнаас гадна Ямаан усны 61-р булшны малтлагаас сэдэвлэсэн “Асарын өндөр” хэмээх түүхэн жүжгийг найруулан тайзнаа тавьжээ. Ямаан усны судалгааны хувьд 2022 оны судалгааны тайланг бүрэн эхээр нь хэвлүүлснээс гадна хээрийн судалгааны тайлан 4, эрдэм шинжилгээний өгүүлэл 10 гаруйг³ дотоод, гадаадын бүтээлүүдэд нийтлээд байна.

¹ Д.Хатанбаатар, Ж.Мөнхдэлгэр, Б.Очир, Р.Төгссайхан, С.Болормаа, Ю.Болдбаатар, Б.Цэндбаяр, Т.Санжмятав. Завхан аймгийн Алдархаан сумын “Ямаан ус”-ны Хүннүгийн язгууртны дурсгалт газарт хийгдсэн археологийн судалгаа. Монголын Археологи-2022. УБ.2022.т90-95., Д.Хатанбаатар, Ж.Мөнхдэлгэр, Г.Ариунболд, С.Болормаа, Б.Цэндбаяр. Завхан аймгийн Алдархаан сумын “Ямаан ус”-ны Хүннүгийн язгууртны дурсгалт газарт хийгдсэн археологийн судалгаа. Монголын Археологи-2023. ЭШХЭ.2023.х69-73.

² Д.Хатанбаатар, Ж.Мөнхдэлгэр. Ямаан усны Хүннүгийн язгууртны булшны судалгаа-I. УБ.2023.

³ Д.Нямсүрэн, Жу Хён Гён, Д.Хатанбаатар, Г.Ариунцэцэг. Хүннүгийн язгууртны булшинаас илэрсэн модон эдлэлийн хадгалалт, хамгаалалт ба төрөл зүйлийн шинжилгээний урьдчилсан үр дүн. Монголын Археологи-2022. УБ.2022.т102-106., Жу Хён Гён, Д.Хатанбаатар, Жу Нам Чол, Чуи Хюу Рён. Хүннүгийн язгууртны дурсгалаас илрүүлсэн тэрэгний цонгийн бичил бүтцийн шинжилгээ. Монголын Археологи-2022. УБ.2022. т106-109., 최효령, 조현경, D. Khatanbaatar, J. Munkhdelger, 조남철. 몽골 야만오스 61호묘 출토 청동유물의 과학적 분석. 제57회 춘계학술대회.2023., Д.Хатанбаатар, Ж.Мөнхдэлгэр, Г.Ариунболд, С.Болормаа, Б.Цэндбаяр. Завхан аймгийн Алдархаан сумын “Ямаан ус”-ны Хүннүгийн язгууртны дурсгалт газарт хийгдсэн археологийн судалгаа. Монголын Археологи-2023. ЭШХЭ.2023.х69-73., Д.Хатанбаатар, Ж.Мөнхдэлгэр. Завхан аймгийн Алдархаан сумын “Ямаан ус”-ны Хүннүгийн язгууртны дурсгалт газарт хийгдсэн археологийн судалгаа. “Монголчуудын хойлгын зан үйл: уламжлал-орчин үе-чиг хандлага” IV хурал. УБ.2024.х10-26., Д.Хатанбаатар, Ж.Мөнхдэлгэр. Ямаан усанд хийгдсэн Хүннүгийн язгууртны булшны судалгаа. Interactions between the Central Plains and the Grasslands: International Symposium on New Discoveries and New Research in Xiongnu Archaeology. 2024., Jacqueline Eng, Michelle Hrivnyak, Erdene Myagmar, Dorjpurev Khatanbaatar, Jigjav Munkhdelger. “Bioarchaeological analysis of an elite Xiongnu site, Yamaan us, in western Mongolia”, 93th annual meeting of the American

Тус оршуулгын цогцолборт 2022, 2023, 2024 онуудад язгууртны төрөлд хамаарах 2 булш (Ямаан ус 58, 61-р дурсгал) болон дагуул 5 булш (Ямаан ус 58-1, 2, 61-1, 2, 3), жирийн иргэдийн төрөлд хамаарах 5 булш (Ямаан ус 33, 46, 52, 54, 59-р булш) буюу нийт 12 дурсгал малтан судалжээ.

Ямаан усны Хүннүгийн оршуулгын цогцолборт гадаад байгууламжийн хувьд дөрвөлжин хэлбэрийн үүдэвчтэй болон цагариг гэсэн 2 үндсэн хэлбэрийн булш байгаа болох нь тогтоогдоод байна. Анхны хайгуулын дүнд цагариг хэлбэрийн үүдэвчтэй булш хэмээн үзэж байсан дурсгалууд нь гадаад зохион байгуулалт эвдэгдэж, тухайн хэлбэрийг олсон болох нь малтлага судалгааны явцад тодорхой болсон билээ.

Дагуул булшны тухайд жижиг хэмжээтэй язгууртны булш дагуулгүй, харин булшны хэмжээ томрох тусам баруун, зүүн талдаа нумарсан байдалтай гадаад зохион байгуулалтын хувьд Хүннүгийн жирийн иргэдийн булштай төстэй дагуул булш (1-30 хүртэл) үйлддэг ба⁴ Ямаан усны 61-р булшны зүүн талд 3 булш, 58-р булшинд 2 булш дагалдуулан хийсэн байв. Ямаан усны 61-р булшинд 20-25 насны эмэгтэй хүнийг оршуулсан байсан бол дагуул булшнуудад 18-24 (Эм?), 25 (Эр?), 14-15 (Эм) настай хүмүүсийг, 58-р булшинд 20 настай эрэгтэйг оршуулсан байх ба түүнд дагалдуулан 16-19 насны болон 40-45 насны эрэгтэй хүнийг дагалдуулсан байжээ. Үндсэн болон дагуул булшнаас илрүүлсэн хүний яснуудад хийсэн

судалгаагаар бүгд монголжуу төрхтэй болохыг тогтоосон явдал нь судалгааны өндөр ач холбогдолтой юм.

Судлаачид Хүннүгийн язгууртны булшнаас илэрдэг эд зүйлсийг 1. Сүйх тэрэг, адуу малын тоног хэрэгсэл, 2. Хувцас, гоёл чимэглэлийн зүйлс, 3. Ахуйн хэрэглээний зүйлс, 4. Зэр зэвсгийн зүйлс, 5. Оюуны соёл, шүтлэг бишрэлийн холбогдолтой зүйлс гэж үндсэн 5 хэсэгт хуваан авч үздэг ба Ямаан усны 61-р булшнаас сүйх тэрэг болон адуу малын тоног хэрэгсэл, зүмбэрдэж хийсэн үүлэн хээ бүхий модон тэвш, алт шармал хүрэл морины дүрст чимэглэлүүд, хаш чулуун эдлэл болон шилэн эдлэлийн хэсгүүд, шавар болон хүрэл сав суулга, завьяаны хэсгүүд, нар, сарны дүрст алтан чимэглэл, авсны 4 дэлбээт цэцгэн ялтсан чимэглэл, ясан савх, чулуун зүүлт, чимэглэл, алтан ялтас зэрэг 200 гаруй эд өлгийн зүйлс, 58-р булшнаас сүйх тэрэг, адуу малын тоног хэрэгсэл, хүрэл морины дүрст чимэглэлүүд, хаш чулуун эдлэл, авсны ялтсан чимэглэл, бог бод малын шагай зэрэг урьд жилийн малтлага судалгаагаар олдож байсан эд зүйлсийн зэрэгцээгээр төмөр зэв, нумын ясан наалт зэрэг зэр зэвсгийн холбогдол бүхий олдвор хэрэглэгдэхүүн илэрч олдсон нь өмнө хугацаанд малтан судлагдсан Хүннүгийн язгууртны Гол мод-1, Гол мод-2, Ноён уул, Дуурлиг нарс зэрэг зөвхөн томоохон оршуулгын газруудаас илэрч олддог эд зүйлсийн иж бүрдэлтэй олон талаар ижил байна.

Дурсгалаас илэрсэн тэрэгний төмөрлөг эд ангиудад хийгдэх

Association of Biological Anthropologists, USA, 2024-3-23, vol. 183. Issue S77, pp. 48

⁴ Э.Мижиддорж, Б.Галбадрах. Хүннүгийн язгууртны булшны дагуул булшны оршуулгын зан үйлийн онцлог // Монголчуудын хойлгын зан үйл II. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар., 2019. т62-84


лабораторийн судалгаа явагдаж байгаа төдийгүй булшнаас олдсон тэрэгний модон тэвшинд хийсэн судалгаагаар уг тэвшийг Монголын уугуул⁵ нарс модоор хийсэн байх магадлал өндөр болохыг тогтоогоод байна. Үүгээр тогтохгүй булшнаас илэрсэн суварга мэт модон эдлэл, хүрэл утлагын сав нь Монголд анх удаа илэрч олдож буйгаараа онцлогтой билээ.

Бид одоогийн байдлаар Ямаан усны язгууртны буюу үүдэвчтэй булшнаас илэрсэн 2 хүний ясны дээжид үнэмлэхүй он цаг тогтоох радиокарбоны судалгааг хийлгээд байна. Тус судалгаагаар Ямаан усны 61-р булшны он цаг НТӨ 55 – НТ 62 (92.2%), 61-р булш НТӨ 46 - НТ 79 (93.9%) онд холбогдох буюу НТӨ I зууны дунд хагасаас НТ I зууны дунд хагаст холбогдох үзүүлэлт гарчээ.


Ийнхүү харьцуулсан болон үнэмлэхүй он цагийн судалгааны дүнд Ямаан усны дурсгалт газрын ерөнхий он цагийг НТӨ I - НТ I зуун

гэж баримжаалах бололцоотой болсон нь өмнө үеийн олонхи судлаачдын Хүннүгийн язгууртны булшийг НТӨ I зууны төгсгөлөөс НТ I зуунд холбогдох буюу Умард Хүннүгийн үед бүтээгдсэн гэж үздэгтэй үндсэндээ дүйж байна. Малтлага судалгаагаар Ямаан усны дурсгалт газар нь Монголд судлагдаад буй Хүннүгийн язгууртны булш, оршуулгын томоохон цогцолборуудтай дүйх хэмжээний судалгааны өндөр ач холбогдолтой дурсгалт газар болох нь тогтоогдсон ба судалгаагаар илрүүлсэн зарим олдворын сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалт, лабораторийн нарийвчилсан шинжилгээний ажлууд ШУТИС-ийн НХСургууль, ШУТИСийн Механик тээврийн сургуулийн “Соёлын өвийн органик бус эдлэлийн лаборатори” болон Соёлын өвийн үндэсний төв зэрэг газруудад хийгдэж байгаа ба хүн болон малын ясанд хийгдэх хоол хүнс тэжээлийн болон эртний удамшил зүйн судалгааны ажлууд гадны өндөр түвшний лабораториудад илгээгдээд байна.


⁵ Д.Нямсүрэн, Жу Хён Гён, Д.Хатанбаатар, Г.Ариунцэцэг. Хүннүгийн язгууртны булшнаас илэрсэн модон эдлэлийн хадгалалт, хамгаалалт ба төрөл зүйлийн шинжилгээний урьдчилсан үр дүн. Монголын Археологи-2022.УБ.2022.т102-106




Зураг 1. Ямаан усны дүрсгалт газрын дэвсгэр зураг



Зураг 2. Ямаан усны 61-р бушины малтлагын үе



Зураг 3. Ямаан усны 58-р булсны малтлагын үе



ХАЛХЫН ХАР ОЧИР ЗАЙРАНГИЙН ТҮҮХЭН ДҮР: БӨӨГИЙН ЗАН ҮЙЛ БА ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН УЯЛДАА

Гэндэнжамцын Хишигбадам

МУИС-ийн Философи, шашин судлалын докторант

Удиртгал

Монголын уламжлалт соёл, шүтлэгийн бүтэц дотор бөөгийн зан үйл нь зөвхөн шүтлэг төдийгүй тухайн нийгмийн ёс зүй, дэг журам, эрх зүйн харилцааг зохицуулах нэгэн чухал институт болж хөгжиж иржээ. Энэ хүрээнд шүүх таслах, эвлэрүүлэх, газар эзэмших, гэр бүлийн ёс зүй, шүтээн тахилгын зан үйл зэрэг олон үйлд бөө нарын оролцоо, удирдлага чухал байв. Халхын хар Очир зайран хэмээн алдаршсан бөө нь XIX–XX зууны заагт зөвхөн домын хүчээр бус, хууль ёсны уламжлал, нийгмийн зохицуулалтанд гүйцэтгэж байсан үүргээрээ онцлог түүхэн дүр байв. Түүний зан үйлд зөвхөн шүтлэгийн утга төдийгүй үндэстний хууль ёсны уламжлал, сэтгэлгээний тогтолцоо тусгалаа олсон байдаг. Гэвч энэ өнцгөөс нарийвчлан судалсан бүтээл, түүхийн баримт цөөн бөгөөд Очир зайрангийн эрх мэдэл, ёс зүйн үүргийг гүнзгий шинжилсэн судалгаа байхгүй. Түүний талаар багахан танилцуулга бичье.

Халхын хар Очир зайрангийн түүхэн гарвал, нутаг ус: Халхын хар Очир зайран /бас “Алдарт Торгоны замын тэргүүн зайран” гэдэг/ нь 1850-аад оны үед (1929 оны хүн амын тооллогын бүртгэлд Халигудайн Очир 78 настай гэж тэмдэглэгдсэн)¹ Засагт Хан аймгийн Дайчин Вангийн хошуу буюу одоогийн

Говь-Алтай аймгийн Төгрөг сумын харъяат Халигудайн хүү болж төрсөн. Тэрээр өөрийн хошуугаар зогсохгүй зэргэлдээ хошуу нутгаар залагдан ядарч, зовсон олон түмэнд тус хүргэдэг хүчтэй олон онгодтой, 13 үе дамжсан зайран байв. Тэрээр 1935 оны орчим өөд болсон бөгөөд түүний бөөгийн хуяг дуулга, хувцас хэрэглэл нь түүний хүү О.Гончигийн гэрт нэг хэсэг хадгалагдаж байсныг Төгрөг сумын нутаг Чавчаалын хөндий хэмээх газрын нэгэн агуйд ач хүү Г.Дамбил, Г.Тумбаа нар нь улааны хэт хувьсгалчдаас нуужээ. Хожим 1963 оны хавар ач хүү Г.Тумбаа нь хувцас хэрэгслийг нь олон нийтийн хүртээл болгохоор тухайн үед Говь-Алтай аймгийн Орон нутаг судлах музейн эрхлэгчээр ажиллаж байсан П.Довчинд хүлээлгэн өгчээ. Очир зайрангийн бөө онгод 1920-1990-ээд оны эхэн хүртэлх үед хэсэг тасарсан хэдий ч 1997 оноос түүний гуч хүүд эргэн заларчээ.²




Зураг 1: 1906-1909 оны орчим Финляндын жуулчны авсан гэрэл зураг

¹ Архивын Ерөнхий газрын архив <https://www.archives.gov.mn/>

² Төгрөг сум байгуулагдсаны 80 жилийн ойд зориулан хэвлэгдсэн “Төгрөгийн хөх шашитир” 2006: 50-51

1909 онд Финляндын аялагч, гэрэл зурагчин Сакари Палси Хэл шинжлэлийн эрдэмтэн Г.Ж.Рамстедтийн хамт Хаант Оросоос Хүрээгээр дамжин Говь-Алтайн хязгаар хүртэл урт аялал хийж, Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Баянголын хөндий хэмээх газарт Очир бөөгийн гэрэл зургийг авчээ. Палси аяллынхаа тухай герман хэлээр бичсэн нь удаан хугацаанд хэвлэгдээгүй байсан бөгөөд 1982 онд Хален засварлаж хэвлүүлжээ. 2014 онд миний удирдагч Др.Обрущанский Борбала Финляндын Үндэсний музейгээс Очир бөөгийн гэрэл зургийн хуулбарыг авсан. 2017 онд Сейцонен 1909 оны Финляндын экспедицийн маршрутыг тодорхойлсон боловч тэд хүрэл зэвсгийн үеийн дурсгалт газруудаар зочилсонд нь голчлон анхаарчээ.



Зураг 2 (Финляндын музейгаас ирсэн захидал)

I. Бөө нарын хууль ёсны эрх мэдэл ба зан үйл

Монгол бөөгийн уламжлалд хууль, эрх зүйн чанартай тусгай зан заншлууд байсаар ирсэн бөгөөд тэдгээр нь тухайн нийгэм, овог аймаг, ард иргэд, бөө

нарын хоорондын харилцаа, сахилга ёс суртахуун, гэм нүглийг зохицуулах үүрэгтэй байв. Үүнийг бид “ёс заншлын хууль” буюу хуучин уламжлалт шүтлэгт ёс суртахууны хэм хэмжээ гэж ойлгож болно. Бөө хүн нь зөвхөн сүнстэй харьцагч биш, нийгмийн дотор шударга ёсыг сахиулагч, маргаан таслагч, ёс суртахууны сахиул байв. Хэн дуртай нь бөө болох боломжгүй бөгөөд удам угсааны уламжлал, сахилга бат, журам мөрдөгддөг байв.

Бөө хүнд юуг зөвшөөрдөг, юуг хориглодог вэ?

Зөвшөөрөгдөх зүйлс:

- Онгодтой харьцах, өвөг дээдсийн сүнсийг дуудах,
- Эвлэрүүлэн зуучлах, хулгай маргааныг шийдвэрлэх,

Овгийн тахилгын гол удирдагч байх,

Хориглох зүйлс:

- Сэтгэлийн хөдөлгөөнөөр дом, засал хийж болохгүй,
- Худал хэлэх, ашиг хонжоо хайж болохгүй.
- Бөө нарын эрх зүйн чанартай зан заншлын жишээнүүд:

Гэм нүглийг цагаатгах зан үйл: Бөөгийн шүтлэгт гэм нүгэл (буруу үйл үйлдэх, лус савдагийг хилэгнүүлэх, цээрийг зөрчих, хүн гомдоох, амьтан тамлах, ах захаа үл хүндлэх гэх мэт)-ийг онгод, савдагт гэмшиж, уучлал гуйх, цагаатгалын зан үйл хийх замаар засдаг байсан. Энэ нь өнөөдрийн шүүхийн ял, шийтгэлтэй төстэй ойлголт юм. Гэхдээ сүнслэг түвшинд засал хийж, тухайн хүн ёс суртахууны хувьд “ариусах”-ыг зорьдог байв.

Онгодыг үл хүндэтгэсэн тохиолдолд ногдуулах хориг, шийтгэл: Бөөгийн онгодын хуяг дуулга, хэрэгсэлд гар хүрэх,

гутаах, шатаах, голох үг хэлэх нь маш том нүгэлд тооцогддог байжээ. Үүнийг хийсэн хүнд онгод хилэгнэж, “галзуурах, өвдөх, зовлон тохиох” зэргээр сүнслэг шийтгэл ногдуулна гэж үздэг байв.

Бөөгийн хүрээллийн дотоод сахилга, журам: Бөөгийн удам дамжсан онгодыг өөр бөө булаан эзэмших, хуурамчаар дуудлага хийх, онгодын ивээлгүй хүн бөө болохыг оролдох зэрэг нь хүнд нүгэл байв. Ийм нөхцөл үүссэн тохиолдолд ахмад бөө нар хуралдаж, тухайн хүнийг бөө нарын хүрээллээс хөөх, онгодыг нь зогсоох зэрэг арга хэмжээ авч болдог байжээ.

Цээр, хоригийн хуулиуд: Тодорхой сар, өдөр, улиралд хийхийг хориглодог зан үйлүүд, уул ус, онгодын газар нутгийг гутаахгүй байх ёстой. Энэ нь хатуу цээртэй байв. Үүнийг зөрчвөл “савдаг хилэгнэж”, тухайн хүн болон түүний гэр бүлд гай ирнэ гэж үздэг байсан.

Бөөгийн зөвлөл, ахлагчийн шийдвэр: Зарим тохиолдолд бөөгийн хүрээнд шийдвэр гаргах дотоод зохион байгуулалттай байсан. Жишээ нь: Хэн бөө болох ёстой, онгод буулгах эрх хэнд байгаа, сэтгэл мэдрэлийн асуудалтай хүн жинхэнэ онгодтой эсэхийг шүүн тунгаах зэрэг.

Монгол бөөгийн уламжлалд төрийн хууль мэт албан ёсны эрх зүйн тогтолцоо байгаагүй ч, ёс суртахуун, сахилга бат, хариуцлага, гэм нүгэл, уучлал, цээр хориг зэрэг нь нийгмийн харилцааг зохицуулдаг, өргөн хүрээтэй сүнслэг “эрх зүйн тогтолцоо” байсан гэж хэлж болно. Халхын хар Очир зайран эдгээр зан заншлыг чанд баримталж, хулгай маргаан, газрыг зөвшөөрөлгүй эзэмших, муу үйл үйлдэхийг илрүүлэн таслан зогсоож байсан тухай яриа, түүх

олноор хадгалагдан үлджээ.

II. Бөөгийн гэр бүлийн ёс заншил: Овоо тахилгын жишээ.

Монголын уламжлалт шүтлэгийн хүрээнд бөө мөргөл нь зөвхөн сүнслэг орчинтой харилцах, онгод сахиусыг шүтэх, тахих зан үйлээр хязгаарлагдахгүй бөгөөд тухайн овог, ястан, нутгийн хүмүүсийн хоорондын харилцаа, ёс суртахуун, гэм нүгэл, цээр хориг зэргийг зохицуулах ёс заншлын эрх зүйн үүргийг давхар гүйцэтгэж байжээ. Энэ нь өнөөгийн эрх зүйн ойлголтоор “ёс суртахууны эрх зүй”, “сүнслэг сахилга бат” гэж нэрлэгдэхүйц онцлог тогтолцоо байв.

Очир заарин бол бөө мөргөлийн дотор зөвхөн сүнс дууддаг бөө биш, харин ч олон нийт, овог аймаг, нийгмийн хүрээнд онгод, савдаг, газар шүтлэг, удмын сахиусуудтай “гэрээ” байгуулж, тэдний нэрийн өмнөөс сахилга хэм хэмжээг сахиулах, ёс цээрийг чандлан баримтлуулах, гэм нүгэл үйлдсэн этгээдэд засал хийж, уучлал гуйх ёслолыг гүйцэтгэх чухал үүрэгтэй байжээ.³

Бөөгийн гэр бүлд тусгай сахилга, ёс зүй үйлчилдэг. Очир зайрангийн гэр бүл нь нутгийнхаа овоо тахилгын үеэр олон нийтэд үлгэрлэн оролцдог байсан бөгөөд: Овоо тахилга бол зөвхөн шүтлэгийн биш, хууль ёсны батламжлал байв. Тэнд хэн эзэн болох, аль нутаг дэвсгэр хэний эрхэнд байх, ямар овогт онгод ирсэн зэрэг нь тахилгаараа шийдэгддэг. Очир зайран “Энэ уулыг энэ овог хамгаална, энд ан хийхийг цээрлэнэ” хэмээн зарлиг буулгадаг байсан. Энэ нь тухайн газрын хэрэглээний эрх, “эзэн”-ийн баталгаа байжээ.

Монголын төрийн уламжлалд газар бол төрийн өмч. Харин бөө

³ Төгрөгийн хөх шастир, 2006: 32-33

мөргөлд, Овоо бол байгалийн амьтай, эзэнтэй оршихуй. Гэвч түүнийг овог, аймаг, нутаг ус хамгаалдаг. Монголын уламжлалт бөө мөргөлийн хамгийн чухал зан үйл бол овоо тахилга бөгөөд энэ нь зөвхөн сүсэг бишрэлийн ёслол бус, тухайн газар нутгийн эзэн савдагтай харилцах, удам угсааны сахилга бат, зан үйл, ёс суртахууны хэм хэмжээг сэргээх эрх зүйн шинжтэй хэрэг явдал байв. Монголчуудын үзэлд уул, ус бүрд сүнслэг эзэн оршин байдаг бөгөөд энэ савдагтай харилцах үүд хаалга нь тухайн нутгийн овоо юм. Овоо нь сүнслэг утгаараа газрын эзний оршихуйн илэрхийлэл, нийгэм-овгийн түвшинд уламжлалт ёсны өмчийн эрх, төрийн түвшинд бол үндэсний нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, байгаль хамгааллын бэлгэ тэмдэг гэж ойлгогдож иржээ.

Овоо эзэмших, тахих эрхийн жишээ: Очир зайрангийн шүтдэг уулын овоог зөвхөн түүний гэр бүл тахиж байсан. Гэвч үүнийг өмчлөл бус тусгай үүрэгт эзэмшил гэж үзэж болно. Тэрээр "Эзэнтэй газарт зөвшөөрөлгүй буух нь нүгэл" хэмээн анхааруулдаг байсан нь газрын хуулийн уламжлалт дүр байв.



Зураг 3: Өвгөн овоо, Төгрөг сум, Говь-Алтай аймаг. Очир бөөгийн удмынхны тахиж шүтдэг овоо. Түүний гуч хүү Дамбилын Мөнхбаяр, Дамбилын Даваахүү нар хүндэтгэл үзүүлж буй нь

Овоо тахилгын талаарх уламжлалт эрх зүйн ойлголт: Монголчуудын дунд газар, уул, овоо нь тодорхой овог, ястан, удам угсаанд хамаарах ёс зүйн болон зан үйлийн өмч байв. Иймээс тухайн овоог: Зөвхөн өөрийн удам тахиж болно, Тахилгын үед очих, үг хэлэх, үйлдэх ёс цээртэй дүрэм мөрдөгдөнө. Очир заарин зэрэг тусгай онгодтой, эрх мэдэлтэй хүмүүс л овоог тахих эрхтэй байдаг. Овооны эзэн нь шууд утгаараа газар нутгийн савдаг онгод боловч, зан үйлийн хүрээнд тухайн нутгийн овог, заарин, ахлагч бөө түүнийг тахих эрхийг ёс суртахууны эрхийн үндсэн дээр хэрэгжүүлдэг байв. Энэ нь уламжлалт эрх зүйн хүрээнд нэн хүндэтгэх өмчийн эрх хэмээн ойлгогдож байсан.

Орчин үеийн эрх зүйн зохицуулалт: 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулиар газар нутгийг төрийн өмч гэж заасан. Энэ хүрээнд уул, ус, ой мод, овоо зэрэг нь хууль ёсоор төрийн мэдэлд багтана. Гэвч Соёлын өвийн тухай, Байгаль орчны тухай хууль, Шашны эрх чөлөөний тухай хууль зэргээр уламжлалт овоо тахилгыг:

- Ард иргэдийн шашин, зан заншлын эрх чөлөө,
- Соёлын өвийн хамгаалалт,
- Байгалийн сэтгэл зүй, ёс суртахууны шүтлэгийн орон зай хэмээн үзэн, тухайн зан үйлийг хамгаалан дэмжих зохицуулалттай болжээ.

Очир зайрангийн үүрэгтэй уялдах нь: Очир зайран нь зөвхөн онгод дууддаг бөө бус, овог удам, уул усны савдагтай байгуулсан гэрээг хадгалагч, зан үйлийн сахилга бат сахиулагчийн хувьд: Овоо тахих тусгай эрх бүхий этгээд байжээ. Тэрээр “газрын эзэн савдагт хандан зөвхөн өөрийн эрхээр

тахилга хийж чадах хүн” хэмээн хүлээн зөвшөөрөгддөг. Тиймээс Очир заарин овооны эзэн биш ч, газрын эзний өмнө тахилгын эрхээ хэрэгжүүлдэг ёс суртахууны “итгэмжлэгдсэн төлөөлөгч” юм.

III. Адууны хулгайн эсрэг хууль ёс ба Очир зайрангийн үүрэг:

Монголчуудын хувьд адуу бол хүний унаа хүлэг төдийгүй тэнгэрийг бэлгэддэг халуун хошуут мал юм.⁴ Тиймээс адуу хулгайлах нь хамгийн нүгэлтэй, ялтай хэрэг байв. Тухайлбал: Чингис хааны “Их засаг” хуулиар адуу хулгайлагчийг шилбийг нь хугалах, амьдаар нь цаазлах шийтгэлтэй байсан. Харин өнөөдөр адуу хулгайлах нь Монгол Улсын хуулиар хүнд гэмт хэрэгт тооцогддог. Энэ талаар Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд “Мал хулгайлах” гэдэг нэртэйгээр тусгайлан заасан байдаг. Эрүүгийн хариуцлага:

17.3 дугаар зүйл. Мал хулгайлах

1. Нэг удаагийн, бусдын малыг хууль бусаар авах (хулгайлах) нь:

- Торгууль (10 сая хүртэл төгрөг),
- Хөдөлмөр эрхлэлтийг хязгаарлах,
- 1 хүртэл жилийн хорих ял ногдуулж болно.

2. Дахин давтан, бүлэглэн, эсвэл маш олон тооны мал хулгайлбал:

- 2–5 жилийн хорих ял онооно.

3. Онц ноцтой нөхцөлтэй (жишээ нь сүрэг мал, хүч хэрэглэсэн, бүлэглэж зохион байгуулалттай үйлдсэн) бол: 5–12 жилийн хорих ял оноож болно.⁵

Очир зайран ийм хэрэг гарсан үед онгодоо буулгаж эзнийг илрүүлэн, цээрлүүлдэг байсан. Очир бөөгийн зан үйлийн жишээ: Дүн дан хийх хэнгэргийн дуунаар сэрсэн ач хүү Дамбил нь нөмөрч унтсан цагаан нэхий дээлний суганы оёдлын ханзархайгаар гэрийн доторхийг тойруулан харав. Гэрийн хойморт өвөг эцэг Очир нь бөөгийн өмсгөл хуяг дуулгаа өмсөж, гартаа хэнгэргээ дэлдэнэ. Төд удалгүй тэрээр завилан суусан тэр янзаараа суудал дээрээ бүтэн эргээд, дараа нь газраас дээш хөөрч, буцаад газарт буух аж. Очир бөө:

Хур бороон дундуур
Хурдлан гүйгээд ир
Хайя, хүүе, хайя.
Зүсэр бороон дундуур
Зүглэн гүйгээд ир
Хайя, хүүе, хайя.
Шиврэх бороон дундуур
Шогшин гүйгээд ир

Хайя, хүүе, хайя... гэж дуудав. Тэгснээ алд хэрийн сэлмээ тулганд дүрэлзэх гал руу хийж, мах шиг улаан болтол нь улайсгаад түүнийг хэлээрээ долоогоод энгэр дэх бөөгийн толио гаргаж, хэсэг харснаа сэлмээрээ хэлээ огтлон цус гаргаж, бөөгийн толь руугаа нулимав. Тэгснээ Очир бөө завилсан тэр чигээрээ тулганы гурван тогто дамжин үсэрч, гэрийн үүдэнд хүрээд, үүдээрээ шагайж хэн нэгэнтэй ямар нэгэн юм шивнэн ярилцах үедээ тэрээр гурван хөлтэй сонин шувуу мэт дүрстэй болсон байв. Тэр явдлаас хоёр хоногийн дараа нэг сайхан бороо шивэрсэн тогтуун үдшээр адуу нь цуварсаар гэрийнхээ гадаа ирэв гэнэ. Харин адууг нь хөөсөн хасагууд Алагнуурын говьд шуурганд хөөгдөн

⁴ Монгол соёлын тайлбар толь бичиг, С.Дулам, 2024: 32

⁵ Монгол Улсын Эрүүгийн хууль, 2020 оны шинэчилсэн найруулга

хөлдөж үхсэн байжээ.⁶ Дээрх үйл явдалд Очир бөөгийн увидас чадал нөлөөлсөн нь дамжиггүй бөгөөд гэм нүглийг цагаатгах, хулгайчийг шийтгэх эрх зүйн шинжтэй зан үйл гэж ойлгож болох юм.

IV. Бөө хүний оршуулгын тухай: Бөө хүнийг нас барахад онгон газар оршуулна эсвэл шатаана. Түүний хувцас, онгон, онгодыг шатаах буюу нууж хадгалах ёстой. Ястан бүрийн хувьд харилцан адилгүй зан үйлтэй.

Судалгааны явцад бөө хүнийг нас барсны дараах зан үйл, эдлэл хэрэглэлийг нь яадаг вэ гэдэг асуудалд анхаарлаа хандуулсан. Ингэхэд:

1. Онгод буцаалт буюу онгод салгах ёс: Нас барсан бөө хүний онгодыг “буцаах” буюу тусгай зан үйлийн дагуу салгах, эсвэл хойч үеийнхэн нь өвлөдөг байна. Очир зайрангийн хувьд тухайн үеийн нийгэм, цаг үеийн хэцүү байдлаас шалтгаалан хойч үе нь өвлөн авч чадаагүй.

2. Эд хэрэгслийн хувь заяа: Эдлэл / хэрэглэлийг яах ёстой вэ?

Хуур хөгжим: Онгодын сүнснийг дууддаг хамгийн чухал хэрэгсэл тул тусгай ёслолоор шатаах, хадгалах, өндөр уулын агуйд нуух эсвэл галд өргөж шатаадаг. Очир зайрангийн эдлэл хэрэглэлийг уулын агуйд нуусан.

Толь, зоос, сахиус: Гэр бүлийнхэнд өвлүүлдэггүй, зарим үед газар булдаг, эсвэл удган мод⁷-онд даатгана.

Дээл, бүс, малгай: Онцгой тохиолдолд онгод өвлөх дараагийн хүнд өгнө. Эс бөгөөс шатаах эсвэл газар даатгана.

Хувийн хэрэглэл (аяга, уут): Ихэнхдээ шатаадаг, зарим үед хээр орхих зан үйл хийдэг.

3. Онцгой тохиолдолд шүтээн болгодог: Ховор тохиолдолд хүчтэй зайран, удганы эд зүйлсийг онгод шүтээний хамт хадгалан ард түмэн тахиж дээдэлдэг. Жишээлбэл: Очир зайрангийн хуучин дээл, хуур, хэнгэрэг зэрэг нь өв соёлын дурсгал болон хадгалагдах үндэстэй гэж үзэж болно.

4. Орчин үеийн үзэл: Орчин үед зарим бөө нар эд зүйлээ гэр бүлийн залгамж хүндээ өвлүүлдэг ч уламжлал ёсоор “онгодын даалгаваргүйгээр хэрэглэж болохгүй” гэж үздэг. Иймд бөө нас барсны дараа эдлэл хэрэгслийг буруу ашиглах нь сөрөг үр дагавартай гэж үздэг.

Талархал

Энэхүү өгүүллийг бичихэд урам зориг өгч, дурсамж, түүх, уламжлалаа хуваалцсан нутгийн ахмадууд, мөн эрдэмтэн судлаач багш нартаа талархал илэрхийлье. Монголын уламжлалт эрх зүйн үнэт өвийг судлахад хувь нэмэр оруулж буй бүх хүмүүст талархан хүндэтгэл илэрхийлье.

⁶ Өвөг эцэг Г.Дамбилын ярианаас

⁷ Уулын энгэр бэл, хормойд байгаа ганц модыг УДГАН МОД гэдэг.

Ном зүй

С.Дулам, 2024 *Монгол соёлын тайлбар толь бичиг*. Нандир хэвлэх үйлдвэр: Улаанбаатар.

Д.Бум-очир, 2017 *Монгол бөөгийн зан үйл*. МУИС Пресс Хэвлэлийн газар: Улаанбаатар.

Ч.Далай, 1959 *Монгол бөөгийн мөргөлийн товч түүх*. Шинжлэх Ухаан, Дээд Боловсролын Хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний хэвлэлийн газар: Улаанбаатар.

О.Пүрэв, 2009 *Монгол бөөгийн шашин*. ADMON компани: Улаанбаатар.

Н.Ням-осор, Ж.Цэцэгмаа, 2019 *Их Засаг хууль судлал*. Чингис хааны үеийн хууль цаазын эмхэтгэл. Их Засаг Их сургууль: Улаанбаатар.

Ү.Хүрэлбаатар, 2006 *Төгрөгийн хөх шаштир*. Мөнхийн үсэг: Улаанбаатар

МОНГОЛ УЛС ДАХЬ СИБИРИЙН ТУЛ (HUSCHIA TAIMEIN) ЗАГАСНЫ ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ХАМГААЛЛЫН ГЕНОМЫН СУДАЛГАА

Шрамко Габор^{1,2}

Удиртгал

Сибирийн тул загас (*Huscho taimen*) нь Зүүн хойд Азийн спортын загас агнуурын хамгийн үнэ цэнтэй төрөл зүйлийн нэг бөгөөд амьдрах орчны өөрчлөлт, зохистой бус агнуурын улмаас ноцтой аюулд өртөж байна.

Төрөл бүрийн молекул судалгааны аргуудыг ашиглан хийсэн өмнөх судалгаанууд нь тухайн зүйлийн популяцийн бүтцийн талаар чухал ойлголтыг өгсөн ч илүү өргөн хүрээтэй, өндөр нарийвчлалтай судалгаа хийх шаардлагатай хэвээр байна. Энэхүү судалгаанд бид Монгол Улс болон хөрш зэргэлдээх ОХУ-ын бүс нутгуудын гол мөрдийн систем дэх Сибирийн тул загасны генетикийн олон янз байдал, популяцийн бүтцийг судлахын тулд хязгаарлалтын бүсэд хамаарах ДНХ-ийн дараалалд (RADseq) суурилсан геномын аргыг ашигласан. Геномын өргөн хүрээний SNP мэдээллийн дүн шинжилгээ нь Номхон далай ба Хойд мөсөн далай руу цутгаж буй хоёр үндсэн усны хагалбар дахь популяциудын хооронд генетикийн гүнзгий ялгаа ажиглагдаж байгааг өмнө хийгдсэн судалгаанууд баталсан. Хоёр үндсэн усны сав газарын популяци нь геномын хувьд ихээхэн ялгаатай гетерозигот

байдлыг харуулж, Номхон далайн усны сав газарт чухал үүргийг гүйцэтгэдэг. Судалгааны явцад бид өндөр хэмжээнд боловсруулсан филогенетик ургийн модыг зурснаар популяцийн хувьслын түүхийг сэргээх боломжийг бидэнд олгосон. Ялангуяа чухал үр дүн бол Хойд мөсөн далай руу урсдаг жижиг Енисейн усны хагалбар дахь урьд өмнө мэдэгдээгүй генетикийн нэгжийг тодорхойлох явдал юм.

Нэмж дурдахад бид Ангарын сав газрын дээд хэсэг дэх популяциудын усны хагалбаруудын дунд генетикийн шилжилт хөдөлгөөн байгааг нотлох баримтыг олсон.

Энэ бүс нутгийн популяци саяхныг хүртэл Бага Енисей, Сэлэнгэ мөрний сав газар гэсэн хоёр чиглэлд хамааралтай байсан бөгөөд энэ нь холимог генетикийн найрлагатай популяцийг бий болгоход хүргэсэн. Бид мөн генетикийн бүтцэд пропорциональ бус хувь нэмэр оруулдаг зарим дасан зохицох локусуудыг (5.6%) тодорхойлсон бөгөөд үүнийг Бага Енисейн сав газарт орон нутгийн дасан зохицох хүчтэй шинж тэмдэг хэмээн тайлбарлаж болно.

Судалгааны үр дүнгүүдэд үндэслэн Монгол Улсад гурван өөр усны сав газарыг ялгах боломжтой: Тухайлбал,

¹ *Дебрецени ИХ Сургуулийн Байгалийн ШУ, Ургамал зүйн тенхим, Эволюц Геномын судалгааны баг; 4032 Дебрецен хот, Egyetem tér 1. email: sramko.gabor@science.unideb.hu*

² *HUN-REN-UD Természeti Biológiai Kutatócsoport; 4032 Debrecen, Egyetem tér 1.*

Номхон далайн сав газар, Сэлэнгийн сав газар, Бага Енисейн сав газар. Эдгээр сав газрын менежментийн нэгжүүдийг хүлээн зөвшөөрөх нь Сибирийн тул загасны Монгол Улс дахь нөөцийг тогтвортой удирдах, хамгаалахад нэн чухал бөгөөд ялангуяа нэгжүүдийн хооронд генетикийн холбоо байхгүй, үүнээс үүдэлтэй эмзэг байдлыг харгалзан үзэх нь чухал юм.

Хулд овгийн загасны төрлийг хамгаалах шинжлэх ухааны үндэслэлтэй, үр дүнтэй стратегийг боловсруулахад геномын аргуудыг ашиглах нь чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг бидний судалгаа онцолж байна.

Түлхүүр үг: хамгаалалтын геномик, орон нутгийн дасан зохицох чанар, генетикийн олон янз байдал, удирдлагын нэгж, RADseq

Танилцуулга

Хойд Евразийн цэнгэг усны экосистем нь дэлхийн хамгийн тусгаарлагдсан усны системүүдийн нэг боловч хүний үйл ажиллагааны нөлөөлөл нэмэгдэж байгаатай холбоотойгоор хурдацтай өөрчлөгдөж байна. Сибирь ба Монгол Улсын хойд хэсгийн усны хагалбарууд нь хулд загас тэр дундаа хамгийн том зүйл болох Сибирийн тул (*Hucho taimen*) загасаар баялаг юм. Түүхээс үзэхэд, энэхүү гайхалтай загас Сибирь даяар, түүнчлэн Оросын Холбооны Улсын Европын хэсэг дэх Ижил мөрний дээд сав газарт өргөн тархсан бөгөөд Монголын умард нутгууд, Зүүн хойд Хятад, Казахстаны

Зүүн хойд хэсгээр тархсан байв. Митохондрийн ДНХ-д үндэслэсэн филогенетикийн судалгаанууд нь хулдын овгийн гурван зүйл болох Европын хучо (*Hucho hucho*), баруун Хятадад нутагшсан хятад хучо (*H. bleekeri*), Сибирийн тул (*H. taimen*) -ын популяцийн ялгаатай зүйлийн статусыг баталж, Европ болон Азийн эртний удамшлын ялгаа нь паллеологийн үед үүссэн болохыг харуулж байна.²³ Митохондрийн ДНХ-ийн харьцангуй бага хэлбэлзэл нь одоо байгаа тул загасны популяциудад тодорхойлогддог бөгөөд энэ нь хагас сая жилийн өмнө хуваагдсан хоёр гаплогрупп байгааг харуулж байна. Эдгээр нь Хойд мөсөн далай, Номхон далайн сав газартай холбоотой байж болох баруун болон зүүн гаплогруппуудыг үүсгэдэг. Сибирийн тул загас нь Монгол орны загас агнуурын хамгийн чухал зорилтот төрөл зүйлийн нэг бөгөөд экологийн үүрэг нь ч онцгой: цэнгэг усны экосистемд махчин загас нь цэвэр усны идэшний сүлжээний төлөв байдлын индикатор гэж тооцогддог учраас эдийн засгийн чухал ач холбогдолтой юм. Иймд энэ зүйл загасны хамгаалалтанд ихээхэн анхаарал хандуулж, дэлхийн хэмжээнд ховордсон гэж тооцогддог. Энэ хүрээнд Монголын тул загасны популяцийг хамгаалах зорилгоор генетикийн хоёр ч судалгааг бид хийж гүйцэтгэсэн. Каус болон түүний багийнхан үндсэн томоохон голуудын бүх системээс дээж цуглуулж, митохондрийн ДНХ болон микро хиймэл дагуул дээр суурилсан генотип аргачлалаар тухайн популяцийн

³ Marić, S., S. Alekseyev, A. Snoj, et al. 2014. „First mtDNA sequencing of Volga and Ob basin taimen *Hucho taimen*: European populations stem from a late Pleistocene expansion of *H. taimen* out of western Siberia and are not intermediate to *Hucho hucho*.” *Journal of Fish Biology* 85, no. 2: 530-539. <https://onlinelibrary.wiley.com/doi/abs/10.1111/jfb.12428>

генетик бүтцийг тодорхойлсон.⁴ Үүний зэрэгцээ Галланд болон түүний багийнхан Монгол Улсын үндсэн хоёр усны хагалбарыг төлөөлсөн түүврийн багц дээр давхар задлах RADseq аргыг ашигласан боловч үндсэн голуудын аль нэг системийн дээжийг хамруулаагүй.⁵ Номхон далай болон Хойд мөсөн далайн усны хагалбаруудыг заагласан монгол нутгийн гол мөрнүүдэд тархсан Сибирийн тул загасны популяцийн дунд генетикийн үндсэн хагарлын шугам байгааг энэ хоёр судалгаа харуулжээ. Каус болон түүний багийнхны ашигласан генетикийн тэмдэглэгээ нь үндсэн удамшлын нарийн генетикийн бүтцийг судлах боломжийг олгодоггүй бол Галландын багийнхны ашигласан геномын арга нь тухайн зүйлийн филогеографийн хэв маягийн талаарх ойлголтыг өгсөн.

Харин сүүлийн үед Монголд Сибирийн тул загас ховордож байгаа нь тодорхой ажиглагдаж байна. Энэ бүхэн нь экологийн онцгой ач холбогдол бүхий энэ зүйл загасны генетикийн бүтцийн геномд суурилсан цогц судалгааг хийх тодорхой үндэслэл болж байгаа бөгөөд энэ нь дасан зохицох өөрчлөлтийг харгалзан үзэж, гол мөрний бүх үндсэн системийг төлөөлсөн дээжид тулгуурлан байгаль хамгаалах талаар үр дүнтэй шийдвэр гаргахад хувь нэмэр оруулах юм. Бидний судалгааны зорилго нь Монголын гол мөрнүүдийн систем болон зэргэлдээх ОХУ-ын нутаг Сибирийн тул загасны генетикийн

бүтцийг нэг удаагийн задгай (sd) RADseq мэдээлэлд үндэслэн судлах замаар судалгааны хоосон орон зайг нөхөх зорилготой юм.

Энэ хүрээнд бид дараах асуултуудад хариулт хайж байна: (i) Монгол орны тархалтын бүсэд ямар генетикийн үндсэн кластеруудыг ялгаж боломжтой вэ; (ii) дасан зохицох генетикийн өөрчлөлт нь популяцийн генетикийн бүтцэд хэрхэн нөлөөлдөг; (iii) удамшлын мэдээллийг харгалзан тухайн зүйлийн менежментийн нэгжүүдийг Монгол улсад хэрхэн дахин үнэлэх боломжтой вэ.

Судалгааны материал ба аргачлал

Сибирийн тул загасны дээжийг Монгол орны гол мөрнүүдийн системээс цуглуулсан бөгөөд эдгээр нь Номхон далай болон Хойд мөсөн далайн усны хуримтлалын санд хамаардаг. (1-р зураг). Дээж цуглуулах явцад бид Монголын 8 голын 8 популяцийг судалж, нэмэлтээр хөрш зэргэлдээх ОХУ-аас 3 популяцийг нэмж судалсан. Загасчид гидробиологичдын тусламжтайгаар дээжийг сэрвээний хавчаар хэлбэрээр цуглуулаад дээж авсны дараа загасыг амьдарч буй орчинд нь хор хөнөөлгүй буцаан тавьдаг байсан. ДНХ-ийн чанарыг хадгалахын тулд эд эсийн дээжийг этанолд хадгалсан. Генетикийн судалгаанд бүрэн геномын ДНХ-г тусгаарлаж, зөвхөн өндөр чанартай, хуваагдаагүй дээжийг ашигласан. Бид дээжээс хоёр бие даасан RADseq

⁴ Kaus, A., S. Michalski, B. Hänfling, et al. 2019. „Fish conservation in the land of steppe and sky: Evolutionarily significant units of threatened salmonid species in Mongolia mirror major river basins.” *Ecology and Evolution* 9, no. 6: 3416-3433. <https://onlinelibrary.wiley.com/doi/abs/10.1002/ece3.4974>

⁵ Galland, L. M., J. B. Simmons, J. P. Jahner, et al. 2021. „Hierarchical genetic structure and implications for conservation of the world’s largest salmonid, *Hucho taimen*.” *Scientific Reports* 11, no. 1: 20508. <https://doi.org/10.1038/s41598-021-99530-3>

каталоги санг үүсгэсэн бөгөөд үүнд нийт жар гаруй генетикийн мэдээлэл багтсан. Каталогиг сангуудын чанарыг техник давтамжаар шалгасан. Хязгаарлалтын талбайтай холбоотой ДНХ-ийн дарааллыг (RADseq) тогтоохдоо тусдаа ховор фермент (SbfI)-ийг ашигласан бөгөөд үүссэн ДНХ-ийн санг Illumina дараалал ашиглан эрэмбэлсэн. Ажлын дараалал нь өмнөх дээжүүд дээр түшиглэсэн⁶. Сангийн дэс дарааллын өгөгдлийг чанарын хатуу хяналтанд оруулсны дараа дээж бүрт хуваарилсан. Гарсан хариуг ойрын төрөл зүйл болох Дунай мөрний галоца (Huchо huchо) загасны сангийн геномтой харьцуулсан бөгөөд PCR-ын хуулбарыг цаашдын шинжилгээнд хамруулаагүй. Генетик хувилбаруудыг (SNPs) тодорхойлсны дараа өгөгдлийг олон шатлалттайгаар шүүж, зөвхөн паралог нөлөөгүй найдвартай маркеруудад дүн шинжилгээ хийсэн. Ялгасан SNP мэдээллийн багцад филогенетик болон популяцийн геномын аргуудыг ашиглан дүн шинжилгээ хийсэн. Популяци хоорондын хувьслын харилцааг сэргээж, удамшлын ялгааны цар хүрээг тодорхойлж, популяцийн бүтэц, боломжит хольцын хэв маягийг судалсан. Бид гол усны хагалбар сав газруудын ялгааг анхаарч, тус бүрийн түвшинд болон популяцийн түвшинд генетикийн олон янз байдалд үнэлгээ хийсэн. Генетик дээжийг тодорхойлохын тулд неутрал болон дасан зохицох боломжтой генетик хувилбаруудыг ялгасан. Энэхүү популяци хоорондын ялгаа ямар хэмжээгээр өмнө хийгдсэн

ангиллууд болон орон нутгийн байгаль орчны нөхцөлд дасан зохицох чадварт хэр зэрэг нийцэж буйг судлах боломжийг бидэнд олгосон. Популяци хоорондын генетик хамаарлыг харьцуулахын тулд дасан зохицох болон неутрал маркер дээр суурилсан шинжилгээг зэрэгцүүлэн ашигласан. Эцэст нь, бид зорилтот статистик тестийг ашиглан популяцийн дундах боломжит генетикийн холилдсон байдал болон генетик ялгааг гол мөрний системийн дагуух байршлын хооронд дахь зайгаар тайлбарлаж болох цар хүрээг судалсан.

Үр дүн

Судалгааны явцад хоёр Illumina дарааллын сангаас нийт 500 сая гаруй тэгш тоогоор төгссөн, 150 сангийн урттай ДНХ-ийн хариуг (богино ДНХ-ийн дараалал) гаргасан. Чанарын хяналтыг хийж ялгасны дараа гарсан үр дүнгийн 97 орчим хувь нь хадгалагдан үлдсэн нь дарааллын маш сайн чанарыг харуулж байна. Дунджаар нэг дээж 4 сая уншигдсан. Уншигдсан өгөгдлийн дийлэнх хэсгийг амжилттай нэгтгэж болох хамгийн ойр төрөл зүйлийн загас болох галоца (Huchо huchо) загасны геномын лавлагаатай харьцуулсан. ПГУ-ын (PCR) давхардлыг арилгасны дараа дээжийн дундаж геномын хамрах хүрээ 10-17 дахин их байсан нь генетикийн өөрчлөлтийг найдвартай тодорхойлох хангалттай нарийвчлалыг хангасан. Хамрах хүрээ хэтэрхий өргөн хоёр дээжийг цаашдын шинжилгээнээс хассан. Геномын хувилбаруудыг тодорхойлох явцад бид ойролцоогоор

⁶ Szatmári, L., T. Cserkés, L. Laczkó, et al. 2021. „A comparison of microsatellites and genome-wide SNPs for the detection of admixture brings the first molecular evidence for hybridization between *Mustela eversmanii* and *M. putorius* (Mustelidae, Carnivora).” *Evolutionary Applications* 14, no. 9: 2286-2304. <https://onlinelibrary.wiley.com/doi/abs/10.1111/eva.13291>

265 мянган SNP илрүүлсэн. Чанартай нарийн шинжилгээ хийсний дараа эдгээрийг ойролцоогоор 36 мянган SNP-ийн найдвартай мэдээллийн багц болгон бууруулсан бөгөөд энэ нь цаашдын бүх популяцийн генетикийн шинжилгээний үндэс болсон. Үүний хүрээнд бид дасан зохицох ач холбогдолтой статистик аргуудыг ашиглан ойролцоогоор 2,000 SNP-ийг тодорхойлсон бол үлдсэн 34,000 гаруй SNP-ийг саармаг генетик хувилбар гэж үзсэн. Сибирийн тул загас одоогоор бүрэн судлагдсан лавлагаа геномгүй тул дасан зохицох байршлын функциональ ач холбогдлыг үнэн зөв тайлбарлах боломжгүй байв. Гэсэн хэдий ч мэдээллийн сангийн багцын хэмжээ, чанар нь тухайн зүйлийн генетикийн бүтэц дасан зохицох хэв маягийг нарийвчилсан, геномын хэмжээнд судлах боломжийг олгосон. Популяци хоорондын удамшлын холбоонд хийсэн дүн шинжилгээгээр Сибирийн тул загас нь Монгол Улсын нутаг дэвсгэрт Номхон далай, Хойд мөсөн далайн сав газартай холбогдож болох хоёр гүн гүнзгий хувьслын нэгжтэй болохыг тодорхой харуулсан. (2B. Зураг). Эдгээр хоёр нэгжийн генетикийн тусгаарлалт нь ач холбогдолтой бөгөөд ашигласан бүх шинжилгээнд тууштай харагдаж байна. Хойд мөсөн далайн усны хагалбар сав газраас нэмэлт, тодорхой ялгагдах генетикийн хэв маягийг ажиглаж болно. Сэлэнгэ мөрний сав газар болон Бага Енисейн сав газрын популяци нь тусдаа хувьслын удам угсаа үүсгэдэг бол Ангарын сав газрын популяци нь шилжилтийн, холимог генетик шинж чанартай байдаг. Үр дүнгээс харахад, Ангарын сав газрын зарим популяци харьцангуй саяхан олон чиглэлээс суурьшсан нь холимог генетикийн найрлагад хүргэсэн. Дасан зохицох

чадвартай генетик хувилбаруудын хувьд генетикийн ялгааны зэрэг нь хүчтэй болохыг батласан. (2A. зураг). Эдгээр дасан зохицох байршлууд нь Хойд мөсөн далайн сав газрын популяцийг голын өөр өөр сав газрын дагуу хуваадаг байсан бол төвийг сахисан генетикийн өөрчлөлт нь үндсэндээ хоёр том усны сав газрын ялгааг тусгасан байдаг. Энэ нь орон нутгийн дасан зохицол популяцийн генетик бүтцийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг харуулж байна. Ялангуяа Бага Енисейн сав газарт. Популяцийн бүтцийн судалгаанд үндэслэн хамгийн дээд шатлалын түвшинд гурван үндсэн генетик нэгжийг ялгах боломжтой: Үүнд: Номхон далайн сав газар, Сэлэнгийн сав газар, Бага Енисейн сав газрын популяци. Ангарын сав газрын популяци Сэлэнгийн сав газар, Бага Енисейн сав газрын популяци дунд байдаг бөгөөд хоёулантай нь генетик холбоог үзүүлдэг. Генетикийн олон янз байдлын түвшин нь тухайн хоёр гол мөрний сав газартай томоохон ялгаатай байдлыг харуулдаг. Номхон далайн сав газрын популяциудын удамшлын олон янз байдал мэдэгдэхүйц өндөр байсан бол Хойд мөсөн далайн сав газрын популяциуд удамшлын олон янз байдал багатай байсан нь байгалийн эмзэг байдал нэмэгдэж, хамгаалах шаардлагатайг харуулж байна. Шинжилгээнүүд нь Хойд мөсөн далайн сав газрын генетикийн ялгааг гол мөрнүүдийн усны системийн хоорондох газарзүйн зайгаар (өөрөөр хэлбэл, “алслагдмал тусгаарлагдсан” “isolation-by-distance” бүтэцтэй) хэсэгчлэн тайлбарлаж болох тодорхой нотолгоог өгсөн. Энэ хэв маяг нь Сэлэнгэ, Бага Енисейн сав газрын популяцийн дунд илүү тод ажиглагдсан нь хоорондоо

алслагдмал оршдог тул тусгаарлагдмал байдлыг харуулж байна.

Ерөнхийдөө бидний судалгааны үр дүнгээс харахад Сибирийн тул загасны монгол популяци нь өндөр бүтэцтэй, удамшлын олон янз байдал жигд бус тархсан, дасан зохицох генетикийн ялгаа нь популяцийг тусгаарлахад гол үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр үр дүнгүүд нь тухайн популяцийг ирээдүйд шинжлэх ухааны үндэслэлтэй хамгаалж, удирдлага менежментийн стратеги боловсруулахад шууд ашиглах боломжтой юм.

Хэлэлцүүлэг

Сибирийн тул загас нь Монгол орны цэнгэг усны экосистемд нэн чухал махчин загас бөгөөд гол мөрний системийн экологийн тэнцвэрийг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Ташрамд дурдахад, энэ зүйл нь Монгол орны спорт чөлөөт загасчлалын голлох зорилтот загасны нэг бөгөөд загасны нөөцөд хүн төрөлхтний үзүүлж буй нөлөөлөл нэмэгдэж байгааг харгалзан хамгаалал, менежментийн үүднээс онцгой анхаарал хандуулах ёстой.

Бидний судалгаагаар тул загасны монгол нутаг дахь тархац нь Номхон далай, Хойд мөсөн далайн сав газартай холбоотой хоёр гүнзгий ялгаатай эволюцийн нэгж байгааг баталсан. (2. зураг). Энэхүү ялгаа нь эволюцийн урт удаан түүхтэй бөгөөд тухайн бүс нутгийн геологи, мөстлөгийн үйл явцтай холбоотой юм. Хойд мөсөн далайн сав газарт тэр дундаа Бага Енисейн сав популяцийн генетикийн тод ялгаа нь онцгой анхаарал татаж байна. Өмнөх

судалгаанууд бага нарийвчлалтай генетик маркерууд эсвэл түүвэрлэлтийн хангалтгүй байдлаас улбаалж үүнийг тодорхойлж чадаагүй юм. Бидний хийсэн судалгааны үр дүнд үндэслэн Бага Енисейн сав газрын тул загасыг бие даасан хувьслын нэгж гэж тайлбарлаж болно. Үүний эсрэгээр, Сэлэнгийн сав газарт генетикийн хуваагдал нь хамаагүй бага бөгөөд энэ нь тухайн зүйлийн идэвхтэй шилжилт хөдөлгөөн, урт наслалттай нийцэж байна: Голын систем дэх генетикийн ялгаа нь илүү дунд зэрэг бөгөөд нарийн, орон нутгийн үйл явцаар тайлбарлагддаг.

Ангарын сав газрын популяци нь түр зуурын, холимог генетик шинж чанартай байдаг. Үүнээс үзэхэд, энэ нутагт харьцангуй сүүлд олон талаас суурьшсан байж болох бөгөөд энэ нь тухайн бүс нутгийн гидрографи, геологийн өнгөрсөн үетэй холбоотой байж болох юм. Удамшлын зүй тогтол дээр үндэслэн, өмнө нь Зүүн Саяны нурууны бүс нутагт голын өөр өөр системүүдийн хооронд үе үе дамжин өнгөрөх усны хагалбарын өөрчлөлтүүд гарч байсан байх магадлалтай юм. Эндээс үзэхэд, тухайн загасыг хамгаалахыг чухалчлан удирдлага менежментийн нэгжийг тодорхойлохдоо зөвхөн өнөөгийн гидрографийн хил хязгаарт найдах нь хангалтгүй. Учир нь өнөөгийн газар зүйн нөхцөл байдал нь хувьслын өнгөрсөн үеийг тэр бүр үнэн зөв тусгадаггүй. Үүнд Байгаль нуурын үүрэг онцгой бөгөөд анхаарал хандуулах ёстой юм. Хэдийгээр Байгаль нуур нь дэлхийн хамгийн эртний цэнгэг устай нууруудын нэг боловч одоогийн усны менежментийн систем нь геологийн хувьд залуу бөгөөд тул

загас энэ газрыг харьцангуй хурдан колоничлох магадлалтай.⁷ Бидний судалгааны үр дүнгээс үзэхэд, нуур нь байнгын, нэвтэршгүй генетик саад болж байгаагүй: Тул загас шилжилт хөдөлгөөн ихтэй тул нуурын хоёр эргийн хооронд түр зуурын генийн холбоо үүссэн байж магадгүй юм. Энэ нь бусад хөдөлгөөн багатай голын загасны төрөл зүйлийн хувьд төсөөлж байснаас өөр юм.⁸

Генетикийн олон янз байдлын үүднээс авч үзэхэд чухал ач холбогдолтой зүйл бол хоёр сав газрын усны талбайн хооронд мэдэгдэхүйц ялгаа байгаа явдал юм: Номхон далайн сав газрын популяци илүү их генетикийн олон янз байдалтай байдаг бол Хойд мөсөн далайн ай савд амьдардаг популяциуд генетикийн олон янз байдал багатай байдаг. Гетерозигот байдал нь генетикийн олон янз байдлын үндсэн үзүүлэлт бөгөөд энэ нь популяцийн урт хугацааны дасан зохицох чадвар, оршин тогтнох чадвартай холбоотой байж болох тул чухал юм. Хэдийгээр ийм геномын тооцоог бусад төрөл зүйл эсвэл бусад судалгаатай харьцуулах боломж хязгаарлагдмал боловч энэ загвар нь төрөл зүйлийн доторх тодорхой мэдээллийг агуулдаг: Генетикийн олон янз байдал багатай популяциуд илүү эмзэг байж болох бөгөөд зорилтот зорилгод хүрэх нь илүү төвөгтэй байж болох юм. Сэлэнгийн сав газарт ажиглагдаж буй

зарим шинж тэмдгүүд нь сүүлийн үед нөөцийн бууралттай нийцэж байгаа бөгөөд үүний нэг шалтгаан нь хэт ашиглалт байж болох ч үүнийг нарийн үнэлэхэд чиглэсэн, нарийвчилсан загас агнуурын мэдээлэл шаардлагатай болно. Судалгааны хамгийн чухал сургамжуудын нэг бол “неутрал” болон “дасан зохицох” генетикийн ялгаа нь ижил дүр зургийг үзүүлдэггүй явдал юм. (2.зураг). Неутрал генетик өөрчлөлт нь гол төлөв хоёр том усны хагалбарын тусгаарлалтыг тусгадаг бол дасан зохицох (байгаль орчинд дасан зохицохтой холбоотой) хувилбарууд нь сав газрын хязгаарлагдмал, илүү хурц хуваагдлыг харуулдаг. Энэ нь монгол орны тул загасны популяцийн бүтцийг бий болгоход орон нутгийн дасан зохицол нь гол үүргийг гүйцэтгэж болохыг харуулж байгаа бөгөөд үүнийг сонгодог, бага нягтралтай генетикийн маркерыг ашиглан ийм тодорхой илрүүлж чадаагүй юм. Бага Енисейн сав газрын популяцийн дунд хүчтэй дасан зохицол, ялгаатай байдал ажиглагдаж байгаа нь энэ популяци нь тухайн нутгийн байгаль орчны нөхцөл байдалд дасан зохицсон байж болзошгүйг харуулж байна.

Эндээс байгаль хамгаалах дараах практик дүгнэлтэд хүрч байна: Бага Енисей, Сэлэнгийн сав газрын популяцийн бүлгүүдийг эвцэлдүүлэх нь эрсдэлтэй байдаг учир нь өөр өөр дасан зохицох үндэс суурьтай популяциудыг

⁷ Mats, V. D., and T. I. Perepelova. 2011. “A new perspective on evolution of the Baikal Rift.” *Geoscience Frontiers* 2, no. 3: 349-365. <https://www.sciencedirect.com/science/article/pii/S1674987111000594>

⁸ Koskinen, M. T., I. Knizhin, C. R. Primmer, et al. 2002. “Mitochondrial and nuclear DNA phylogeography of *Thymallus* spp. (grayling) provides evidence of ice-age mediated environmental perturbations in the world’s oldest body of fresh water, Lake Baikal.” *Molecular Ecology* 11, no. 12: 2599-2611. <https://onlinelibrary.wiley.com/doi/abs/10.1046/j.1365-294X.2002.01642.x>

нийлүүлэх нь зарим тохиолдолд орон нутгийн дасан зохицох чадвар суларч, нөхөн үржихүйн амжилт буурахад хүргэдэг.

Генетикийг хамгаалж “аврах”-ад зохих ёсоор болгоомжтой байж амжилтанд хүрч болох жишээнүүд байдаг ч ерөнхий зарчмын хувьд өөр өөр популяциудыг зохиомлоор эвцэлдүүлэхээс болгоомжлох нь үндэслэлтэй юм. Сонирхолтой нь, Номхон далайн сав газарт популяцийн ялгаа илүү онцгой байгаа нь тухайн нутгийн экологийн нөхцөлтэй холбоотой дасан зохицох ялгаа нь популяцийг илүү хүчтэй ялгаж болохыг харуулж байна. Ерөнхийдөө энэхүү тул загасыг хамгаалах, менежментийн стратеги нь газарзүйн тусгаарлалтаас гадна дасан зохицох чадварын ялгааг харгалзан үзэх ёстойг харуулж байна.

Дүгнэлт

Хулдын овгийг удирдах, хамгаалахад дасан зохицох генетикийн өөрчлөлтийн ач холбогдлыг судалгаанд эртнээс хүлээн зөвшөөрдөг⁹. Энэхүү судалгаанд бид Бага Енисейн сав газарт хязгаарлагдах Монголын Сибирийн тул загасны популяцид нэмэлт генетикийн кластер байгааг тодорхойлсон бөгөөд тэдгээрийн тусгаарлалт нь дасан зохицох генетикийн ялгаатай байдлаас үүдэлтэй хэмээн таамаглаж байна.

Дасан зохицох чадварын ялгаа нь удамшлын хямрал (“outbreeding depression”) хэмээн нэрлэгддэг үндсэн шалтгаануудын нэг байж болох тул Сибирийн тул загасыг урт хугацаанд зохистой, тогтвортой хамгаалах менежментийн нэгжийг тодорхойлоход энэхүү генетикийн нэгжийг таних нь чухал юм.¹⁰ Бидний судалгааны үр дүн нь Монгол дахь популяцийн бөөгнөрөл дэх цусны нөхөн сэргэлт муудаж болзошгүйг нотолсон эрсдлийн үнэлгээг өгсөн. Тиймээс бидний тодорхойлсон генетикийн кластерийг Монголд аль хэдийн хүлээн зөвшөөрөгдсөн хувьслын чухал нэгжид нэмж оруулах нь зөв юм. Эдгээр нэгжийг удамшлын эрсдэлтэй холилдох эрсдэлгүйгээр хамгаалах, менежментийн үүднээс нэг популяци болгон удирдах боломжгүй юм. Бидний судалгаагаар тухайн гол мөрний сав газрын дээд хэсэгт амьдардаг популяци нь гол мөрний системийн доод хэсэгт амьдардаг популяцитай генетикийн хувьд өөр усны хагалбар дахь популяцитай илүү нягт холбоотой байдаг жишээг мөн илрүүлсэн.

Энэ хэв маягийг сүүлчийн мөстлөгийн үед үүссэн гидрографийн өөрчлөлтөөр тайлбарладаг. Ийм тохиолдлууд нь зөвхөн гидрографийн үндэслэлд суурилсан генетикийн нэгжийн автомат тэмдэглэгээ нь тухайн зүйлийн үр дүнтэй менежментэд үргэлж тохирдоггүй гэдгийг тодорхой харуулж байна.

⁹ Taylor, E. B. 1991. “A review of local adaptation in Salmonidae, with particular reference to Pacific and Atlantic salmon.” *Aquaculture* 98, no. 1: 185-207. <https://www.sciencedirect.com/science/article/pii/0044848691903831>

¹⁰ Weeks, A. R., C. M. Sgro, A. G. Young, et al. 2011. “Assessing the benefits and risks of translocations in changing environments: a genetic perspective.” *Evolutionary Applications* 4, no. 6: 709-725. <https://onlinelibrary.wiley.com/doi/abs/10.1111/j.1752-4571.2011.00192.x>

Ерөнхийдөө бидний судалгаа нь өнөө үед байгаль хамгаалахад геномын судалгааг ашиглах нь зайлшгүй чухал гэдгийг онцолж байна¹¹. Өнөөгийн нарийвчлалтай генетик өгөгдөлүүд нь хувьслын болон дасан зохицох хоёр талыг харгалзан менежментийн нэгжийг илүү нарийвчлалтай тодорхойлох боломжийг олгодог бөгөөд энэ нь Монголд Сибирийн тул загасыг урт хугацаанд оршин тогтноход чухал ач холбогдолтой юм.

Талархал

Энэхүү судалгаа нь Унгар хэл рүү орчуулагдсан Олон улсын өргөн хүрээтэй хэвлэлийн товчилсон хувилбар юм. Судалгаанд оролцон хамтран ажилласан дараах хүмүүст талархаж байгаагаа илэрхийлье: Батсүхийн Цэрэндулам, Сотмари Лаёш, Дечингаваа Цэнд-Аюуш, В.Суханова Любовь, Е.Богданов Бактиар Bakhtiar, Бямбадашийн Сод-Эрдэнэ, Чулуунбаатарын Батцэцэг, Чононбаатар Аюушсүрэн, Ганбилэг Ганхуяг.


Мөн хээрийн дээж авахад тусалсан судлаачдад талархал илэрхийлье: Энхтайваны Молор-Эрдэнэ, Диймажавын Эрдэнэбаатар, Зундуйбаатарын Өнөдбаясгалан, Баттулгын Мөнхзориг, Цограшын Дэמידсэрээтэр. Энэхүү судалгааг Монголын Шинжлэх Ухааны Академийн Технологийн Сан (ШуСс-2020/22), Унгар, Монголын Шинжлэх Ухааны Академийн хамтын ажиллагааны мобилити тэтгэлэг (тэтгэлэгийн дугаар: НКМ 2024-26), Унгарын Үндэсний судалгаа, хөгжил, инновацийн сангийн ОТКА FK буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хүрээнд (ОТКА FK137962) санхүүжүүлсэн. Улаанбаатар дахь Унгарын Элчин сайдын яам болон Элчин сайд (Др.Обрущанский Борбала)-д байнгын дэмжлэг туслалцаа үзүүлсэнд онцгой талархал илэрхийлье. Мөн ГХЯ-ны Соёл, шинжлэх ухааны дипломатын хэлтсээс Монголд дээж авахад дэмжлэг үзүүлсэнд талархаж байна.

11 Funk, W. C., J. K. McKay, P. A. Hohenlohe, et al. 2012. "Harnessing genomics for delineating conservation units." *Trends in Ecology & Evolution* 27, no. 9: 489-496. <https://www.sciencedirect.com/science/article/pii/S0169534712001279>

Ábrák



1. зураг: Судалгаанд хамрагдсан популяцийн гарал үүслийн ойролцоох газрыг улаан цэгээр харуулсан судалгааны газрын зураг.



2. зураг: (A) дасан зохицох боломжтой хувьсах чанар ба (B) нейтрал (саармаг) генетикийн хувьсах чанарт үндэслэн судлагдсан популяцийн генетикийн ялгаа. Кластер диаграммыг Уэйр, Кокерхэм нарын популяци хоорондын залруулсан Райтын генетикийн ялгагч хэмжүүр (F_{ST}) дээр үндэслэн UPGMA аргыг ашиглан боловсруулсан.

МОНГОЛ ОРНЫ ОЙН ШИЙХНҮҮХЭЙН (*ANTHUS TRIVIALIS*, LINNAEUS, 1758) ФИЛОГЕНЕТИКИЙН СУДАЛГАА

Түмэндэмбэрэлийн Өлзийсайхан¹, Бямбадашийн Сод-Эрдэнэ¹, Шрамко Габор^{2,3}, Батсүхийн Цэрэндулам^{1*}.

Хураангуй:

Бидний зорилго бол Монгол Ойн Шийхнүүхэй (*Anthus trivialis*)-ийн генетикийн олон янз байдлыг тодорхойлж, филогенетик модыг бүтээж аль дэд зүйл вэ гэдгийг тогтоох явдал байв. Бид энэхүү судалгааг нийт Монголын 21, Унгарын 6 Ойн шийхнүүхэйн дээжийг цуглуулан, *Cyt-b* генийн 469хн, *D-loop* маркерийн 554хн, *ND2* генийн 846хн фрагментүүд буюу митохондрийн ДНХ-ийн нийт 2307хн урттай маркер генүүдийн хэсэгчилсэн дарааллыг ашиглан хийсэн. Нд утга нь бусад генийн хэсгүүдээс бүх популяцид *ND2* (0.96) хамгийн өндөр байсан бол Монголын популяцид 0.94 байв. Түүнчлэн нуклеотидын олон янз байдал (Pi) нийт популяцид 0,00234-0,004 хооронд хэлбэлзэж байсан бол Монголын популяцид 0,00183-0,00376 хооронд хэлбэлзэж байна. мтДНХ-ийн хосолсон дараалалд үндэслэсэн байгуулсан филогенетик мод нь хоёр клад бүлгийг илрүүлсэн ч Монголын Ховд аймгийн Ойн Шийхнүүхэйн популяци нь бусад популяцитай

генетикийн солилцоонд ордог, *Anthus trivialis trivialis* дэд зүйлд хамаарч байгаа болохыг харуулав.

Түлхүүр үг: популяцийн генетик, гаплотип, *Anthus trivialis*, филогенетик, *Cyt-b*, *ND2*, *D-loop*, *COI*.

Удиртгал

Ойн шийхнүүхэй (*Anthus trivialis*, Linnaeus, 1758) бол *Motacillidae* овогт багтдаг Монгол орны улаан номд орсон ховор статустай нүүдлийн шувуу юм. Энэ зүйл шувуу Зүүн өмнөд Азийн орнуудад агнуурт ихээхэн өртдөг. Сүүлийн жилүүдэд Төв Азийн популяци мэдэгдэхүйц буурч, Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооны (IUCN) 2023 оны үнэлгээгээр Дэлхий даяар буурч буй популяцийн ангилалд багтах болсон [1]. *Anthus* төрөл нь *Motacillidae* овогт багтдаг бөгөөд 43 зүйлээс бүрддэг. *Motacillidae* овог нь хамгийн өргөн тархсан, төрөл зүйлээр баялаг овгийн нэг гэж хүлээн зөвшөөрөгдсөн [2, 3]. *Anthus* төрөл нь янз бүрийн шувуудын

¹ Генетикийн лаборатори, Биологийн Хүрээлэн, Монголын Шинжлэх Ухааны Академи, УБ-13330, Монгол.

² Эволюцийн геномиксийн судалгааны баг, Ботаникийн тэнхим, Дэбрэцэний Их Сургууль, Дэбрэцэн

³ HUN-REN-UD Хамгааллын Биологийн судалгааны баг, Эгетэм тер, Дэбрэцэн-4032, Унгар

* Холбоо барих зохиогч: tserendulamb@mas.ac.mn, <https://orcid.org/0000-0002-8409-0968>

бүлгийг хамардаг бөгөөд тэдгээрийн гадаад шинж чанарын төсөөтэй байдал нь удамшлын нарийн холбоог тогтооход хүндрэл учруулдаг [4].

Шувуудын филогеографийн анхны судалгаа нь митохондрийн ДНХ (мтДНХ) [6] дээр үндэслэн, түүнийг генетик болон филогеографийн судалгаанд өргөнөөр ашиглах болсон нь түүний хувьслын өндөр эрчимтэй, ДНХ-ийн задрал бага байдагтай холбоотой [7]. Монголд Ойн Шийхнүүхэйн ямар дэд зүйл тархаж байгааг тогтоохын тулд генетикийн судалгаа хийх шаардлагатай байна.

Энэ судалгаанд бид Монголын ойн шийхнүүхэйн мтДНХ-ийн тодорхой генүүдийн нуклеотидын дарааллыг ашиглан дэлхийн бусад популяцитай харьцуулсан генетикийн шинжилгээг хийж, дэд зүйлийн түвшинд тодорхойлохыг зорьсон бөгөөд ингэснээр ойн шийхнүүхэйн популяцийн генетикийн талаар үнэ цэнэтэй ойлголт өгөх болно.

МАТЕРИАЛ БА АРГА ЗҮЙ

Дээж ба мтДНХ маркеруудын судалгаа. Ойн шийхнүүхэй Монголын улаан номонд орсон тул дээж авах бүх зөвшөөрлийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас авсан. Бид Баруун Монголын Ховд аймгаас *Anthus trivialis*-ийн 21 бодгаль амьтны эдийн дээж авсан. Булчингийн эдээс нийт геномын ДНХ-ийг үйлдвэрлэгчийн протоколын дагуу ДНХ ялгах цомог (*Zanaspex*) ашиглан ялгасан. Митохондрийн цитохром b (*Cyt-b*), NADH дегидрогеназын дэд нэгж 2 (*ND2*), D-гөгцөө, цитохромын оксидазын дэд нэгж 1 (*COI*) генүүдийн хэсэгчилсэн дарааллыг олшруулахын

тулд бид Полимеразын гинжин урвал (ПГУ) ашигласан. *COI*-ийн хувьд форвард 5'-GCA TGA GCA GGG ATA GTG GGT A-3' ба урвуу 5'-GTG ACC GAA GAA TCA GAA GAG GT-3' праймерууд, *Cyt-b*-ийн праймер хосууд нь L15086 (5'-CTC CGT AGC TCA CAT ATG CCG AG-3') ба H15853 (5'-GGC GGA AGG TTA TTG ATC GCA G-3') байв. *ND2*-ийн хувьд праймер хосууд нь 5'-GCA AAA CTA ATC TTC GTC ACC-3' ба 5'-ATA GGG GCG ATT GGT AGA AG-3' байсан бол D-loop-ийн хувьд бид 5'-TAA CTAT GCAT TAC ACT CTC TGC C-3' ба 5'-GAA GGG CTT ATT GAA GAG ACG C-3'-г ашигласан. ПГУ-ын нөхцлүүд бүх генийн хувьд ижил байсан бөгөөд 94 °C-т 3 минутын турш урьдчилан денатураци хийх, дараа нь 94 °C-т 30 секунд, 60 °C-д 1 минут, 72 °C-т 1 минутын турш 40 цикл, дээр нь 72 °C-д эцсийн уртсах шатыг 5 минут хийсэн. ПГУ-ын дараа бүтээгдэхүүнийг 1% агароз гель электрофорезоор шалгаж, ABI3730XL (Macrogen Inc.) ашиглан нуклеотидын дарааллыг тогтоолгов. Уншуулсан ДНХ дарааллыг Seqman II (DNASTAR) ба MEGA-X [9] дахь ClustalW [8] програмууд дээр шалгаж алайнмэнт хийсэн. Псевдоген байхгүй эсэхийг баталгаажуулахын тулд бид сээр нуруутан амьтдын митохондрийн кодчилолын хүснэгтийг дагаж митохондрийн генийн зогсох кодон ба инделийг сайтар судалж үзсэн. Нэмж дурдахад бид харьцуулсан дүн шинжилгээ хийхийн тулд GenBank-аас *COI* -д (GU571734, GU571733, GU571261, GU571260, GQ481368, GQ481370, GQ481367, GQ481365, K29), *ND2*-д (GU816850, KU859174, KU859173, KU859172, KU859171, KU859170, KU859169, KU859167, KU859166, KU859165, KU859166),

түүнчлэн *D-loop*-д (OQ344431, OQ344432) болон *Cyt-b* хувьд (U46775, AY228048) хэсэгчилсэн дарааллыг татаж авсан.

мтДНХ -ийн Нуклеотидын полиморфизм ба филогенетик шинжилгээ. Бид Монголын болон бусад ойн шийхнүүхэйн популяцийн хувьд segregating сайтын тоо (S), гаплотипийн тоо (H), гаплотипийн олон янз байдал (Hd), нуклеотидын олон янз байдал (Pi) зэргийг болон Fu ба Li's D [11] болон Тажимагийн D [12] параметруудийг DnaSP 5.0 [10] ашиглан хийсэн. Haplotype сүлжээний газрын зургийг TCS Popart v.1.7[13] ашиглан хийсэн.

Бид BEASTv 1.10.4 [14]-ийг популяци хоорондын филогенетик харилцааг тодруулахад ашигласан. “Дундаж өндөр” шалгуурыг ашиглан модыг нэгтгэн дүгнэхийн тулд бид BEAST багцын TREEANNOTATOR

1.8-ыг ашигласан [15]. Филогенетикийн модыг FigTree v1.4.2 (<http://tree.bio.ed.ac.uk/software/figtree/>) ашиглан дүрслэн харуулсан.

ҮР ДҮН

Генетикийн өөрчлөлт

Бид Монгол (21), Унгар (6)-ын *Anthus trivialis* популяциас нийт 27 бодгальд *COI* 469хн, *Cyt-b* 435хн, *D-loop* 554хн, 846хн *ND2* зэрэг митохондрийн ДНХ-ийн 2307 хн урттай хэсгүүдийг олшруулж судалсан. Гаплотипийн олон янз байдал (Hd) нь бусад генүүдээс *ND2* (0.96) бүх популяцид хамгийн өндөр байсан бол Монголын популяцид 0.94 байв. Нуклеотидын олон янз байдал (Pi) бүх популяцид 0.00234-0.004 хооронд хэлбэлзэж байсан бол Монголын хүн амд 0.00183-0.00376 хооронд хэлбэлзэж байна (Хүснэгт-1).

	<i>COI</i>		<i>Cyt-b</i>		<i>D-loop</i>		<i>ND2</i>	
	All	MGL	All	MGL	All	MGL	All	MGL
Урт (хн)	469		435		554		849	
N	35	21	28	21	29	21	40	21
Nhap	9	6	13	8	14	11	26	14
Hd	0.644	0.5325	0.7196	0.5667	0.8571	0.8143	0.9679	0.9474
Pi	0.0026	0.00183	0.02879	0.00234	0.004	0.0041	0.00376	0.0035
s	9	6	67	9	13	12	35	18
Fu ба Li's F	-2.588*	0.0018	0.70145	-2.99641	-2.567	-2.077	-3.99989	-2.62
Tajima's D	-1.505	-1.4851	-1.19957	-1.99058*	-1.294	-1.106	-2.13307**	-1.623


Хүснэгт-1. Нуклеотидын полиморфизм ба Tree Pipit-ийн мтДНХ генийн саармаг байдлын туршилтын үр дүн. All-Нийт популяци, MGL-Монголын популяци. N, дээжийн тоо; S, segregating сайтуудын тоо; Nhap, гаплотипийн тоо; Hd, гаплотипийн олон янз байдал; Фүгийн FS, Фүгийн FS тестийн статистик (*P < 0.01); Tajima's D, Tajima's D- тестийн статистик (*P < 0.05)

COI генийн фрагментийн анализаар нийт 9 гаплотипийг тодорхойлсон. Гаплотип-1 ба 2 нь бүх популяцид нийтлэг харин Монголын популяцид нийт 6 гаплотип илэрсэн бөгөөд тэдгээрийн дотроос 6, 7, 8-р гаплотипууд өвөрмөц байв. Гаплотип-4 ба 9 нь Европын популяцид, гаплотип 3 нь Орос-Казахстаны популяцид өвөрмөц байсан. *Cyt-b* генийн фрагментийн хувьд бид нийт 13 гаплотип, Монголын популяцид 8 гаплотип илрүүлсэн. Эдгээр гаплотипууд нь газарзүйн тодорхой бүс нутагт харгалзах хоёр үндсэн гаплогруппт хуваагдсан. Гаплотип-1 нь бүх популяцид нийтлэг бол бусад гаплотипууд нь гаплогрупп тус бүрт өвөрмөц байв. D-гогцооны фрагментийн хувьд бид нийт 14 гаплотип, Монголын популяцид 11 гаплотип илрүүлсэн. Гаплотип-12-14 нь зөвхөн Европын популяцид, Гаплотип-3-11 нь Монголын популяцид өвөрмөц байсан бол гаплотип-1 ба 2 нь бүх популяцид илэрсэн. Мөн *ND2* генийн фрагментийн хувьд бид бусад генүүдтэй харьцуулахад нийт 26 гаплотипийг тодорхойлсон. *ND2* генийн гаплотипуудын хувьд тусдаа гаплогруппууд үүсгээгүй бөгөөд нийт газарзүйн тархалтын талбайд тодорхой ялгаа байгаагүй. Түүнчлэн, бид GenBank-д илрүүлсэн бүх гаплотип дарааллыг дараах байдлаар бүртгүүлсэн: *COI* (OR787543-OR787558), *Cyt-b* (PP501875-PP501884), *ND2* (PP501885-PP501904), *D-loop* (PP501905-PP501921).

Филогенетик бүтэц

Ойн шийхнүүхэйн мтДНХ генүүдийн нэгтгэсэн дарааллаар байгуулсан филогенетик мод нь Bayesian Inference (BI) анализаар хоёр үндсэн бүлгийг илрүүлсэн. Бид *Anthus hodgsoni* (KX189345, KJ455323, KX189345, KX189345) шувууг тусгаар зүйл болгон харьцуулах зорилгоор сонгосон. Уг үүссэн модны голын мөчрийн магадлалын утгыг дэмжих зангилаа нь 0.65 байна. Энэ нь хоёр мөчир хоорондоо холбоотойг дэмжих утгыг илэрхийлнэ. Монголын дээж Швед, Орос, Норвеги зэрэг улсын ойн шийхнүүхэйн популяцитай нэг кластерт орсон бол манай судалгаанд ашигласан Унгараас цуглуулсан ойн шийхнүүхэйн дээж нь Монголын популяциас тусдаа кластер үүсгэсэн боловч Орос, Норвеги, Шведийн популяцитай хамт нэг кластер үүсгэсэн (Зураг 1).

Энэхүү судалгааны зорилго нь Унгарын популяцийг оролцуулан 27 дээжинд мтДНХ -ийн *COI*, *Cyt-b*, *D-Loop*, *ND2* генийг нэгтгэн судалж, дэлхийн GeneBank-ийн мэдээлэлтэй харьцуулан Монгол руу нүүдэллэн ирж буй ойн шийхнүүхэйг дэд зүйлийн түвшинд тодорхойлоход оршиж байв. Филогенетикийн модны шинжилгээний үр дүнд, Монгол дахь ойн шийхнүүхэй нь *Anthus trivialis trivialis* дэд зүйлтэй (KF946594.1) 100%, *Anthus hodgsoni* зүйлтэй 96.4% таарч байгааг харууллаа. Энэхүү дүнг судлаачдын өмнө нь санал болгосны дагуу газарзүйн тархалт, зүйлийн алсын зайн нүүдлийн хэв маяг зэрэг экологийн янз бүрийн хүчин зүйлтэй холбон тайлбарлаж болно [16].



Зураг-1. Ойн шийхнүүхэйн мтДНХ-ийн генүүд (*COI*, *Cyt-b*, *D-loop*, *ND2*) дээр суурилсан филогенетик мод. Тайлбар: *An.t_1-21*- Монгол *Anthus trivialis* дээж (дугаар), *SWD*-Швед, *KAZ*-Казахстан, *NOR*-Норвеги, *Орос-Орос*, *NED*-Нидерланд, *ГЕР*-Герман. Зангилаа дэмжих утга нь 0.65 байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Anthus-ын төрлийн шувуудыг ялгахын тулд мтДНХ-ийн *Cyt-b* маркерийг ашигласан хувьслын филогенетикийн хэд хэдэн судалгаа байдаг [5, 17]. *Anthus*-ын төрөл нь өнгө, дуу хоолойн хувьд нэлээд төстэй [18] тул гадаад төрхөөр нь ялгахад хэцүү байдаг. Иймээс бид энэ судалгаагаар Монголоос 21, Унгараас 6 дээжийг мтДНХ-ийн дөрвөн маркерыг нэгтгэн шинжилж, филогенетик модыг байгуулсан. Үүний үр дүнд Монголын *Anthus trivialis* популяци нь Европын популяцитай

ижил дэд зүйлд багтдаг болохыг харуулсан. *Anthus trivialis*-ийн Монгол популяци нь Зүүн Палеарктикийн төрөл зүйлд багтдаг бөгөөд Евразийн өргөн удам популяцийг төлөөлдөг болохыг бид өмнөх бусад судалгаануудтай харьцуулан харлаа [19, 20].

Бидний судалгааны давуу тал нь бидний судалгаанд ашигласан мтДНХ-ийн хэд хэдэн генийн дарааллыг нэгтгэх замаар филогенетик шинжилгээ хийсэнд оршино. Энэ арга нь генийг тусад нь шинжлэхтэй харьцуулахад илүү нарийвчлалтай, найдвартай үр

дүн гаргах боломжтой [21]. Нэмж дурдахад бид өргөн тархсан шувуудын төрөл зүйлийн популяцийн генетикийн судалгаанд өргөн хэрэглэгддэг BEAST програмд суурилсан Bayesian inference (BI) филогенетик аргыг ашигласан [17, 22, 23].

Хэдийгээр бид Монголоос ойн шийхнүүхэйн нэг л популяцийг судалсан ч Унгараас цуглуулсан Европын дээжийг оруулж чадсан. Түүгээр ч зогсохгүй Ази, Европын хэд хэдэн ойн шийхнүүхэйн популяцийн төлөөлөгчдийн геномуудыг харьцуулах зорилгоор NCBI-ээс татаж авсан. *Anthus*-ын төрлийн талаархи ихэнх судалгаанууд нь тэдний гадаад төрх байдал, нүүдлийн хэв маягт анхаарлаа төвлөрүүлдэг [5, 24], ба филогенетикийн цөөн тооны судалгаа байдаг. Иймээс энэ удаагийн судалгаа нь Монголын ойн шийхнүүхэйн анхны филогенетикийн судалгаа юм. *Anthus trivialis*-ийн бусад дэд зүйл Монголд нүүдэллэдэг эсэхийг тодруулахын тулд Монголын бусад ойн шийхнүүхэйн популяциас тархалтын цэгүүдээс илүү олон дээжийг хамруулах нэмэлт судалгаа хийх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Монгол дахь ойн шийхнүүхэйн популяцийн филогенетикийн шинжилгээгээр тусдаа салалт илрээгүй бөгөөд энэ нь Монголын Ховд аймгийн ойн шийхнүүхэйн популяци нь *Anthus trivialis trivialis*-тай нэг дэд зүйл болохыг харуулж байна. Түүнчлэн, уг судалгаагаар Монгол болон бусад популяциудад ажиглагдаж буй 2 нийтлэг гаплотип байгааг тогтоосон нь тэдний дунд генийн урсгал явагдаж байгааг харуулж байна.

Ашигласан материал

- [1] B. International, “BirdLife International (2023) IUCN Red List for birds,” 2023.
- [2] S. Tyler, “Family Motacillidae (pipits and wagtails),” *Handbook of the birds of the world*, vol. 9, pp. 686-786, 2004.
- [3] E. C. Dickinson, N. David, and M. A. Alonso-Zarazaga, “Some comments on Schodde & Bock (2016) on gender agreement,” *Bulletin of the British Ornithologists’ Club*, vol. 137, no. 2, pp. 142-144, 2017.
- [4] B. P. Hall, *The taxonomy and identification of pipits (genus Anthus)*. British Museum (Natural History), 1961.
- [5] G. Voelker, “Molecular evolutionary relationships in the Avian genus *Anthus* (Pipits: Motacillidae),” *Molecular Phylogenetics and Evolution*, vol. 11, no. 1, pp. 84-94, 1999.
- [6] J. Avise, “INTRASPECIFIC PHYLOGEOGRAPHY: The Mitochondrial DNA Bridge Between Population Genetics and Systematics,” 1987.
- [7] S. V. Drovetski, M. Raković, G. Semenov, I. V. Fadeev, and Y. A. Red’kin, “Limited phylogeographic signal in sex-linked and autosomal loci despite geographically, ecologically, and phenotypically concordant structure of mtDNA variation in the Holarctic avian genus *Eremophila*,” *PLoS One*, vol. 9, no. 1, p. e87570, 2014.
- [8] J. D. Thompson, D. G. Higgins, and T. J. Gibson, “CLUSTAL W: improving

- the sensitivity of progressive multiple sequence alignment through sequence weighting, position-specific gap penalties and weight matrix choice,” *Nucleic acids research*, vol. 22, no. 22, pp. 4673-4680, 1994.
- [9] S. Kumar, G. Stecher, M. Li, C. Knyaz, and K. Tamura, “MEGA X: molecular evolutionary genetics analysis across computing platforms,” *Molecular biology and evolution*, vol. 35, no. 6, p. 1547, 2018.
- [10] P. Librado and J. Rozas, “DnaSP v5: a software for comprehensive analysis of DNA polymorphism data,” *Bioinformatics*, vol. 25, no. 11, pp. 1451-1452, 2009.
- [11] Y.-X. Fu, “Statistical tests of neutrality of mutations against population growth, hitchhiking and background selection,” *Genetics*, vol. 147, no. 2, pp. 915-925, 1997.
- [12] F. Tajima, “Statistical method for testing the neutral mutation hypothesis by DNA polymorphism,” *Genetics*, vol. 123, no. 3, pp. 585-595, 1989.
- [13] J. W. Leigh and D. Bryant, “POPART: full-feature software for haplotype network construction,” *Methods in ecology and evolution*, vol. 6, no. 9, pp. 1110-1116, 2015.
- [14] M. A. Suchard, P. Lemey, G. Baele, D. L. Ayres, A. J. Drummond, and A. Rambaut, “Bayesian phylogenetic and phylodynamic data integration using BEAST 1.10,” *Virus Evolution*, vol. 4, no. 1, 2018.
- [15] A. Rambaut and A. Drummond, “TreeAnnotator. Version 1.8, distributed as part of the BEAST Package,” ed, 2010.
- [16] C. Moga, T. Hartel, and K. Öllerer, “Ancient oak wood-pasture as a habitat for the endangered tree pipit *Anthus trivialis*,” *Biologia*, vol. 64, no. 5, pp. 1011-1015, 2009.
- [17] H. V. Norambuena, P. Van Els, C. P. Muñoz-Ramírez, and P. F. Victoriano, “First steps towards assessing the evolutionary history and phylogeography of a widely distributed Neotropical grassland bird (Motacillidae: *Anthus correndera*),” *PeerJ*, vol. 6, p. e5886, 2018.
- [18] P. Doniol-Valcroze, P. Coiffard, P. Alström, M. Robb, P. Dufour, and P.-A. Crochet, “Molecular and acoustic evidence support the species status of *Anthus rubescens rubescens* and *Anthus [rubescens] japonicus* (Passeriformes: Motacillidae),” *Zootaxa*, vol. 5343, no. 2, pp. 173-192, 2023.
- [19] P. Arctander, O. Folmer, and J. FJELDSA, “The phylogenetic relationships of Berthelot’s Pipit *Anthus berthelotii* illustrated by DNA sequence data, with remarks on the genetic distance between Rock and Water Pipits *Anthus spinoletta*,” *Ibis*, vol. 138, no. 2, pp. 263-272, 1996.
- [20] B. Finch et al., “High levels of mitochondrial cytochrome b sequence diversity are present within the *Anthus similis* complex in sub-Saharan Africa,” *Ostrich*, vol. 84, no. 2, pp. 145-151, 2013.
- [21] S. R. Gadagkar, M. S. Rosenberg, and S. Kumar, “Inferring species phylogenies from multiple genes: concatenated sequence tree versus consensus gene tree,” *Journal of Experimental Zoology Part B*:

- Molecular and Developmental Evolution, vol. 304, no. 1, pp. 64-74, 2005.
- [22] P. van Els, H. V. Norambuena, and R. S. Etienne, “From pampa to puna: Biogeography and diversification of a group of Neotropical obligate grassland birds (Anthus: Motacillidae),” vol. 57, ed: Wiley Online Library, 2019, pp. 485-496.
- [23] G. Song et al., “Complete taxon sampling of the avian genus *Pica* (magpies) reveals ancient relictual populations and synchronous Late-Pleistocene demographic expansion across the Northern Hemisphere,” *Journal of Avian Biology*, vol. 49, no. 2, pp. jav-01612, 2018.
- [24] P. Zduniak and R. Yosef, “Migration and staging patterns of the Red-throated (*Anthus cervinus*) and Tree Pipits (*Anthus trivialis*) at the migratory bottleneck of Eilat, Israel,” *Ornis Fennica*, vol. 88, no. 3, pp. 129–137-129–137, 2011.